

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН (ТӨРӨЛЖСӨН) ХУУЛЬ

ЕРӨНХИЙ АНГИ

I ХЭСЭГ. ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН (ТӨРӨЛЖСӨН) ХУУЛИЙН ЗОРИЛТ, ЗАРЧИМ

1 дүгээр зүйл. Монгол улсын эрүүгийн Төрөлжсөн хуулийн зорилт

1.1. Монгол улсын Эрүүгийн Төрөлжсөн хуулийн зорилт нь хүний ба иргэний эрх, эрх чөлөө, өмч, нийгмийн хэв журам ба нийгмийн аюулгүй байдал, хүрээлэн буй орчин, Монгол улсын үндсэн хуулийн байгууллыг гэмт халдлагаас хамгаалах, энх тайван ба хүн төрөлхтний аюулгүй байдлыг хангах, түүнчлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино.

1.2. Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд энэхүү Төрөлжсөн хуулиар эрүүгийн хариуцлагын үндэслэл ба зарчмыг тогтоож, хувь хүн, нийгэм буюу улсад аюултай ямар хэргийг гэмт хэрэгт тооцохыг тодорхойлж, гэмт хэрэг үйлдэхэд хүлээлгэх ялын төрөл ба эрүүгийн эрх зүйн шинжтэй бусад арга хэмжээг тогтооно.

2 дугаар зүйл. Монгол улсын Эрүүгийн хууль тогтоомж

2.1. Монгол улсын эрүүгийн хууль тогтоомж нь энэхүү Төрөлжсөн хуулиас бүрэлдэнэ. Эрүүгийн хариуцлага тогтоосон шинэ хууль нь энэхүү Төрөлжсөн хуулийн бүрэлдэхүүн хэсэг болно.

2.2. Энэхүү Төрөлжсөн хууль нь Монгол улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд нийцсэн байна.

3 дугаар зүйл. Хууль ёсны зарчим

3.1. Гэмт хэрэг, түүнчлэн ял хүлээх байдал ба эрүүгийн эрх зүйн бусад үр дагаврыг зөвхөн энэхүү Төрөлжсөн хуулиар тодорхойлно.

3.2. Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхийг хориглоно.

4 дүгээр зүйл. Гэм буруугийн зарчим

4.1. Зөвхөн нийгэмд аюултай үйлдэл (эс үйлдэхүй) үйлдсэн ба нийгэмд аюултай хор уршиг учруулсан, тэдгээртэй харьцсан гэм буруу нь тогтоогдсон этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

4.2. Гэм буруугүйгээр гэм хор учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

5 дугаар зүйл. Иргэд хуулийн өмнө эрх тэгш байх зарчим

5.1. Гэмт хэрэг үйлдсэн этгээд хуулийн өмнө эрх тэгш байх бөгөөд түүний хүйс, арьсны өнгө, хэл, үндэс угсаа, эд хөрөнгийн ба албан тушаалын байдал, оршин суугаа газар, шашин шүтлэг, итгэл үнэмшил, түүнчлэн бусад нөхцөл байдлаас хамаарахгүйгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

6 дугаар зүйл. Шударга ёсны зарчим

6.1. Ял ба гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хэрэглэх эрүүгийн эрх зүйн шинжтэй арга хэмжээ нь гэмт хэргийн шинж чанар ба нийгмийн аюулын хэр хэмжээ, түүнийг үйлдсэн нөхцөл байдал ба гэм буруутай этгээдийн хувийн байдалд нийцэж тохирсон байна.

6.2. Хэнд ч нэг гэмт хэрэгт хоёр удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

7 дугаар зүйл. Энэрэнгүй ёсны зарчим

7.1. Монгол улсын эрүүгийн хууль тогтоомж нь хүний аюулгүй байдлыг хангана.

7.2. Ял ба гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хэрэглэх эрүүгийн эрх зүйн шинжтэй арга хэмжээ нь бусдын бие махбодийг зовоох ба хүний нэр хүндийг гутаах зорилгыг агуулж болохгүй.

8 дугаар зүйл. Эрүүгийн хариуцлагын үндэслэл

8.1. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл нь энэхүү Төрөлжсөн хуульд заасан гэмт хэргийн бүрэлдүүний бүх шинжийг агуулсан хэрэг болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙНХУУЛЬ ҮЙЛЧЛЭХ ЦАГ ХУГАЦАА, НУТАГ ДЭВСГЭР, ХАМААРАХ ЭТГЭЭД

9 дүгээр зүйл. Эрүүгийн хууль үйлчлэх цаг хугацаа

9.1. Гэмт хэрэг ба ял хүлээх хэргийг тухайн хэргийг үйлдэх үед дагаж мөрдөж байсан эрүүгийн хуулиар тодорхойлно.

9.2. Гэмт хэрэг үйлдсэн цаг хугацаа гэж гэмт хэргийн хор уршиг буй болсон цаг хугацаанаас үл хамааран нийгэмд аюултай үйлдлийг (эс үйлдэхүйг) үйлдсэн цаг үеийг үзнэ.

10 дугаар зүйл. Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх

10.1. Хэргийг гэмт хэрэгт тооцохгүй болсон, ял хөнгөрүүлсэн буюу бусад байдлаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийн байдлыг дээрдүүлсэн эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх бөгөөд өөрөөр хэлбэл, ийм хууль батлахаас өмнө холбогдох хэрэг үйлдсэн, түүний дотор ял эдэлж байгаа, ял эдэлж байсан буюу ялтай байдалтай байгаа этгээдэд хамаарна. Хэргийг гэмт

хэрэгт тооцсон, ялыг чангатгасан буюу өөр байдлаар тухайн этгээдийн байдлыг дордуулсан эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхгүй.

10.2.Хэрэв эрүүгийн шинэ хуулиар тухайн этгээдийн ял эдэлж буй хэрэгт заасан ялыг хөнгөрүүлж байгаа бол шинэ эрүүгийн хуульд заасан хязгаарын хүрээнд түүний ялаас хасна.

11 дүгээр зүйл. Монгол улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хууль үйлчлэх

11.1.Монгол улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэхүү Төрөлжсөн хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

11.2.Монгол улсын нутаг дэвсгэрийн агаарын буюу усны орон зайн хязгаарын хүрээнд үйлдсэн гэмт хэргийг Монгол улсын нутаг дэвсгэрт үйлдсэн гэмт хэрэг гэж үзнэ.

11.3.Монгол улсаас гадна агаарын буюу нээлттэй усны орон зайд буй Монгол улсын хөлөг онгоцонд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хэрэв Монгол улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэхүү Төрөлжсөн хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

11.4.Гадаад улсын дипломат төлөөлөгч ба дархлаа бүхий бусад иргэн Монгол улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэх асуудлыг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн шийдвэрлэнэ.

12 дугаар зүйл. Монгол улсын нутаг дэвсгэрийн гадна гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хууль үйлчлэх

12.1.Монгол улсын иргэн ба Монгол улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа харъяалалгүй этгээд энэхүү Төрөлжсөн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлын эсрэг Монгол улсын нутаг дэвсгэрийн гадна гэмт хэрэг үйлдсэн бол хэрэв түүний хувьд энэхүү гэмт хэргийн талаар гадаад улсын шүүхийн шийдвэр гараагүй бол энэхүү Төрөлжсөн хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

12.2.Монгол улсын хилийн гадна байрлаж байгаа цэргийн ангийн цэргийн албан хаагч гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн бол хэрэв Монгол улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэхүү Төрөлжсөн хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

12.3.Гадаадын иргэн ба Монгол улсад байнга оршин суугч бус харъяалалгүй этгээд Монгол улсаас гадна үйлдсэн гэмт хэрэг нь хэрэв Монгол улс, эсхүл Монгол улсын иргэн, эсхүл Монгол улсад байнга оршин амьдардаг харъяалалгүй этгээдийн ашиг сонирхлын эсрэг чиглэгдсэн, түүнчлэн Монгол улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд хэрэв гадаадын иргэн ба Монгол улсад байнга оршин суугч бус харъяалалгүй этгээд гадаад улсад ял шийтгэгдээгүй ба Монгол улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хариуцлагад татагдаж байгаа бол энэхүү Төрөлжсөн хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ

13 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэх

13.1.Гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн Монгол улсын иргэнийг гадаад улсад шилжүүлэн өгөхгүй.

13.2. Монгол улсаас гадна гэмт хэрэг үйлдсэн Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн ба харъяалалгүй этгээдийг Монгол улсын олон улсын гэрээний дагуу эрүүгийн хариуцлагад хүлээлгэх буюу ял эдлүүлэхээр гадаад улсад шилжүүлэн өгч болно.

I I ХЭСЭГ. ГЭМТ ХЭРЭГ

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГЭМТ ХЭРГИЙН УХАГДАХУУН БА ГЭМТ ХЭРГИЙН ТӨРӨЛ

14 дүгээр зүйл. Гэмт хэргийн ухагдахуун

14.1. Гэмт хэрэг гэж ял ногдуулах замаар энэхүү Төрөлжсөн хуулиар хориглосон, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдсэн хэргийг үзнэ.

14.2. Энэхүү Төрөлжсөн хуульд заасан ямар нэгэн хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч нийгмийн аюул нь ялимгүй үйлдлийг (эс үйлдэхүйг) гэмт хэрэгт тооцохгүй.

15 дугаар зүйл. Гэмт хэргийн ангилалт

15.1. Энэхүү Төрөлжсөн хуульд заасан хэргийн нийгмийн аюулын шинж чанар ба хэр хэмжээг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд ба онц хүнд гэж ангилна.

15.2. Хөнгөн гэмт хэрэг гэж энэхүү Төрөлжсөн хуульд заасан ялын дээд хугацаа нь хоёр жилийн хорих ялаас хэтрэхгүй байгаа санаатай ба болгоомжгүй үйлдсэн хэргийг үзнэ.

15.3. Хүндэвтэр гэмт хэрэг гэж энэхүү Төрөлжсөн хуульд заасан ялын дээд хугацаа нь таван жилийн хорих ялаас хэтрэхгүй байгаа санаатай үйлдсэн хэрэг ба энэхүү Төрөлжсөн хуульд заасан хоёр жилийн хорих ялаас дээш хугацаатай болгоомжгүй үйлдсэн хэргийг үзнэ.

15.4. Хүнд гэмт хэрэг гэж энэхүү Төрөлжсөн хуульд заасан ялын дээд хугацаа нь арван жилийн хорих ялаас хэтрээгүй санаатай үйлдсэн хэргийг үзнэ.

15.5. Онц хүнд гэмт хэрэг гэж энэхүү Төрөлжсөн хуульд заасан арваас дээш жилийн хорих ялтай буюу түүнээс хатуу ял заасан санаатай үйлдсэн хэргийг үзнэ.

16 дугаар зүйл. Нийлмэл гэмт хэрэг

16.1. Хоёр буюу түүнээс дээш гэмт хэрэг үйлдэж тэдгээрийн аль нэгэнд ял шийтгүүлээгүй ба хамгийн хатуу ял хүлээх нөхцөл байдал болгон энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн зүйлд заасан хоёр буюу түүнээс дээш гэмт хэрэг үйлдсэнээс бусад тохиолдолд нийлмэл гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ. Нийлмэл гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэхүү Төрөлжсөн хуулийн холбогдох зүйл буюу хэсэгт заасан үйлдсэн гэмт хэрэг тус бүрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

16.2. Энэхүү Төрөлжсөн хуулийн хоёр буюу түүнээс дээш зүйлд заасан гэмт хэргийн шинжийг агуулсан нэг үйлдлийг (эс үйлдэхүй) нийлмэл гэмт хэрэг гэж үзнэ.

16.3. Хэрэв тухайн гэмт хэргийг ерөнхий ба тусгай хэм хэмжээнд заасан тохиолдолд нийлмэл гэмт хэрэг гэж үзэхгүй, эрүүгийн хариуцлагыг тусгай хэм хэмжээнд үндэслэн хүлээлгэнэ.

17 дугаар зүйл. Давтан гэмт хэрэг

17.1. Урьд нь санаатай гэмт хэрэг үйлдэж ялтай байдалтай байгаа этгээд гэмт хэрэг санаатай үйлдснийг давтан гэмт хэрэг гэж үзнэ.

17.2. Аюултай давтан гэмт хэрэг гэж:

17.2.1. хэрэв урьд нь хүндэвтэр гэмт хэрэг санаатай үйлдэж, хоёр буюу түүнээс дээш удаа хорих ял шийтгүүлсэн этгээд хорих ял биечлэн эдлэх хүнд гэмт хэрэг үйлдснийг үзнэ;

17.2.2. хэрэв урьд нь хүнд буюу онц хүнд гэмт хэрэгт хорих ял биечлэн эдэлсэн этгээд хүнд гэмт хэрэг үйлдснийг үзнэ.

17.3. Онц аюултай давтан гэмт хэрэг гэж:

17.3.1. хэрэв урьд нь хүнд гэмт хэрэгт хоёр удаа хорих ял биечлэн эдэлсэн этгээд биечлэн хорих ял эдлэх хүнд гэмт хэрэг үйлдснийг үзнэ;

17.3.2. хэрэв урьд нь хүнд буюу онц хүнд гэмт хэрэгт хоёр удаа ял шийтгүүлсэн этгээд онц хүнд гэмт хэрэг үйлдснийг үзнэ.

17.4. Дараахь байдлыг давтан гэмт хэрэгт тооцохгүй:

17.4.1. хүндэвтэр санаатай гэмт хэрэгт ялтай байдалтай байгаа;

17.4.2. арван найман нас хүрэхийн өмнө үйлдсэн гэмт хэрэгт ялтай байдалтай байгаа;

17.4.3. ял тэнсэгдэж, эсхүл шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж, хэрэв тэнсэгдсэн буюу шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан нь цуцлагдаагүй ба хорих газар ял эдлэхээр яваагүй, түүнчлэн энэхүү Төрөлжсөн хуулийн 82 дугаар зүйлд тогтоосон журмын дагуу ялтай байдалтайд тооцох хугацаа нь арилсан буюу дууссан.

17.5. Давтан гэмт хэрэгт энэхүү Төрөлжсөн хуульд заасан хязгаарын хүрээнд үндэслэн хамгийн хатуу ял ногдуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХ ЭТГЭЭД

18 дугаар зүйл. Эрүүгийн хариуцлагын нийтлэг нөхцөл

18.1. Зөвхөн энэхүү Төрөлжсөн хуулиар тогтоосон насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хувь этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

19 дүгээр зүйл. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх нас

19.1. Гэмт хэрэг үйлдэх үед арван зургаан насанд хүрсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

19.2. Гэмт хэрэг үйлдэх үед арван дөрвөн насанд хүрсэн этгээдэд хүн санаатай алах (100 дугаар зүйл), эрүүл мэндэд хүнд гэм хор санаатай учруулах (106 дугаар зүйл), эрүүл мэндэд хүндэвтэр гэм хор санаатай учруулах (107 дугаар зүйл), хүн хулгайлах (136 дугаар зүйл), хүчиндэх (148 дугаар зүйл), хүч хэрэглэсэн бэлгийн шинжтэй үйлдэл үйлдэх (149 дүгээр), хулгайлах (153 дугаар зүйл), булаах (156 дугаар зүйл), дээрэмдэх (157 дугаар зүйл), далайлган сүрдүүлэх (158 дугаар зүйл), ашиглан шамшигдуулах зорилгогүйгээр автомашин буюу бусад тээврийн хэрэгслийг хууль бусаар эзэмдэх (161 дүгээр зүйл), хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар эд хөрөнгө санаатай устгах буюу гэмтээх (162 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг), террорист явуулга (192 дугаар зүйл), хүн барьцаалах (195 дугаар зүйл), хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар танхайрах (200 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг), эрээчих (201 дүгээр зүйл), галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл ба тэсэрч дэлбэрэх бодис ба дэлбэлэгч төхөөрөмжийг ашиглан шамшигдуулах эсхүл далайлган сүрдүүлэх (212 дугаар зүйл), мансууруулах хэрэгсэл ба сэтгэцэд нөлөөт бодисыг ашиглан шамшигдуулах эсхүл далайлган сүрдүүлэх (216 дугаар зүйл), тээврийн хэрэгсэл, зам харилцааны төхөөрөмжийг хэрэгцээнээс гаргах (248 дугаар зүйл) гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

19.3. Хэрэв энэхүү зүйлийн нэг, хоёр дахь хэсэгт заасан насанд хүрсэн насанд хүрээгүй хүн нийгэмд аюултай хэрэг үйлдэх үедээ өөрийн үйлдлийн бодит шинж чанар ба нийгэмд аюултай байдлыг бүрэн хэмжээгээр ухамсарлаж чадаагүй нь сэтгэцийн зовиуртай холбоогүй, харин сэтгэцийн хөгжлийн хомсдолын улмаас болсон бол түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

20 дугаар зүйл. Хэрэг хариуцах чадваргүй байдал

20.1. Нийгэмд аюултай хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан өөрөөр хэлбэл, сэтгэцийн архаг зовиур, сэтгэцийн түр зовиур, оюун ухааны хомсдол, эсхүл сэтгэцийн өөр өвчний улмаас өөрийн үйлдлийн (эс үйлдэхүйн) бодит шинж чанар ба нийгэмд аюултай байдлыг ухамсарлаж, эсхүл түүнийг удирдан жолоодож чадаагүй байсан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

20.2. Эрүүгийн хуульд заасан нийгэмд аюултай хэргийг хэрэг хариуцах чадваргүй байдалд үйлдсэн этгээдэд шүүх энэхүү Төрөлжсөн хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ ногдуулж болно.

21 дүгээр зүйл. Хэрэг хариуцах чадвар бүхий сэтгэцийн зовиуртай этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага

21.1. Гэмт хэрэг үйлдэх үед сэтгэцийн зовиурын улмаас өөрийн үйлдлийн (эс үйлдэхүйн) бодит шинж чанар ба нийгэмд аюултай байдлыг бүрэн хэмжээгээр ухамсарлаж, эсхүл түүнийг удирдан жолоодож чадаагүй хэрэг хариуцах чадвартай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

21.2. Шүүх ял ногдуулахдаа хэрэг хариуцах чадвар нь үгүйсгэгдээгүй сэтгэцийн зовиурыг харгалзан үзэх ба түүнийг эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ ногдуулах үндэслэл болгож болно.

22 дугаар зүйл. Согтуурлын байдалд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага

22.1. Согтууруулах ундаа, мансууруулах хэрэгсэл буюу бусад донтуулах бодис хэрэглэсний улмаас согтуурал мансуурлын байдалд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ. ГЭМ БУРУУ

23 дугаар зүйл. Гэм буруугийн хэлбэр

23.1. Хэргийг санаатай буюу болгоомжгүй үйлдсэн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцно.

23.2. Зөвхөн болгоомжгүй үйлдсэн хэргийг гагцхүү энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлд тусгайлан заасан тохиолдолд гэмт хэрэг гэж үзнэ.

24 дүгээр зүйл. Санаатай үйлдсэн гэмт хэрэг

24.1. Санаатай үйлдсэн гэмт хэрэг гэж шууд буюу шууд бус санаагаар үйлдсэн хэргийг үзнэ.

24.2. Шууд санаагаар үйлдсэн гэмт хэрэг гэж хэрэв тухайн этгээд үйлдлийнхээ (эс үйлдэхүйн) нийгмийн аюулыг ухамсарлаж, нийгэмд аюултай хор уршиг учруулахыг урьдчилан мэдэх боломжтой буюу мэдэх ёстой байсан ба түүнийг хүсэж учруулсаныг үзнэ.

24.3. Шууд бус санаагаар үйлдсэн гэмт хэрэг гэж хэрэв тухайн этгээд үйлдлийнхээ (эс үйлдэхүйн) нийгмийн аюулыг ухамсарлаж, нийгэмд аюултай хор уршиг учруулахыг урьдчилан мэдэх боломжтой байсан ба түүнийг учруулахыг хүсээгүй боловч тухайн хор уршгийг зориуд учруулсан буюу тухайн хор уршгийг учруулсан ч яахав гэж харьцсаныг үзнэ.

25 дугаар зүйл. Болгоомжгүй үйлдсэн гэмт хэрэг

25.1. Болгоомжгүй үйлдсэн гэмт хэрэг гэж хөнгөмсгөөр найдсан буюу хайхрамжгүй хандаж үйлдсэн хэргийг үзнэ.

25.2. Хөнгөмсгөөр найдаж үйлдсэн гэмт хэрэг гэж хэрэв тухайн этгээд үйлдлийнхээ (эс үйлдэхүйн) нийгмийн аюулыг ухамсарлаж, нийгэмд аюултай хор уршиг учруулахыг урьдчилан мэдэх боломжтой байсан боловч энэ хор уршгийг зайлуулж чадна гэж хангалттай үндэслэлгүйгээр өөртөө найдаж тооцоолсоныг үзнэ.

25.3. Хайхрамжгүй хандаж үйлдсэн гэмт хэрэг гэж хэрэв тухайн этгээд үйлдлийнхээ (эс үйлдэхүйн) нийгмийн аюулыг ухамсарлаж, нийгэмд аюултай хор уршиг учруулахыг урьдчилан мэдээгүй боловч зайлшгүй шаардлагатай анхаарал ба хянуур байсан бол энэ хор уршгийг урьдчилан мэдэх ёстой ба мэдэж болох байсаныг үзнэ.

26 дугаар зүйл. Гэм буруугийн давхардсан хэлбэр

26.1. Хэрэв гэмт хэрэг санаатай үйлдсэний үр дүнд хуулийн дагуу хамгийн хатуу ял ногдуулах хүнд хор уршиг учруулж, энэ нь тухайн этгээдийн санаанд багтаагүй байсан бол ийм хор уршигт тухайн этгээд өөрийнхөө үйлдлийн (эс үйлдэхүйн) нийгмийн аюулыг ухамсарлаж, нийгэмд аюултай хор уршиг учруулахыг урьдчилан мэдэх боломжтой байсан

боловч энэ хор уршигийг зайлуулж чадна гэж хангалттай үндэслэлгүйгээр өөртөө найдаж тооцоолсон буюу хэрэв тухайн этгээд урьдчилан мэдээгүй боловч ийм хор уршиг учруулахыг мэдэх ёстой ба мэдэж болох байсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Ийм гэмт хэргийг бүхэлд нь гэмт хэрэг санаатай үйлдсэн гэж үзнэ.

27 дугаар зүйл. Гэм буруугүй учруулсан гэм хор

27.1. Хэрэв хэрэг үйлдсэн этгээд үйлдлийнхээ (эс үйлдэхүйн) нийгмийн аюулыг ухамсарлаагүй ба хэргийн нөхцөл байдлаар ухамсарлаж чадахгүй байсан, эсхүл нийгэмд аюултай хор уршиг учруулах боломжийг урьдчилан мэдэх боломжгүй ба хэргийн нөхцөл байдлаар мэдэх ёсгүй байсан ба урьдчилан харж чадахгүй байсан хэргийг гэм буруугүй үйлдсэн гэж үзнэ.

27.2. Хэрэв хэрэг үйлдсэн этгээд үйлдлийнхээ (эс үйлдэхүйн) улмаас нийгэмд аюултай хор уршиг учруулахыг урьдчилан мэдэх боломжтой байсан боловч өөрийнх нь сэтгэц-физиологийн чанар нь онцгой нөхцөл буюу мэдрэл-сэтгэцийн хэт их ачааллын шаардлагад нийцээгүйн улмаас тухайн хор уршигийг зайлуулж чадаагүй бол гэм буруугүй үйлдсэн гэж үзнэ.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ГЭМТ ХЭРЭГ ТӨГСӨХӨӨС ӨМНӨХ ҮЕ ШАТ

28 дугаар зүйл. Төгссөн ба төгсөөгүй гэмт хэрэг

28.1. Хэрэв тухайн этгээдийн үйлдсэн хэрэг нь энэхүү Төрөлжсөн хуульд заасан гэмт хэргийн бүрэлдүүний бүх шинжийг агуулсан бол төгссөн гэмт хэрэг гэж үзнэ.

28.2. Гэмт хэрэгт бэлтгэх ба гэмт хэрэгт завдахыг төгсөөгүй гэмт хэрэг, өөрөөр хэлбэл, гэмт хэрэг төгсөхөөс өмнөх үе шат гэж үзнэ.

28.3. Төгсөөгүй гэмт хэрэгт энэхүү Төрөлжсөн хуулийн 29, 30 дугаар зүйлийг баримтлан төгссөн гэмт хэрэгт заасан зүйлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

29 дүгээр зүйл. Гэмт хэрэгт бэлтгэх

29.1. Гэмт хэрэгт бэлтгэсэн гэж гэмт хэрэг үйлдэх зэвсэг буюу хэрэгслийг эрж олсон, бэлтгэсэн, төхөөрч тохируулсан, хамтран оролцогчийг сонгож авсан, гэмт хэрэг үйлдэх талаар үгсэн тохиролцсон, түүнчлэн гэмт хэрэг үйлдэх бусад нөхцөлийг санаатай бүрдүүлсэн ба ингэхдээ тухайн этгээдээс үл шалтгаалах нөхцөл байдлын улмаас гэмт хэргийг төгсөөгүй байхыг үзнэ.

29.2. Гагцхүү хүнд буюу онц хүнд гэмт хэрэгт бэлтгэсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

30 дугаар зүйл. Гэмт хэрэгт завдах

30.1. Гэмт хэрэгт завдсан гэж гэмт хэрэг үйлдэхэд шууд чиглэгдсэн санаатай үйлдэл (эс үйлдэхүй) үйлдсэн ба хэрэв ингэхдээ тухайн этгээдээс үл шалтгаалах нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг төгсөөгүй байхыг үзнэ.

31 дүгээр зүйл. Гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзах

31.1. Гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзсан гэж хэрэв тухайн этгээд гэмт хэргийг төгсгөлд нь хүргэх бололцоотой байснаа ухамсарлаж, гэмт хэрэгт бэлтгэх, эсхүл гэмт хэрэг үйлдэхэд шууд чиглэгдсэн үйлдлээ бүрмөсөн зогсоосныг үзнэ.

31.2. Тухайн этгээдэд төгсгөлд нь хүргэхээс сайн дураараа ба бүрмөсөн татгалзсан гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

31.3. Гэмт хэргийг төгсгөлд нь хүргэхээс сайн дураараа татгалзсан этгээд хэрэв өөр гэмт хэргийн бүрэлдүүнийг агуулсан хэрэг үйлдсэн тохиолдолд тэр хэрэгт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

31.4. Гэмт хэргийн зохион байгуулагч ба гэмт хэрэгт хатгагч нь хэрэв цаг тухайн үед нь засаг төрийн байгууллагад мэдээлсэн буюу гүйцэтгэгчээс гэмт хэргийг төгсгөлд нь хүргэхээс зайлуулах бусад арга хэмжээ авч чадсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй. Гэмт хэрэг үйлдүүлэхгүйн тулд өөрөөсөө шалтгаалах бүх арга хэмжээг авсан бол гэмт хэргийн хамжигчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

31.5. Хэрэв зохион байгуулагч буюу хатгагчийн үйлдэл нь энэ зүйлийн дөрөв дэх хэсэгт заасан, гүйцэтгэгчээс гэмт хэрэг үйлдэх явдлыг болиулж чадаагүй бол тэдний авсан арга хэмжээг ял ногдуулахад хөнгөрүүлэх нөхцөл байдал хэмээн шүүх харгалзан үзэж болно.

ДОЛООДУГААР БҮЛЭГ. ГЭМТ ХЭРЭГ ХАМТРАН ҮЙЛДЭХ

32 дугаар зүйл. Гэмт хэрэгт хамтран оролцох ухагдахуун

32.1. Гэмт хэрэгт хамтран оролцох гэж гэмт хэрэг санаатай үйлдэхээр хоёр буюу түүнээс дээш этгээд санаатай нэгдсэнийг үзнэ.

33 дугаар зүйл. Гэмт хэрэг хамтран оролцогчийн төрөл

33.1. Гүйцэтгэгч болон зохион байгуулагч, хатгагч ба хамжигчийг гэмт хэргийн хамтран оролцогч гэж үзнэ.

33.2. Гүйцэтгэгч гэж гэмт хэрэг шууд үйлдсэн, эсхүл бусад этгээдтэй гэмт хэрэг үйлдэхэд хамтран шууд оролцсон (хамтран гүйцэтгэгчид), түүнчлэн нас, хэрэг хариуцах чадваргүй байдал буюу өөр нөхцөл байдлын улмаас энэхүү Төрөлжсөн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээх ёсгүй бусад этгээдийг ашиглах замаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг үзнэ.

33.3. Зохион байгуулагч гэж гэмт хэрэг үйлдэхийг зохион байгуулсан буюу түүний гүйцэтгэлийг удирдсан, түүнчлэн зохион байгуулалттай бүлэг буюу гэмт бүлэглэл (гэмт байгууллага) ббайгуулсан, эсхүл түүнийг удирдсан этгээдийг үзнэ.

33.4. Хатгагч гэж гэмт хэрэг үйлдэхэд ятгасан, хууль бус шан харамж өгсөн, айлган сүрдүүлсэн буюу өөр аргаар бусад этгээдийг өдөөн турхирсан этгээдийг үзнэ.

33.5. Хамжигч гэж гэмт хэрэгт үйлдэхэд зөвлөгөө, зааварчилга, мэдээлэл өгсөн, гэмт хэрэг үйлдэх хэрэгсэл буюу зэвсэг олж өгсөн, эсхүл учрах саадыг арилгаж тус дөхөм үзүүлсэн этгээд, түүнчлэн урьдчилан амлаж гэмт хэрэгтэн, гэмт хэрэг үйлдсэн хэрэгсэл ба зэвсэг, гэмт хэргийн ул мөр, эсхүл гэмт замаар олсон зүйлийг нуусан, ийм зүйлийг урьдчилан амлаж авсан буюу борлуулсан этгээдийг үзнэ.

34 дүгээр зүйл. Гэмт хэргийн хамтран оролцогчид хүлээлгэх хариуцлага

34.1. Гэмт хэрэгт хамтран оролцогчид хүлээлгэх хариуцлага нь гэмт хэрэг үйлдэхэд тэдний тус бүрийн бодит оролцооны шинж чанар ба хэр хэмжээгээр тодорхойлогдоно.

34.2. Хамтран гүйцэтгэгчдэд энэхүү Төрөлжсөн хуулийн 33 дугаар зүйлийг удирдлага болгохгүйгээр хамтран үйлдсэн гэмт хэрэгт нь энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн зүйлээр хариуцлага хүлээлгэнэ.

34.3. Зохион байгуулагч, хатгагч ба хамжигч нэгэн зэрэг гэмт хэргийн хамтран гүйцэтгэгчид болж байгаагаас бусад тохиолдолд тэдэнд энэхүү Төрөлжсөн хуулийн 33 дугаар зүйлийг удирдлага болгон үйлдсэн гэмт хэрэгт нь ял тогтоосон зүйлээр хариуцлага хүлээлгэнэ.

34.4. Гэмт хэрэг үйлдэхэд хамтран оролцсон, энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлд тусгайлан заасан гэмт хэргийн субъект бус этгээдэд тухайн гэмт хэргийн зохион байгуулагч, хатгагч, эсхүл хамжигчаар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

34.5. Гэмт хэргийн гүйцэтгэгчээс үл шалтгаалах нөхцөл байдлын улмаас гэмт хэргийг төгсгөлд нь хүргээгүй тохиолдолд бусад хамтран оролцогчдод гэмт хэрэгт бэлтгэсэн буюу завдсанаар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Гэмт хэрэг үйлдэхэд өөрөөсөө үл шалтгаалах нөхцөл байдлын улмаас бусад этгээдийг өдөөн турхирч чадаагүй этгээдэд гэмт хэрэгт бэлтгэсэнээр эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

35 дугаар зүйл. Бүлэг этгээд, урьдчилан тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг буюу гэмт бүлэглэл (гэмт байгууллага) гэмт хэрэг хамтран үйлдэх

35.1. Бүлэг этгээдийн үйлдсэн гэмт хэрэг гэж хоёр буюу түүнээс дээш гүйцэтгэгч урьдчилан тохиролцолгүйгээр гэмт хэрэгт хамтран оролцсоныг үзнэ.

35.2. Урьдчилан тохиролцсон бүлгийн үйлдсэн гэмт хэрэг гэж хамтран гэмт хэрэг үйлдэх талаар урьдчилан тохиролцсон этгээдүүд оролцсоныг үзнэ.

35.3. Зохион байгуулалттай бүлгийн үйлдсэн гэмт хэрэг гэж нэг буюу хэд хэдэн гэмт хэрэг үйлдэхээр урьдчилан нэгдсэн тогтвортой бүлгээс үйлдсэнийг үзнэ.

35.4. Гэмт бүлэглэл (гэмт байгууллага)-ийн үйлдсэн гэмт хэрэг гэж хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдэхээр нягтарсан зохион байгуулалттай бүлэг, эсхүл ийм зорилгоор байгуулагдсан зохион байгуулалттай бүлэгт нэгдэж үйлдсэнийг үзнэ.

35.5. Зохион байгуулалттай бүлэг буюу гэмт бүлэглэл (гэмт байгууллага)-ийг байгуулсан, эсхүл түүнийг удирдсан этгээдэд энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлд заасан тохиолдолд байгуулсан ба удирдсан, түүнчлэн түүний санааг хамарсан зохион байгуулалттай бүлэг буюу гэмт бүлэглэл (гэмт байгууллага)-ийн үйлдсэн бүх гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Зохион байгуулалттай бүлэг буюу гэмт бүлэглэл

(гэмт байгууллага)-ийн бусад оролцогчдод энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлд заасан тохиолдолд, түүнчлэн тэдгээрийн бэлтгэсэн буюу оролцож үйлдсэн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

35.6. Энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн зүйлд заагаагүй тохиолдолд зохион байгуулалттай бүлэг байгуулсан бол зохион байгуулалттай бүлэг байгуулж үйлдэхээр бэлтгэсэн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

35.7. Бүлэг этгээд, урьдчилан тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг буюу гэмт бүлэглэл (гэмт байгууллага) гэмт хэрэг үйлдсэн бол энэхүү Төрөлжсөн хуульд заасан хязгаарын хүрээнд үндэслэн хамгийн хатуу ял ногдуулна.

36 дугаар зүйл. Гэмт хэргийн зөрж гүйцэтгэгч

36.1. Гэмт хэргийн зөрж гүйцэтгэгч гэж бусад хамтран оролцогчдын санааг хамраагүй гэмт хэрэг үйлдсэнийг үзнэ. Зөрж гүйцэтгэгчийн үйлдсэн гэмт хэрэгт гэмт хэргийн бусад хамтран оролцогчдод эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

НАЙМДУГААР БҮЛЭГ. ГЭМТ ХЭРГИЙГ ҮГҮЙСГЭХ НӨХЦӨЛ БАЙДАЛ

37 дугаар зүйл. Аргагүй хамгаалалт

37.1. Хамгаалагчийн буюу бусад этгээдийн эрх буюу нийгэм ба төрийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг нийгэмд аюултай халдлагаас хамгаалах үед хэрэв тухайн халдлага хүч хэрэглэсэн, хамгаалагчийн буюу бусад этгээдийн амь биед аюултай байсан, эсхүл ийм хүч хэрэглэхээр шууд айлган сүрдүүлсэн бол халдагч этгээдэд гэм хор учруулсаныг гэмт хэрэг гэж үзэхгүй.

37.2. Хамгаалагчийн буюу бусад этгээдийн амь насанд аюултай, эсхүл ийм хүч хэрэглэхээр шууд айлган сүрдүүлсэн хүч хэрэглээгүй халдлагаас хамгаалсан нь хэрэв аргагүй хамгаалалтын хэр хэмжээг хэтрүүлээгүй өөрөөр хэлбэл, халдлагын шинж чанар ба аюулд илт нийцээгүй санаатай үйлдлийг эрх зүйн дагуу гэж үзнэ.

37.2.1. Хэрэв тухайн этгээд гэнэтийн халдлагын улмаас довтолгооны аюулын хэр хэмжээ ба шинж чанарыг бодитой үнэлж чадаагүй бол хамгаалагчийн үйлдлийг арга хамгаалалтын хэр хэмжээг хэтрүүлсэн гэж үзэхгүй.

37.3. Энэ зүйлийн заалт нь мэргэжлийн буюу өөр тусгай бэлтгэл ба албан ажлын байдал, түүнчлэн нийгэмд аюултай халдлагаас зайлсхийх буюу бусад этгээд буюу засаг төрийн байгууллагаас туслалцаа авахаар хандах боломжоос үл шалтгаалан бүх этгээдэд нэгэн адил хамаарна.

38 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг албадан саатуулах үед гэм хор учруулах

38.1. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг засаг төрийн байгууллагад хүргэх ба түүнээс шинэ гэмт хэрэг үйлдэх боломжийг таслан зогсоох, хэрэв өөрөөр хэрэгслээр тухайн этгээдийг албадан саатуулах боломжгүй ба ингэхдээ аргагүй хамгаалалтын хэр хэмжээг хэтрүүлээгүй бол гэмт хэрэг үйлдсэн этгээдэд гэм хор учруулсныг гэмт хэрэг гэж үзэхгүй.

38.2. Албадан саатуулагдсан этгээдийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар ба хэр хэмжээнд илтэд тохироогүй, албадан саатуулсан нөхцөл байдал зайлшгүй шаардаагүй байхад хэр хэмээс илт хэтэрсэн гэм хор учруулсан бол гэмт хэрэг үйлдсэн этгээдийг албадан саатуулахад зайлшгүй шаардлагатай арга хэмжээг хэтрүүлсэн гэж үзнэ. Ийм хэтрүүлэлтэд зөвхөн гэм хор санаатай учруулсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

39 дүгээр зүйл. Гарцаагүй байдал

39.1. Хүний эрх ба тухайн этгээд буюу бусад этгээдийн эрх, нийгэм буюу төрийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд шууд заналхийлсэн аюулыг арилгасан, хэрэв энэ аюулыг өөр хэрэгслээр арилгаж болохооргүй байсан ба ингэхдээ гарцаагүй байдлын хэр хэмжээг хэтрүүлээгүй нөхцөлд эрүүгийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсан бол гэмт хэрэг гэж үзэхгүй.

39.2. Заналхийлсэн аюулын шинж чанар ба хэр хэмжээ ба дурдсан ашиг сонирхолд эн тэнцүү буюу учирч болох байснаас илүү их гэм хор учруулж, аюулыг арилгах нөхцөл байдалтай илтэд тохироогүй гэм хор учруулсан бол гарцаагүй байдлын хэр хэмжээг хэтрүүлсэн гэж үзнэ. Ийм хэтрүүлэлтэд зөвхөн гэм хор санаатай учруулсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

40 дүгээр зүйл. Бие махбодийн буюу сэтгэл санааны албадлага

40.1. Эрүүгийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд бие махбодийн албадлагын үр дүнд гэм хор учруулсан, хэрэв ийм албадлагын улмаас тухайн этгээд өөрийн үйлдлийг (эс үйлдэхүйг) удирдан жолоодож чадахгүй байсан бол гэмт хэрэг гэж үзэхгүй.

40.2. Сэтгэл санааны албадлага, түүнчлэн бие махбодийн албадлагын үр дүнд өөрийн үйлдлийг удирдан жолоодох боломжоо хэвээр хадгалж байсны улмаас эрүүгийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг энэхүү Төрөлжсөн хуулийн 39 дүгээр зүйлийн заалтыг харгалзан шийдвэрлэнэ.

41 дүгээр зүйл. Үндэслэлтэй эрсдэл

41.1. Нийгэмд ашигтай зорилгод хүрэхийн тулд үндэслэлтэй эрсдлийн явцад эрүүгийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсаныг гэмт хэрэг гэж үзэхгүй.

41.2. Хэрэв эрсдэл бий болгосон этгээд эрүүгийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулахаас сэрэмжлэхийн тулд шаардлагатай арга хэмжээг хангалттай авсан боловч үйлдлийн (эс үйлдэхүйн) эрсдэлтэй холбоогүйгээр дурдсан зорилгод хүрч чадаагүй бол үндэслэлтэй эрсдэл гэж үзнэ.

41.3. Хэрэв тухайн этгээд зориуд олон хүний амь насанд аюултай заналхийлэл, экологийн сүйрэл буюу нийтийн гамшгийн заналхийллийг буй болгосон бол үндэслэлтэй эрсдэл гэж үзэхгүй.

42 дугаар зүйл. Тушаал буюу захирамж биелүүлэх

42.1. Заавал биелүүлэх тушаал буюу захирамжийг биелүүлсэн этгээд эрүүгийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсаныг гэмт хэрэг гэж үзэхгүй. Хууль бус тушаал буюу захирамж гаргасан этгээдэд ийм гэм хорын төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

42.2. Хууль бус тушаал буюу захирамжийг зориуд биелүүлж, гэмт хэрэг санаатай үйлдсэн этгээдэд нийтлэг үндэслэлийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Хууль бус тушаал буюу захирамжийг зориуд хэрэгжүүлээгүй тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

III ХЭСЭГ. ЯЛ

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ЯЛЫН УХАГДАХУУН БА ЗОРИЛГО. ЯЛЫН ТӨРӨЛ

43 дугаар зүйл. Ялын ухагдахуун ба зорилго

43.1. Ял нь шүүхийн шийтгэх тогтоолоор ногдуулах төрийн албадлагын арга хэмжээ болно. Ялыг гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдсон этгээдэд хэрэглэх ба энэхүү Төрөлжсөн хуулиар тухайн этгээдийн эрх ба эрх чөлөөг хасах буюу хязгаарлана.

43.2. Ялыг нийгмийн шударга ёсыг сэргээн тогтоох, түүнчлэн ялтныг засан хүмүүжүүлэх ба шинэ гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэнэ.

44 дүгээр зүйл. Ялын төрөл

44.1. Ял нь дараахь төрөлтэй байна:

- 44.1.1. торгууль;
- 44.1.2. тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах;
- 44.1.3. тусгай, цэргийн буюу хүндэт цол, зэрэг дэв ба төрийн шагналыг хасах;
- 44.1.4. албадан ажил хийлгэх;
- 44.1.5. засан хүмүүжүүлэх ажил хийлгэх;
- 44.1.6. цэргийн алба хаахыг хязгаарлах;
- 44.1.7. эрх чөлөө хязгаарлах;
- 44.1.8. цэргийн сахилгажуулах ангид явуулах;
- 44.1.9. тодорхой хугацаагаар хорих;
- 44.1.10. бүх насаар нь хорих;
- 44.1.11. цаазаар авах.

44.2. Ял нь үндсэн ба нэмэгдэл гэсэн төрөлтэй байна:

- 44.2.1. Албадан ажил хийлгэх, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, цэргийн алба хаахыг хязгаарлах, эрх чөлөө хязгаарлах, цэргийн сахилгажуулах ангид явуулах, тодорхой хугацаагаар хорих, бүх насаар нь хорих, цаазаар авах ялыг зөвхөн үндсэн ялын төрлөөр хэрэглэнэ.
- 44.2.2. Торгууль, тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл эрхлэх эрхийг хасах ялыг үндсэн болон нэмэгдэл төрлийн ялын алинаар ч хэрэглэж болно.

44.2.3. Тусгай, цэргийн буюу хүндэт цол, зэрэг дэв ба төрийн шагналыг хасах ялыг зөвхөн нэмэгдэл ялын төрөл болгон хэрэглэнэ.

45 дугаар зүйл. Торгууль

45.1. Торгууль гэж энэхүү Төрөлжсөн хуульд заасан хязгаарын хүрээнд нийцүүлэн ногдуулах мөнгөн шийтгэлийг үзнэ.

45.2. Торгуулийг нэг зуун мянгаас дөчин сая төгрөг буюу ялтны хоёр долоо хоногоос таван жил хүртэл хугацааны цалин хөлс буюу бусад орлоготой тэнцэх хэмжээгээр тогтооно. Хорин сая төгрөгөөс дээш, эсхүл гурван жилээс дээш хугацаагаар ялтны цалин хөлс буюу бусад орлогын хэмжээтэй тэнцэх торгуулийг зөвхөн энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлд заасан хүнд ба онц хүнд гэмт хэрэгт ногдуулна.

45.3. Шүүх үйлдсэн гэмт хэргийн хүнд хөнгөний байдал ба ялтны болон түүний гэр бүлийн эд хөрөнгийн байдал, түүнчлэн ялтны цалин хөлс буюу бусад орлого олох боломжийг харгалзан торгуулийн хэмжээг тодорхойлно. Шүүх нөхцөл байдлыг харгалзан үзэж хоёр жил хүртэл хугацаагаар торгуулийн тодорхой хэсгийг төлүүлэхийг хойшлуулахаар ногдуулж болно.

45.4. Энэхүү төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлд заасан тохиолдолд торгуулийг зөвхөн нэмэгдэл ялын чанартай ногдуулж болно.

45.5. Үндсэн ялын чанартай ногдуулсан торгуулийг төлөхөөс ноцтой зайлсхийсэн тохиолдолд энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлд заасан санкцын хязгаарын хүрээнд нийцүүлэн өөр ялаар сольж болно.

46 дугаар зүйл. Тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах

46.1. Тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах нь төрийн алба, нутгийн өөрийн удирдлагын байгууллагад албан тушаал хаших, эсхүл тодорхой мэргэжлийн буюу бусад үйл ажиллагаа эрхлэхийг хориглоход оршино.

46.2. Тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах ялыг үндсэн ялын чанартайгаар нэгээс таван жилийн хугацаагаар, нэмэгдэл ялын чанартайгаар зургаан сараас гурван жилийн хугацаагаар тогтооно.

46.3. Тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах ялыг үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар ба хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдлыг харгалзан түүнд тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хэвээр үргэлжүүлэх нь тохиромжгүй хэмээн шүүх үзвэл энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлд ялын чанартай заагаагүй тохиолдолд нэмэгдэл ялын чанартайгаар ногдуулж болно.

46.4. Энэ төрлийн ялыг албадан ажил хийлгэх, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, түүнчлэн ял тэнсэхтэй нэмэгдэл ялын чанартай ногдуулсан тохиолдолд түүний хугацааг шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн тоолно. Тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах ялыг эрх чөлөө хязгаарлах, цэргийн сахилгажуулах ангид явуулах, хорих ялтай нэмэгдэл ялын чанартайгаар ногдуулсан тохиолдолд дурдсан үндсэн ялын хугацаанд хамаарах ба ингэхдээ тэдгээрийг эдэлж эхэлсэн үеэс түүний хугацааг тоолно.

47 дугаар зүйл. Тусгай, цэргийн буюу хүндэт цол, зэрэг дэв ба төрийн шагналыг хасах

47.1. Гэмт буруутай этгээдийн хувийн байдлыг харгалзан хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд ял ногдуулахдаа шүүх түүний тусгай, цэргийн буюу хүндэт цол, зэрэг дэв ба төрийн шагналыг хасаж болно.

48 дугаар зүйл. Албадан ажил хийлгэх

48.1. Албадан ажил хийлгэх нь ялтнаар нийгэмд ашигтай ажлыг үндсэн ажил буюу хичээл сургалтаас нь хөндийрүүлэхгүйгээр үнэ төлбөргүйгээр хийлгэхэд оршино. Эдлүүлбэл зохих албадан ажлын төрөл ба объектыг нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагатай тохиролцон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага тодорхойлно.

48.2. Албадан ажил хийлгэх ялыг өдөрт дөрвөөс дээшгүй цагаар эдлүүлж, жараас хоёр зуун дөчин цагаар тогтооно.

48.3. Ялтан албадан ажил хийлгэх ялаас ноцтой зайлсхийсэн тохиолдолд эрх чөлөө хязгаарлах, хорих ялаар солино. Ингэхдээ эрх чөлөө хязгаарлах, хорих ялын нэг өдрийг албадан ажил хийлгэх ялын найман цагтай дүйцүүлэн тооцно.

48.4. Албадан ажил хийлгэх ялыг хөдөлмөрийн чадваргүй тахир татуу этгээд, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэл насны хүүхэдтэй эмэгтэй, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй, түүнчлэн цэргийн жинхэнэ хугацаат буюу цэргийн гэрээт алба хааж байгаа этгээдэд ногдуулахгүй.

49 дүгээр зүйл. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх

49.1. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг эрхэлсэн тодорхой ажилгүй этгээдэд ногдуулах ба энэ ялыг нутгийн өөрийн удирдлагын байгууллагатай тохиролцон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тодорхойлсон, тэгэхдээ ялтны оршин суугаа газарт эдлүүлнэ.

49.2. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялын хугацааг хоёр сараас хоёр жил хүртэл хугацаагаар тогтооно.

49.3. Ялтны цалин хөлснөөс шүүхийн шийтгэх тогтоолоор тогтоосон хэмжээгээр, таваас хорин таван хувийн хязгаарт багтаан улсын орлогод суутгана.

49.4. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгүүлсэн этгээд ял эдлэхээс ноцтой зайлхийсэн тохиолдолд шүүх ялын эдлээгүй үлдсэн хэсгийг эрх чөлөө хязгаарлах, хорих ялаар солих ба ингэхдээ эрх чөлөө хязгаарлах ялын нэг өдрийг засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялын нэг өдрөөр, хорих ялын нэг өдрийг засан хүмүүжүүлэх ажлын гурван өдөрт тэнцүүлэн тооцно.

49.5. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг хөдөлмөрийн чадваргүй этгээд, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэл насны хүүхэдтэй эмэгтэй, цэргийн жинхэнэ хугацаат буюу цэргийн гэрээт алба хааж байгаа этгээдэд ногдуулахгүй.

50 дугаар зүйл. Цэргийн алба хаахыг хязгаарлах

50.1. Цэргийн алба хаахыг хязгаарлах ялыг гэрээт цэргийн алба хаагч энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлд заасан цэргийн албаны эсрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд, түүнчлэн гэрээт цэргийн алба хаагчид энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангид заасан засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялын оронд гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар ногдуулна.

50.2. Цэргийн алба хаахыг хязгаарлах ял шийтгүүлэгчийн мөнгөн хангалтаас шүүхийн шийтгэх тогтоолд заасан хэмжээгээр, тэгэхдээ хорин хувиас хэтрүүлэхгүйгээр улсын орлогод суутгана. Энэ ялыг эдлүүлэх хугацаанд ялтанг албан тушаалд дэвшүүлж, эсхүл цэргийн цол хүртээж болохгүй ба ялын хугацааг цэргийн ээлжит цол хүртээх хугацаанд оруулан тооцохгүй.

51 дүгээр зүйл. Эрх чөлөө хязгаарлах

51.1. Эрх чөлөө хязгаарлах ялын агуулга нь шүүхийн шийтгэх тогтоол гаргах үед арван найман насанд хүрсэн этгээдийг түүнд хяналт тавих нөхцөлд нийгмээс тусгаарлахгүйгээр тусгай байгууллагад байлгахад оршино.

51.2. Эрх чөлөө хязгаарлах ялыг дараахь этгээдэд ногдуулна:

51.2.1. гэмт хэрэг санаатай үйлдсэн ба ялтай байдалгүй этгээдэд нэгээс гурван жилийн хугацаагаар;

51.2.2. гэмт хэрэг болгоомжгүй үйлдсэн этгээдэд нэгээс таван жилийн хугацаагаар

51.3. Эрх чөлөө хязгаарлах ялыг албадан ажил хийлгэх буюу засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялаар солих тохиолдолд нэг жилээс доошгүй хугацаатай ногдуулна.

51.4. Эрх чөлөө хязгаарлах ял шийтгүүлсэн этгээд ял эдлэхээс ноцтой зайлсхийсэн тохиолдолд шүүхийн шийтгэх тогтоолоор ногдуулсан эрх чөлөө хязгаарлах ялыг хорих ялаар солино. Ингэхдээ эрх чөлөө хязгаарлах ял эдэлсэн хугацааг хорих ялын нэг өдрийг эрх чөлөө хязгаарлах ялын нэг өдөрт дүйцүүлэн тооцно.

51.5. Эрх чөлөө хязгаарлах ялыг хөдөлмөрийн чадваргүй этгээд, жирэмсэн эмэгтэй, арван дөрөв хүртэл насны хүүхэдтэй эмэгтэй, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй, цэргийн жинхэнэ хугацаат буюу цэргийн гэрээт алба хааж байгаа этгээдэд ногдуулахгүй.

52 дугаар зүйл. Цэргийн сахилгажуулах ангид явуулах

52.1. Цэргийн сахилгажуулах ангид явуулах ялыг цэргийн албан хаагчид хэрэв шүүхийн шийтгэх тогтоол гаргах үед цэргийн жинхэнэ албыг хуулиар тогтоосон журмын дагуу хааж байгаа тохиолдолд ногдуулна. Энэ ялыг цэргийн албаны эсрэг гэмт хэрэг үйлдэж, энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлд заасан тохиолдолд гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар тогтоох ба харин гэмт хэргийн шинж чанар ба гэм буруутай этгээдийн хувийн байдал нь хоёр жил хүртэл хугацаатай хорих ялыг мөн хугацаагаар ялтныг цэргийн сахилгажуулах ангид явуулах ялаар солих боломжтой болохыг харуулсан тохиолдолд ногдуулна.

52.2. Хорих ялын оронд цэргийн сахилгажуулах ангид явуулахад хорих ялын нэг өдрийг цэргийн сахилгажуулах ангид явуулах нэг өдөрт дүйцүүлэн тооцно.

53 дугаар зүйл. Хугацаатай хорих

53.1. Хорих ял нь ялтныг нээлттэй анги, хүмүүжүүлэх анги, жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, эсхүл гянданд байлгах замаар нийгмээс тусгаарлахад оршино.

53.2. Хорих ялын хугацааг нэг сараас хорин жил хүртэл хугацаагаар тогтооно.

53.3. Нийлмэл гэмт хэрэгт ял ногдуулахад хорих ялын хугацааг заримыг буюу бүгдийг нэмэх буюу нэгтгэхэд хорих ялын хугацаа хорин таван жилээс хэтрэхгүй, харин хэд хэдэн шийтгэх тогтоолоор гучин жилээс хэтэрч болохгүй.

54 дүгээр зүйл. Бүх насаар нь хорих

54.1. Бүх насаар нь хорих ялыг хүний амь насанд халдсан онц хүнд гэмт хэрэг, түүнчлэн нийгмийн аюулгүй байдлын эсрэг онц хүнд гэмт хэрэг үйлдэхэд ногдуулна.

54.2. Бүх насаар нь хорих ялыг эмэгтэй, арван найман нас хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнчлэн шүүхийн шийтгэх тогтоол гаргах үед жаран насанд хүрсэн эрэгтэй хүнд ногдуулахгүй.

55 дугаар зүйл. Хорих ял шийтгүүлэгчид хорих байгууллагын төрлийг хэрэглэх

55.1. Хорих ялыг дараахь байдлаар эдлүүлнэ:

55.1.1. Гэмт хэрэг болгоомжгүй үйлдсэн этгээд, түүнчлэн урьд нь хорих ял эдэлж байгаагүй, хөнгөн ба хүндэвтэр гэмт хэрэг санаатай үйлдэж хорих ял шийтгүүлсэн этгээдийн ялыг нээлттэй ангид эдлүүлнэ. Үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал ба гэм буруутай этгээдийн хувийн байдлыг харгалзан шүүх өмнө дурдсан этгээдийн ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлэхээр гаргасан шийдвэртээ үндэслэгээгээ тодорхойлон ногдуулж болно.

55.1.2. Урьд нь хорих ял эдэлж байгаагүй, хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн эрэгтэй, түүнчлэн хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн, аливаа төрлийн давтан гэмт хэрэг үйлдсэн эмэгтэйн ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.

55.1.3. Урьд нь хорих ял эдэлж байгаагүй, онц хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн эрэгтэй, түүнчлэн хэрэв урьд нь хорих ял эдэлж байсан этгээд давтан буюу аюултай давтан гэмт хэрэг үйлдсэн бол хорих ялыг чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.

55.1.4. Бүх насаар хорих ял шийтгүүлсэн, түүнчлэн онц аюултай давтан гэмт хэрэг үйлдсэн эрэгтэйн ялыг онцгой дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.

55.2. Онц хүнд гэмт хэрэг үйлдэж, таван жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн эрэгтэй, түүнчлэн онц аюултай давтан гэмт хэрэг үйлдсэн бол шүүх ялын эдлээгүй үлдсэн хугацааны зарим хэсгийг гянданд эдлүүлэхээр ногдуулж болох ба ингэхдээ шүүх гянданд ял эдлүүлэх хугацаанд шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болохоос өмнө цагдан хоригдож байсан хугацааг оруулан тооцно.

55.3. Шүүхийн шийтгэх тогтоол гаргах үед арван найман насанд хүрээгүй хорих ял шийтгүүлсэн этгээдийн ялыг хүмүүжүүлэх ангид ногдуулна.

55.4.Хорих байгууллагын төрлийг өөрчлөх явдлыг шүүхээс шүүхийн шийдвэрийн гүйцэтгэх тухай хуульд нийцүүлэн хэрэгжүүлнэ.

56 дугаар зүйл. Цаазаар авах

56.1.Цаазаар авах ял нь ялын онцгой арга хэмжээ бөгөөд гагцхүү хүний амь насанд халдсан онц хүнд гэмт хэрэгт тогтооно.

56.2.Цаазаар авах ялыг эмэгтэй, гэмт хэрэг үйлдэх үед насанд хүрээгүй байсан этгээд, шүүхийн шийтгэх тогтоол гаргах үед жаран нас хүрсэн эрэгтэй хүнд ногдуулахгүй.

56.3.Цаазаар авах ялыг уучлалын журмаар бүх насаар нь хорих буюу хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ялаар сольж болно.

АРАВДУГААР БҮЛЭГ. ЯЛ НОГДУУЛАХ

57 дугаар зүйл. Ял ногдуулах нийтлэг зарчим

57.1.Гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдсон этгээдэд энэхүү Төрөлжсөн хуулийн Ерөнхий ангийн заалтыг баримтлан энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлд заасан хязгаарт нийцүүлсэн шударга ял ногдуулна. Гэмт хэрэг үйлдэхэд ногдуулахаар заасан ялын дотроос хамгийн хатуу төрлийн ялыг гагцхүү хэрэв хатуу бус төрлийн ялаар ялын зорилгыг хангаж чадахааргүй тохиолдолд ногдуулна.

57.2.Гэмт хэрэг үйлдэхэд ногдуулахаар энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлд заасан хамгийн хатуу ялыг энэхүү Төрөлжсөн хуулийн 64, 65 дугаар зүйлд нийцүүлэн нийлмэл гэмт хэрэг ба нийлмэл шийтгэх тогтоолоор ногдуулж болно. Гэмт хэрэг үйлдэхэд ногдуулахаар энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлд заасан хатуу бус ялыг ногдуулах үндэслэлийг энэхүү Төрөлжсөн хуулийн 60 дугаар зүйлээр тодорхойлно.

57.3.Ял ногдуулахдаа гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар ба хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, ялыг хөнгөрүүлэх ба хүндрүүлэх нөхцөл байдал, түүнчлэн ялтныг засан хүмүүжүүлэхэд ногдуулах ялын үр нөлөө ба түүний гэр бүлийн амьдралын нөхцөлийг харгалзан үзнэ.

58 дугаар зүйл. Ял хөнгөрүүлэх нөхцөл байдал

58.1. Шүүх ял ногдуулахдаа дараахь нөхцөл байдлыг ял хөнгөрүүлэх нөхцөл байдал гэж үзнэ:

- 58.1.1. тохиолдлын чанартай нөхцөл байдлын улмаас хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн;
- 58.1.2. насанд хүрээгүй этгээд гэмт хэрэг үйлдсэн;
- 58.1.3. жирэмсэн эмэгтэй гэмт хэрэг үйлдсэн;
- 58.1.4. бага насны хүүхэдтэй этгээд гэмт хэрэг үйлдсэн;
- 58.1.5. амьдралын хүнд нөхцөл байдал тохиолдсон, эсхүл өрөвч сэдэлтээр гэмт хэрэг үйлдсэн;

- 58.1.6. бие махбодийн буюу сэтгэл санааны албадлагын үр дүнд, эсхүл эд хөрөнгийн, албан тушаалын буюу бусад эрхшээлийн улмаас гэмт хэрэг үйлдсэн;
- 58.1.7. аргагүй хамгаалалт, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг албадан саатуулах, гарцаагүй байдал, үндэслэлтэй эрсдэл, тушаал буюу захирамжийг биелүүлэх явдал эрх зүйн дагуу байх нөхцөлийг зөрчиж гэмт хэрэг үйлдсэн;
- 58.1.8. хохирогчийн эрх зүйн бус буюу зан суртахуунгүй зан үйл нь гэмт хэрэг үйлдэх шалтаг болсон;
- 58.1.9. өөрийгөө илчилсэн, гэмт хэргийг илрүүлсэн, гэмт хэргийн бусад хамтран оролцогсдыг илчлэх ба гэмт хэргийн үр дүнд олж авсан эд хөрөнгийг эрэн сурвалжилж олоход идэвхтэй тус дөхөм үзүүлсэн;
- 58.1.10. гэмт хэрэг үйлдсэний дараа хохирогчид шууд эмнэлгийн болон бусад туслалцаа үзүүлсэн, гэмт хэргийн үр дүнд учруулсан эд хөрөнгийн хохирол ба ёс суртахууны гэм хорыг сайн дураараа нөхөн төлсөн, хохирогчид учруулсан гэм хорыг арилгахад чиглэгдсэн бусад үйлдэл үйлдсэн.

58.2. Шүүх ял ногдуулахдаа энэ зүйлийн нэг дэх хэсэгт заагаагүй өөр нөхцөл байдлыг ял хөнгөрүүлэх нөхцөл байдал болгон харгалзан үзэж болно.

58.3. Хэрэв энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлд ял хөнгөрүүлэх нөхцөл байдлыг гэмт хэргийн шинж болгон заасан тохиолдолд ял ногдуулахдаа давтан харгалзан үзэж болохгүй.

58.4. Энэ зүйлийн нэг дэх хэсгийн 9,10-т заасан ял хөнгөрүүлэх нөхцөл байдал байгаа ба харин ял хүндрүүлэх нөхцөл байдалгүй бол ялын хугацаа ба хэмжээг энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлд заасан хамгийн хатуу төрлийн ялын дээд хугацаа буюу хэмжээний дөрөвний гурваас дээш хэтрүүлэн ногдуулж болохгүй.

59 дүгээр зүйл. Ял хүндрүүлэх нөхцөл байдал

59.1. Шүүх ял ногдуулахдаа дараахь нөхцөл байдлыг ял хүндрүүлэх нөхцөл байдал гэж үзнэ:

- 59.1.1. давтан гэмт хэрэг үйлдсэн;
- 59.1.2. гэмт хэрэг үйлдсэний үр дүнд хүнд хор уршиг учруулсан;
- 59.1.3. бүлэг этгээд, урьдчилан тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг буюу гэмт бүлэглэл (гэмт байгууллага)-ийн бүрэлдүүнд орж гэмт хэрэг үйлдсэн;
- 59.1.4. гэмт хэрэг үйлдэхэд онц идэвхтэй үүрэг гүйцэтгэсэн;
- 59.1.5. гэмт хэрэг үйлдэхэд сэтгэцийн хүнд зовиуртай этгээд, эсхүл согтуурсан этгээд, түүнчлэн эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрээгүй этгээдийг татан оролцуулсан;
- 59.1.6. улс төр, үзэл суртал, арьсны өнгө, үндэстний буюу шашны үзэн ядалт буюу дайсагнасан сэдэлтээр гэмт хэрэг үйлдсэн;
- 59.1.7. бусад этгээдийн эрх зүйн дагуухи үйлдлээс өс хонзон авах, түүнчлэн өөр гэмт хэргийг нуух буюу түүнийг үйлдэхийг хөнгөвчлөх зорилгоор гэмт хэрэг үйлдсэн;
- 59.1.8. албаны үүргээ гүйцэтгэсэн буюу олон нийтийн журамт үүргээ биелүүлсэнтэй нь холбогдуулан хохирогч буюу түүний ойрын хүнд холбогдуулан үйлдсэн гэмт хэрэг;

- 59.1.9. зориуд эмэгтэй, жирэмсэн байдалтай нь холбогдуулан, түүнчлэн бага насны, биеэ хамгаалж чадахгүй бусад этгээд, эсхүл гэм буруутай этгээдийн эрхшээлд байсан этгээдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн;
- 59.1.10. онц харгис хэрцгий, зовоох тачаал, тохуурхан даажигнаж, түүнчлэн хохирогчийг тамлаж гэмт хэрэг үйлдсэн;
- 59.1.11. галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, тэдгээрийн дэлбэлэгч буюу дууриамал төхөөрөмж, тусгайлан бэлтгэсэн техник хэрэгсэл, хорт ба радиоидэвхт бодис, эмийн ба хими-эмийн түүхий эдийн бусад бэлдмэл ашиглаж, түүнчлэн бие махбодийн буюу сэтгэл санааны албадлага хэрэглэж гэмт хэрэг үйлдсэн;
- 59.1.12. онц байдал, байгалийн буюу өөр бусад нийтийн гамшгийн нөхцөлд, түүнчлэн нийтийн эмх замбараагүй байдлын үед гэмт хэрэг үйлдсэн;
- 59.1.13. гэм буруутай этгээдэд албан ажлын байдал буюу гэрээний улмаас хүлээлгэсэн итгэлийг ашиглан гэмт хэрэг үйлдсэн;
- 59.1.14. дүрэмт хувцас буюу засгийн төлөөлөгчийн баримт бичгийг ашиглан гэмт хэрэг үйлдсэн.

59.2. Хэрэв энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлд хүндрүүлэх нөхцөл байдлыг гэмт хэргийн шинж болгон заасан тохиолдолд ял ногдуулахдаа давтан харгалзан үзэж болохгүй.

60 дугаар зүйл. Тухайн гэмт хэрэгт зааснаас хөнгөн ял ногдуулах

60.1. Гэмт хэргийн зорилго ба сэдэлт, гэм буруутай этгээдийн гүйцэтгэсэн үүрэг, түүний гэмт хэрэг үйлдэх буюу үйлдсэний дараахь үеийн зан үйл нь гэмт хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээг үлэмж багасгасан бусад нөхцөл байдал, түүнчлэн бүлэг гэмт хэргийн оролцогч тухайн гэмт хэргийг илрүүлэхэд идэвхтэй тус дөхөм үзүүлсэнтэй холбогдсон онцгой нөхцөл байдал байгаа бол энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлд заасан ялын доод хэмжээнээс доош татаж ял ногдуулж болох ба шүүх тухайн зүйлд заасан ялын хамгийн хөнгөн төрлийг ногдуулах ба заавал ногдуулахаар заасан ялын нэмэгдэл төрлийг хэрэглэхгүй байж болно.

60.2. Онцгой гэж ял хөнгөрүүлэх тодорхой нөхцөл байдал ба ийм нөхцөл байдлын нийлбэр цогцыг үзэж болно.

61 дүгээр зүйл. Төгсөөгүй гэмт хэрэгт ял ногдуулах

61.1. Төгсөөгүй гэмт хэрэгт ял ногдуулахдаа шүүх гэмт хэргийг төгсгөлд нь хүргээгүй нөхцөл байдлыг харгалзан үзнэ.

61.2. Бэлтгэсэн гэмт хэрэгт ногдуулах ялын хугацаа буюу хэмжээ нь энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлд заасан хамгийн хатуу төрлийн ялын дээд хугацаа буюу хэмжээний талаас дээш хэтэрч болохгүй.

61.3. Завдсан гэмт хэрэгт ногдуулах ялын хугацаа буюу хэмжээ нь энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлд заасан хамгийн хатуу төрлийн ялын дээд хугацаа буюу хэмжээний дөрөвний гурваас дээш хэтэрч болохгүй.

61.4. Гэмт хэрэгт бэлтгэсэн ба завдсан тохиолдолд цаазаар авах ба бүх насаар хорих ял ногдуулахгүй.

62 дугаар зүйл. Хамтран үйлдсэн гэмт хэрэгт ял ногдуулах

62.1. Хамтран үйлдсэн гэмт хэрэгт ял ногдуулахдаа шүүх хамтран оролцсон гэмт хэрэг үйлдэхэд тухайн этгээдийн бодит оролцооны шинж чанар ба хэр хэмжээ, гэмт хэргийн зорилгод хүрэхэд энэ оролцооны учир холбогдол, учруулсан буюу учруулахуйц боломжтой байсан гэм хорын шинж чанар ба хэр хэмжээнд тухайн этгээдийн үзүүлсэн нөлөөг харгалзан үзнэ.

62.2. Хамтран оролцогчдын хэн нэгний хувийн байдалд хамаарах ял хөнгөрүүлэх буюу ял хүндрүүлэх нөхцөл байдлыг зөвхөн тухайн хамтран оролцогч тус бүрт ял ногдуулахад харгалзан үзнэ.

63 дугаар зүйл. Давтан гэмт хэрэгт ял ногдуулах

63.1. Давтан, аюултай буюу онц аюултай давтан гэмт хэрэгт ял ногдуулахдаа урьд нь үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар ба хэр хэмжээ, өмнөх ял засан хүмүүжүүлэх хангалттай нөлөөлөл үзүүлээгүй нөхцөл байдал, түүнчлэн дахин үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар ба хэр хэмжээг харгалзан үзнэ.

63.2. Аливаа төрлийн давтан гэмт хэрэгт ялын хугацаа нь үйлдсэн гэмт хэрэгт заасан ялын хамгийн хатуу төрлийн дээд хугацааны гуравны нэгээс доош байж болохгүй ба тэгэхдээ энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлийн санкцын хязгаарын хүрээнд байна.

63.3. Аливаа төрлийн давтан гэмт хэрэгт хэрэв энэхүү Төрөлжсөн хуулийн 58 дугаар зүйлд заасан ял хөнгөрүүлэх нөхцөл байдал тогтоогдвол үйлдсэн гэмт хэрэгт заасан хамгийн хатуу төрлийн ялын дээд хугацааны гуравны нэгээс доош ногдуулж болох ба тэгэхдээ энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлийн хязгаарт байх ба энэхүү Төрөлжсөн хуулийн 60 дугаар зүйлд заасан онцгой нөхцөл байгаа бол тухайн гэмт хэрэгт заасан ялаас илүү хөнгөн ял ногдуулж болно.

64 дүгээр зүйл. Нийлмэл гэмт хэрэгт ял ногдуулах

64.1. Нийлмэл гэмт хэрэгт үйлдсэн гэмт хэрэг тус бүрт ял ногдуулна.

64.2. Хэрэв үйлдсэн бүх гэмт хэрэг нийлмэл хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэг байвал хамгийн хатуу ялд ногдуулсан ялын хатуу бус ялын заримыг буюу бүгдийг нэмэх замаар ялыг эцэслэн ногдуулна. Ингэхдээ эцэслэсэн ял нь үйлдсэн гэмт хэргийн хамгийн хатуу ялын дээд хугацаа ба хэмжээний талаас дээш хэтэрч болохгүй.

64.3. Хэрэв үйлдсэн нийлмэл гэмт хэргийн аль нэг нь хүнд буюу онц хүнд гэмт хэрэг байвал заримыг буюу бүгдийг нэмэх замаар эцэслэгдсэн ялыг ногдуулна. Ингэхдээ хорих ялын эцэслэсэн ял нь үйлдсэн гэмт хэргийн хамгийн хатуу ялыг заасан хорих ялын дээд хугацааны талаас дээш хэтэрч болохгүй.

64.4. Нийлмэл гэмт хэргийн нөхцөлд үндсэн ялын төрөлд нэмэгдэл ялын төрлийг нэгтгэж болно. Ялын заримыг буюу бүгдийг нэмэхэд эцэслэсэн нэмэгдэл ял нь энэхүү Төрөлжсөн хуулийн Ерөнхий ангийн тухайн төрлийн ялд заасан дээд хугацаа буюу хэмжээнээс хэтэрч болохгүй.

64.5. Энэ журмаар хэрэв шүүхийн шийтгэх тогтоол гаргасны дараа анхны хэргийн талаар шүүхийн шийтгэх тогтоол гаргахаас өмнө үйлдсэн өөр гэмт хэрэгт гэм буруутай нь тогтоогдвол ял ногдуулж болно. Энэ тохиолдолд эцэслэсэн ялд анхны шийтгэх тогтоолоор эдэлсэн ялыг тооцно.

65 дугаар зүйл. Нийлмэл шийтгэх тогтоолоор ял ногдуулах

65.1. Нийлмэл шийтгэх тогтоолоор ял ногдуулахдаа шүүхийн сүүлчийн шийтгэх тогтоолоор ногдуулсан ялтай өмнөх шийтгэх тогтоолын ялын эдлээгүй үлдсэн хэсгийн заримыг буюу бүгдийг нэгтгэж болно.

65.2. Нийлмэл шийтгэх тогтоолоор эцэслэсэн ял нь хэрэв хорих ялаас хатуу бус ял байгаа тохиолдолд энэхүү Төрөлжсөн хуулийн Ерөнхий ангид заасан тухайн төрлийн ялын дээд хугацаа буюу хэмжээнээс хэтэрч болохгүй.

65.3. Нийлмэл шийтгэх тогтоолоор эцэслэсэн ял нь хорих ял байвал гучин жилээс дээш хэтэрч болохгүй.

65.4. Нийлмэл шийтгэх тогтоолоор ял ногдуулахад эцэслэсэн ял нь өмнөх шийтгэх тогтоолын эдлээгүй үлдсэн ялын хэсгээс их байна.

65.5. Нийлмэл шийтгэх тогтоолоор ногдуулсан нэмэгдэл төрлийн ялыг нэгтгэхдээ энэхүү Төрөлжсөн хуулийн зүйлийн дөрөв дэх хэсэгт заасан журмыг баримтална.

66 дугаар зүйл. Ял нэгтгэхэд түүний хугацааг тодорхойлох журам

66.1. Нийлмэл гэмт хэрэг ба нийлмэл шийтгэх тогтоолоор ялын заримыг ба бүгдийг нэмэхэд хорих ялын нэг өдөр нь:

- 66.1.1. эрх чөлөө хязгаарлах ялын хоёр өдөртөй;
- 66.1.2. засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялын гурван өдөртөй;
- 66.1.3. албадан ажил хийлгэх ялын найман цагтай дүйцсэн байна.

66.2. Торгууль, эсхүл тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл тусгай, цэргийн буюу хүндэт цол, зэрэг дэв ба төрийн шагналыг хасах ялыг эрх чөлөө хязгаарлах, хорих ялтай нэгтгэхдээ тус тусад нь гүйцэтгэнэ.

67 дугаар зүйл. Ялын хугацааг тоолох ба ялд тооцох

67.1. Тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, цэргийн алба хаахыг хязгаарлах, эрх чөлөө хязгаарлах, цэргийн сахилгажуулах ангид явуулах, хорих ялын хугацааг сар өдрөөр, харин албадан ажил хийлгэх ялын хугацааг цагаар тоолно.

67.2. Энэхүү зүйлийн нэг дэх хэсэгт заасан ялыг солих буюу нэгтгэх, түүнчлэн ялын хугацааг тооцохдоо өдрөөр тоолж болно.

67.3. Шүүх хуралдаанаас өмнө урьдчилан хоригдсон нэг өдрийг хорих, цэргийн сахилгажуулах ангид явуулах ялын нэг өдөрт, эрх чөлөө хязгаарлах ялын хоёр өдөрт, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ба цэргийн алба хаахыг хязгаарлах ялын гурван өдөрт, харин албадан ажил хийлгэх ялын найман цагийг урьдчилан хоригдсон нэг өдөрт дүйцүүлэн тооцно.

67.4. Монгол улсын хилийн гадна үйлдсэн гэмт хэрэгт шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болохоос өмнө цагдан хоригдсон ба шүүхийн шийтгэх тогтоолоор ногдуулсан хорих ял эдэлсэн хугацаа, энэхүү Төрөлжсөн хуулийн 13 дугаар зүйлд заасан үндэслэлээр тухайн этгээдийг шилжүүлэн авсан тохиолдолд нэг өдрийг нэг өдөрт дүйцүүлэн тооцно.

67.5. Шүүх хуралдаан болохоос өмнө цагдан хоригдож байсан этгээдэд торгууль, тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах ялыг үндсэн ялын чанартай ногдуулахдаа шүүх цагдан хоригдсон хугацааг харгалзан үзэж, ногдуулсан ялыг хөнгөрүүлэх буюу түүнийг энэ ялыг эдлэхээс бүрмөсөн чөлөөлнө.

68 дугаар зүйл. Ял тэнсэх

68.1. Хэрэв засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эрх чөлөө хязгаарлах, найман жил хүртэл хугацаагаар хорих ял ногдуулахдаа шүүх ялыг биечлэн эдлүүлэхгүйгээр ялтныг засан хүмүүжүүлэх боломжтой гэсэн дүгнэлтэд хүрвэл ногдуулсан ялыг тэнсэхээр тогтоож болно.

68.2. Ялыг тэнсэхдээ шүүх үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар ба хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, түүний дотор ял хөнгөрүүлэх ба хүндрүүлэх нөхцөлийг харгалзан үзнэ.

68.3. Шүүх ялыг тэнсэхдээ хянан харгалзах хугацааны туршид ялтан засрал хүмүүжлээ өөрийнхөө зан үйлээр нотлохуйц хянан харгалзах хугацаа тогтооно. Нэг жил хүртэл хугацаатай хорих ял буюу түүнээс хөнгөн төрлийн ял ногдуулсан тохиолдолд хянан харгалзах хугацаа нь зургаан сараас гурван жил хүртэл, харин нэг жилээс дээш хугацаатай хорих ял ногдуулсан тохиолдолд зургаан сараас таван жил хүртэл хугацаатай байна.

68.4. Шүүх ял тэнсэхдээ нэмэгдэл ял ногдуулж болно.

68.5. Шүүх ял тэнсэхдээ ялтнаас гүйцэтгэх дараахь тодорхой үүргийг түүнд хариуцуулж болно: ялтан өөрийн засрал хүмүүжилд хяналт тавих төрийн тусгай байгууллагад мэдэгдэхгүйгээр оршин суугаа газар, ажлын газар, сургуулиа өөрчлөхгүй байх, тодорхой газарт очихгүй байх, архидалт, мансуурал, донтолтын буюу өнгөний өвчний эмчилгээ хийлгэх, гэр бүлдээ материаллаг дэмжлэг туслалцаа үзүүлэх. Шүүх ялтны засрал хүмүүжилд тус дөхөм болохуйц бусад үүргийг тэнсэгдсэн ялтнаар гүйцэтгүүлэхээр түүнд хариуцуулж болно.

68.6. Тэнсэгдсэн ялтны зан үйлд төрийн тусгай байгууллага хяналт тавина.

68.7. Шүүх хянан харгалзах хугацааны туршид тэнсэгдсэн ялтны зан үйлд хяналт тавих байгууллагын саналаар тэнсэгдсэн ялтанд урьд нь тогтоосон үүргийг бүрэн буюу заримыг нь хүчингүй болгох, эсхүл нэмэгдүүлэн тогтоож болно.

68.8. Хэрэв тэнсэгдсэн ялтан хянан харгалзах хугацаа дуусахаас өмнө өөрийнхөө зан үйлээр засрал хүмүүжлээ нотолж чадвал шүүх тэнсэгдсэн ялтны зан үйлд хяналт тавих байгууллагын саналаар ял тэнсэсэнийг хүчингүй болгох буюу ялтны ялтай байдлыг арилгахаар тогтоож болно. Ингэхдээ тогтоосон хянан харгалзах хугацааны талаас доошгүйг өнгөрсний дараа хүчингүй болгоно.

68.9. Хэрэв тэнсэгдсэн ялтан шүүхээс түүнд хариуцуулсан үүргийг биелүүлэхээс зайлсхийсэн буюу нийгмийн хэв журам зөрчиж, захиргааны шийтгэлийн арга хэмжээ авагдсан бол шүүх энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан байгууллагын саналаар нэгээс доошгүй хугацаагаар хянан харгалзах хугацааг сунгаж болно.

68.10. Тэнсэгдсэн ялтан хянан харгалзах хугацаанд шүүхээс түүнд хариуцуулсан үүргийг байнга эс биелүүлсэн буюу биелүүлэхээс ноцтой зайлсхийсэн, эсхүл хэрэв тэнсэгдсэн ялтан хяналтаас зориуд нуугдсан бол шүүх энэ зүйлийн зургаа дахь хэсэгт заасан байгууллагын саналаар ял тэнссэнийг хүчингүй болгож, шийтгэх тогтоолоор ногдуулсан ялыг эдлүүлэхээр тогтоож болно.

68.11. Тэнсэгдсэн ялтан хянан харгалзах хугацаанд болгоомжгүй гэмт хэрэг, эсхүл хөнгөн гэмт хэрэг санаатай үйлдсэн тохиолдолд ял тэнссэнийг хүчингүй болгох буюу хэвээр үргэлжлүүлэх эсэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

68.12. Тэнсэгдсэн ялтан хянан харгалзах хугацаанд хүндэвтэр, хүнд буюу онц хүнд санаатай гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд шүүх ял тэнссэнийг хүчингүй болгож, түүнд энэхүү Төрөлжсөн хуулийн 65 дугаар зүйлд заасан журмын дагуу ял ногдуулна. Энэ журмыг баримтлан энэхүү зүйлийн арван нэг дэх хэсэгт заасан тохиолдолд ял ногдуулна.

IV ХЭСЭГ. ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА БА ЯЛААС ЧӨЛӨӨЛӨХ

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГААС ЧӨЛӨӨЛӨХ

69 дүгээр зүйл. Үйлдсэн гэмт хэргээ илчилж ирсэнтэй холбогдуулан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх

69.1. Хөнгөн ба хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээд хэрэв гэмт хэрэг үйлдсэний дараа сайн дураараа өөрийгөө илчлэн ирсэн, гэмт хэргийг илрүүлэхэд тус дөхөм үзүүлсэн, учруулсан хохирлоо нөхөн төлсөн буюу гэмт хэргийн үр дүнд учруулсан гэм хорыг бусад байдлаар арилгасан ба чин сэтгэлээсээ гэмшсэний улмаас нийгэмд аюултай байхаа больсон тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

69.2. Өөр ангиллын гэмт хэрэг үйлдсэн этгээдийг зөвхөн энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлд тусгайлан заасан тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

70 дугаар зүйл. Хохирогчтой эвлэрсэнтэй холбогдуулан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх

70.1. Хөнгөн ба хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээд хэрэв хохирогчтой эвлэрсэн ба учруулсан гэм хороо арилгасан тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

71 дүгээр зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөнтэй холбогдуулан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх

71.1. Хэрэв гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш дараахь хугацаа өнгөрсөн бол тухайн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө:

71.1.1. хөнгөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн;

71.1.2. хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн;

71.1.3. хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван жил өнгөрсөн;

71.1.4. 71.1.4 онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван таван жил өнгөрсөн.

71.2. Хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш ба шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болохоос өмнөх хугацаагаар тоолно.

71.3. Хөөн хэлэлцэх хугацааны дотор хэрэв мөрдөн байцаалт ба шүүхээс гэмт хэрэг үйлдсэн этгээд зайлхийсвэл хөөн хэлэлцэх хугацаа зогсоогдоно.

71.4. Цаазаар авах буюу бүх насаар нь хорих ял ногдуулах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ. Цаазаар авах буюу бүх насаар нь хорих ял ногдуулах гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөнтэй холбогдуулан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх боломжгүй гэж шүүх үзвэл цаазаар авах ял ба бүх насаар нь хорих ялд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй.

71.5. Энэхүү Төрөлжсөн хуулийн 326, 329, 330, 331 дүгээр зүйлд заасан энх тайван ба хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЯЛААС ЧӨЛӨӨЛӨХ

72 дугаар зүйл. Ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах

72.1. Хэрэв шүүх цэргийн сахилгажуулах ангид явуулах, хорих ял эдэлж байгаа этгээдийг өөрийн засрал хүмүүжлээрээ шүүхээс ногдуулсан ялыг цаашид бүрэн эдлэх шаардлагагүй болсон гэж үзвэл хугацаанаас өмнө суллана. Ингэхдээ тухайн этгээдийг нэмэгдэл ял эдлэхээс бүрэн буюу заримаас нь чөлөөлж болно.

72.2. Хугацаанаас өмнө тэнсэн суллах журмыг хэрэглэхдээ шүүх энэхүү Төрөлжсөн хуулийн 68 дугаар зүйлийн тав дахь хэсэгт заасан үүргийг ялын эдлээгүй үлдсэн хэсэгт ялтанд хариуцуулан гүйцэтгүүлж болно.

72.3. Хугацаанаас өмнө тэнсэн суллах журмыг зөвхөн ялын тодорхой хувийг эдэлсэний дараа хэрэглэж болно:

- 72.3.1. хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэгт ногдуулсан ялын гуравны нэгээс доошгүй хувийг эдэлсэн;
- 72.3.2. хүнд гэмт хэрэгт ногдуулсан ялын талаас доошгүй хувийг эдэлсэн;
- 72.3.3. онц хүнд гэмт хэрэгт ногдуулсан ялын гуравны хоёроос доошгүй, хэрэв урьд нь хугацаанаас өмнө тэнсэгдсэн нь энэ зүйлийн долоо дахь хэсэгт заасан үндэслэлээр хүчингүй болсон тохиолдолд ногдуулсан ялын гуравны хоёроос доошгүйг эдэлсэн.

72.4. Ялтны хорих ял биечлэн эдэлсэн хугацаа зургаан сараас доош байж болохгүй.

72.5. Бүх насаар нь хорих ял эдэлж байгаа этгээдийн хувьд хэрэв шүүх энэ ялыг цаашид эдлүүлэх шаардлагагүй гэж үзэж, хорих ялын хорин таван жилээс доошгүй хугацааг биечлэн эдэлсэн тохиолдолд хугацаанаас өмнө тэнсэн суллаж болно. Бүх насаар нь хорих ялыг цаашид эдлэхээс хугацаанаас өмнө тэнсэн суллах журмыг гагцхүү өмнөх гурван жилийн хугацаанд ял эдлүүлэх талаар тогтоосон журмыг ноцтой зөрчөөгүй ялтанд хэрэглэнэ. Бүх насаар нь хорих ял эдлэх үед шинээр хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хугацаанаас өмнө тэнсэн суллах журмыг хэрэглэхгүй.

72.6. Хугацаанаас өмнө тэнсэн суллагдсан этгээдийн зан үйлд тавих хяналтыг бүрэн эрх бүхий төрийн тусгай байгууллага хэрэгжүүлнэ.

72.7. Хэрэв ялын үлдсэн хугацаанд:

- 72.7.1. нийгмийн хэв журам зөрчиж, захиргааны шийтгэлийн арга хэмжээ авагдсан буюу хугацаанаас өмнө тэнсэн суллах журмыг хэрэглэх явцад шүүхээс хариуцуулсан үүргийг биелүүлэхээс ноцтой зайлсхийсэн бол шүүх энэ зүйлийн зургаа дахь хэсэгт заасан байгууллагын саналаар хугацаанаас өмнө тэнсэн сулласныг хүчингүй болгож, ялын эдлээгүй үлдсэн хэсгийг эдлүүлэхээр тогтоож болно.
- 72.7.2. болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн ялтны хувьд хугацаанаас өмнө тэнсэн суллах журмыг хүчингүй болгох буюу хэвээр үргэлжлүүлэх эсэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ
- 72.7.3. ялтан санаатай гэмт хэрэг үйлдсэн бол шүүх түүнд энэ Төрөлжсөн хуулийн 65 дугаар зүйлд заасан журмыг баримтлан ял ногдуулна. Гэмт хэрэг болгоомжгүй үйлдсэн тохиолдолд энэ журмыг баримтлан хэрэв шүүх хугацаанаас өмнө тэнсэн суллах журмыг хүчингүй болговол ял ногдуулна.

73 дугаар зүйл. Ялын эдлээгүй үлдсэн хэсгийг хамгийн хөнгөн төрлийн ялаар солих

73.1. Шүүх эрх чөлөө хязгаарлах, цэргийн сахилгажуулах ангид явуулах, хорих ял эдэлж байгаа этгээдийн ял эдлэх явцад түүний зан үйлийг харгалзан ялын эдлээгүй үлдсэн хэсгийг хамгийн хөнгөн төрлийн ялаар сольж болно. Ингэхдээ нэмэгдэл ял эдлүүлэхээс бүрэн бүрэн буюу заримаас нь чөлөөлнө.

73.2. Хорих ял шийтгүүлсэн этгээд ялаа дараахь хугацаагаар биечлэн эдэлсний дараа эдлээгүй үлдсэн ялын хэсгийг хамгийн хөнгөн төрлийн ялаар сольж болно:

- 73.2.1. хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн бол ялын хугацааны гуравны нэгээс доошгүйг эдэлсэн;
- 73.2.2. хүнд гэмт хэрэг үйлдсэн бол ялын талаас доошгүйг эдэлсэн;
- 73.2.3. онц хүнд гэмт хэрэг үйлдсэн бол ялын гуравны хоёроос доошгүйг эдэлсэн.

73.3. Ялын эдлээгүй үлдсэн хэсгийг солихдоо шүүх энэхүү Төрөлжсөн хуулийн 44 дүгээр зүйлд заасан ялын төрөлд нийцүүлэн ялын төрөл бүрийг заасан хязгаарын хүрээнд аливаа хамгийн хөнгөн ялын төрлийг сонгон хэрэглэж болно.

74 дүгээр зүйл. Нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй холбогдуулан ялаас чөлөөлөх

74.1. Хэрэв нөхцөл байдал өөрчлөгдсөн буюу түүний үйлдсэн гэмт хэрэг нийгэмд аюултай байхаа больсон нь тогтоогдвол шүүх хөнгөн ба хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээдийг ялаас чөлөөлж болно.

75 дугаар зүйл. Өвчний учир ялаас чөлөөлөх

75.1. Гэмт хэрэг үйлдсэний дараа сэтгэцийн зовиуртай болж, өөрийн үйлдлийн бодит шинж чанар ба нийгмийн аюулын байдлыг ухамсарлах, эсхүл түүнийгээ удирдан жолоодох чадваргүй болсон этгээдийг ялаас чөлөөлөх ба харин ял эдэлж буй этгээдийг ял эдлэхээс чөлөөлнө. Ийм этгээдэд шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

75.2. Гэмт хэрэг үйлдсэний дараа ял эдлүүлэхэд саад болохуйц өөр өвчнөөр өвчилсөн этгээдийг ял эдлэхээс шүүх чөлөөлж болно.

75.3. Цэргийн сахилгажуулах ангид ял эдэлж байгаа цэргийн албан хаагч цэргийн алба хаахад цаашид харшлах өвчнөөр өвчилсөн тохиолдолд ял эдлэхээс чөлөөлнө.

75.4. Энэ зүйлийн хоёр дахь хэсэгт заасан этгээд эрүүл болсон тохиолдолд хэрэв энэхүү Төрөлжсөн хуулийн 71, 77 дугаар зүйлд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрөөгүй тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэж ба ял ногдуулж болно.

76 дугаар зүйл. Жирэмсэн ба бага насны хүүхэдтэй эмэгтэйн ял эдлүүлэхийг хойшлуулах

76.1. Хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг хүнд буюу онц гэмт хэрэгт таваас дээш жилийн хугацаатай хорих ял шийтгүүлснээс бусад тохиолдолд ял шийтгүүлсэн жирэмсэн эмэгтэй, арван дөрөв хүртлэх насны хүүхэд бүхий эмэгтэй ялтанд шүүх хүүхдийг нь арван дөрвөн нас хүрэхээс өмнө биечлэн эдлэх ялыг нь хойшлуулж болно.

76.2. Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасны дагуу ял эдлүүлэхийг хойшлуулсан ялтан хэрэв хүүхдээсээ татгалзсан буюу ялтны зан үйлд хяналт тавих байгууллагаас урьдчилан анхааруулсаар байтал хүүхдээ хүмүүжүүлэхээс зайлсхийснээ үргэлжлүүлбэл энэ байгууллагын саналаар ял эдлүүлэхийг хойшлуулсныг хүчингүй болгож, шүүхийн шийтгэх тогтоолд нийцүүлэн ялтанд ногдуулсан ялыг эдлүүлнэ.

76.3. Хүүхдийг нь арван дөрвөн нас хүрсний дараа шүүх ялтныг ял эдлүүлэхээс чөлөөлөх, эсхүл ялын эдлээгүй үлдсэн хэсгийг хамгийн хөнгөн төрлийн ялаар солино.

76.4. Хэрэв ял эдлүүлэхийг хойшлуулсан хугацаанд ялтан шинээр гэмт хэрэг үйлдсэн бол шүүх энэхүү Төрөлжсөн хуулийн 65 дугаар зүйлд заасан журмыг баримтлан түүнд ял ногдуулна.

77 дугаар зүйл. Шүүхийн шийтгэх тогтоолын хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөнтэй холбогдуулан ял эдлэхээс чөлөөлөх

77.1. Хэрэв шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш дараахь хугацаанд биелэгдээгүй бол тухайн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг ял эдлүүлэхээс чөлөөлнө:

- 77.1.1. хөнгөн гэмт хэрэгт ял шийтгүүлж, нэг жил өнгөрсөн;
- 77.1.2. хүндэвтэр гэмт хэрэгт ял шийтгүүлж таван жил өнгөрсөн;
- 77.1.3. хүнд гэмт хэрэгт ял шийтгүүлж арван жил өнгөрсөн;
- 77.1.4. онц хүнд гэмт хэрэгт ял шийтгүүлж арван таван жил өнгөрсөн.

77.2. Хэрэв ялтан ял эдлэхээс зайлсхийсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа зогсоогдоно. Энэ тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг ялтныг албадан саатуулсан буюу ялтан өөрийгөө илчилж ирсэн үеэс сэргээн тоолно. Ялтан ял эдлэхээс зайлсхийсэн үед өнгөрсөн хөөн хэлэлцэх хугацааг тооцно.

77.3. Цаазаар авах буюу бүх насаар нь хорих ялаар шийтгүүлсэн ялтанд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ. Хэрэв шүүх эдгээр төрлийн ялд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх боломжгүй гэж үзвэл тодорхой хугацаатай хорих ялаар солино.

77.4. Энэхүү Төрөлжсөн хуулийн 326, 329, 330, 331 дүгээр зүйлд заасан энх тайван ба хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ. ӨРШӨӨЛ. УУЧЛАЛ. ЯЛТАЙ БАЙДАЛ

78 дугаар зүйл. Өршөөл

78.1. Өршөөлийг тодорхой бус хүрээний этгээдэд Монгол Улсын Их Хурал үзүүлнэ.

78.2. Өршөөл үзүүлэх тухай хуулиар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно. Гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн этгээдийг ялаас чөлөөлж, эсхүл түүнд ногдуулсан ялыг багасгаж буюу хамгийн хөнгөн төрлийн ялаар сольж, эсхүл нэмэгдэл ялаас чөлөөлж болно. Өршөөл үзүүлэх тухай хуулиар ял эдэлсэн этгээдийг ялгүйд тооцож болно.

79 дүгээр зүйл. Уучлал

79.1. Уучлалыг тодорхой этгээдэд нэг бүрчлэн Монгол Улсын Ерөнхийлөгч үзүүлнэ.

79.2. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд уучлал үзүүлэх тухай актаар гэмт хэрэгт ял шийтгэгдсэн этгээдийг цаашид ялаас чөлөөлж, эсхүл түүнд ногдуулсан ялыг багасгаж буюу хамгийн хөнгөн төрлийн ялаар сольж болно. Уучлал үзүүлэх тухай актаар ял эдэлсэн этгээдийг ялгүйд тооцож болно.

80 дугаар зүйл. Ялтай байдал

80.1. Ялтай байдал гэж гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийг шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ялгүй болох буюу ялгүйд тооцох хүртлэх үеийг үзнэ. Энэхүү Төрөлжсөн хуульд заасны дагуу давтан гэмт хэрэг ба ял ногдуулахад ялтай байдлыг харгалзан үзнэ.

80.2. Ялаас чөлөөлөгдсөн этгээдийг ялтай байдалгүй гэж үзнэ.

80.3. Дараахь хугацаа өнгөрвөл ялгүй болсон гэж үзнэ:

- 80.3.1. ял тэнсэгдсэн этгээдийн хувьд хянан харгалзах хугацаа өнгөрсөн;
- 80.3.2. хорихоос хөнгөн төрлийн ял шийтгүүлсэн этгээдийн хувьд ял эдэлсэн буюу ял гүйцэтгэснээс хойш нэг жилийн хугацаа өнгөрсөн;
- 80.3.3. хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэгт хорих ял шийтгүүлсэн этгээдийн хувьд ял эдэлсэний дараа хоёр жилийн хугацаа өнгөрсөн;
- 80.3.4. хүнд гэмт хэрэгт хорих ял шийтгүүлсэн этгээдийн хувьд ял эдэлсэний дараа таван жилийн хугацаа өнгөрсөн;
- 80.3.5. онц хүнд гэмт хэрэгт хорих шийтгүүлсэн этгээдийн хувьд ял эдэлсэний дараа найман жилийн хугацаа өнгөрсөн.

80.4. Хэрэв хуулиар тогтоосон журмын дагуу ял эдлэхээс хугацааны өмнө суллагдсан буюу ялын эдлээгүй үлдсэн хэсэг нь өөр хөнгөн төрлийн ялаар солигдсон этгээдийн хувьд үндсэн ба нэмэгдэл ял эдлэхээс чөлөөлөгдсөн үеэс биечлэн эдэлсэн ялын хугацааг тоолно.

80.5. Хэрэв ял шийтгүүлсэн этгээд ял эдэлсний дараа өөрийн засрал хүмүүжлээрээ үлгэр жишээч байдлаа харуулсан тохиолдолд түүний хүсэлтээр шүүх ялтай байдлын хугацаа дуусахаас өмнө ялгүйд тооцно.

80.6. Ялгүй болсон буюу ялгүйд тооцсоноор ялтай байдалтай холбогдсон эрх зүйн бүх үр дагавар арилна.

V ХЭСЭГ. НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮНД ХҮЛЭЭЛГЭХ ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮНД ХҮЛЭЭЛГЭХ ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА БА ЯЛЫН ОНЦЛОГ

81 дүгээр зүйл. Насанд хүрээгүй хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага

81.1. Насанд хүрээгүй гэж гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн боловч арван найман насанд хүрээгүй этгээдийг үзнэ.

81.2. Шүүх гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй этгээдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, эсхүл түүнд ял ногдуулах ба ялаас чөлөөлж боловсролын сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад байлгаж болно.

82 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүнд ногдуулах ялын төрөл

81.1. Шүүх насанд хүрээгүй этгээдэд дараахь төрлийн ял ногдуулна:

- 82.1.1. торгууль;
- 82.1.2. тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах;
- 82.1.3. албадан ажил хийлгэх;
- 82.1.4. засан хүмүүжүүлэх ажил хийлгэх;
- 82.1.5. хугацаатай хорих ял.

82.2. Торгуулийг бие даасан цалин хөлстэй буюу гаргуулж болох эд хөрөнгөтэй эсэхээс үл шалтгаалан насанд хүрээгүй этгээдэд ногдуулна. Насанд хүрээгүй этгээдэд ногдуулсан торгуулийг түүний эцэг эх буюу хууль ёсны бусад төлөөлөгчөөс тэдний зөвшөөрөлтэйгээр шүүхийн шийдвэрийн дагуу гаргуулж болно. Торгуулийг тавин мянгаас хоёр зуун мянган төгрөг буюу насанд хүрээгүй ялтны хоёр долоо хоногоос зургаан сар хүртлэх үеийн цалин хөлс ба бусад орлогын хэмжээгээр ногдуулна.

82.3. Албадан ажил хийлгэх ялын агуулга нь насанд хүрээгүй этгээдээр чадах чинээний ажлыг хийлгэх, түүнийг хичээл сургууль буюу үндсэн ажлаас нь чөлөөт үед дөчөөс нэг зуун жаран цаг хүртэл хугацаагаар гүйцэтгүүлэхэд оршино. Энэхүү төрлийн ялын үргэлжлэл нь арван тав хүртлэх насны хүүхдэд өдөрт хоёр цагаас хэтрэхгүй, арван таваас арван найм хүртлэх насны этгээдэд өдөрт гурав хүртэл цаг байна.

82.4. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг нэг жил хүртэл хугацаагаар насанд хүрээгүй хүнд ногдуулна.

82.5. Хорих ялыг арван зургаан насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээдэд зургаан жил хүртэл хугацаагаар ногдуулна. Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, түүнчлэн үлдсэн насанд хүрээгүй этгээдэд арав жил хүртэл хугацаатай хорих ял ногдуулж, хүмүүжүүлэх ангид ялыг нь эдлүүлнэ. Арван зургаан нас хүрэхээс өмнө хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэг анх

удаа үйлдсэн этгээд, түүнчлэн хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн насанд хүрээгүй бусад этгээдэд хорих ял ногдуулж болохгүй.

82.6. Хүнд эсхүл онц хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй этгээдэд хорих ял ногдуулахдаа энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлд заасан ялын доод хязгаарыг тал хувиар багасгана.

82.7. Хэрэв ял нь тэнсэгдсэн насанд хүрээгүй ялтан хянан харгалзах хугацааны дотор онц хүнд бус шинэ гэмт хэрэг үйлдсэн бол шүүх хэргийн нөхцөл байдал ба гэм буруутай этгээдийн хувийн байдлыг харгалзан ял тэнсэх тухай шийдвэрийг давтан гаргаж, шинээр хянан харгалзах хугацаа тогтоож, энэхүү Төрөлжсөн хуулийн 68 дугаар зүйлийн тав дахь хэсэгт заасан тодорхой үүргийг гүйцэтгүүлэхээр тэнсэгдсэн ялтанд хариуцуулж болно.

82.8. Насанд хүрээгүй ялтантай харьцахдаа түүний хувийн байдлын тодорхой онцлогыг харгалзан үзэх тухай заалтыг шүүх ял эдлүүлэх байгууллагад өгч болно.

83 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүнд ял ногдуулах

83.1. Насанд хүрээгүй хүнд ял ногдуулахдаа шүүх энэхүү Төрөлжсөн хуулийн 57 дугаар зүйлд заасан нөхцөл байдлын зэрэгцээ түүний амьдрал ба хүмүүжлийн нөхцөл, сэтгэцийн хөгжлийн хүрсэн түвшин, хувийн бусад онцлог байдал, түүнчлэн ах насны хүнээс түүнд үзүүлсэн нөлөөг харгалзан үзнэ.

83.2. Ял хөнгөрүүлэх нөхцөл байдал болсон насанд хүрээгүй байдлыг ял хөнгөрүүлэх ба хүндрүүлэх бусад нөхцөл байдалтай нийлбэр цогцоор нь харгалзан үзнэ.

84 дүгээр зүйл. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ

84.1. Хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүнийг хэрэв хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх замаар засан хүмүүжүүлэх зорилгод хүрэх боломжтой гэж үзвэл эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

84.2. Насанд хүрээгүй хүнд хүмүүжлийн чанартай албадлагын дараахь арга хэмжээ хэрэглэж болно:

- 84.2.1. урьдчилан сануулах. Энэ нь насанд хүрээгүй хүний учруулсан гэм хор ба энэхүү Төрөлжсөн хуульд заасан гэмт хэргийг хэрэв давтан үйлдвэл түүнээс үүсэх үр дагаврыг тайлбарлан таниулахад оршино;
- 84.2.2. эцэг эх буюу тэднийг орлох бусад этгээд, эсхүл төрийн тусгай байгууллагын хяналтад шилжүүлэх. Энэ нь дурдсан этгээд, эсхүл байгууллагаас насанд хүрээгүй хүнд хүмүүжлийн нөлөөлөл үзүүлэх ба түүний зан үйлд хяналт тавих үүрэг хүлээлгэхэд оршино;
- 84.2.3. учруулсан гэм хорыг арилгах үүрэг хариуцуулах. Энэ нь учруулсан гэм хорыг арилгах үүргийг насанд хүрээгүй хүний эд хөрөнгийн байдал ба түүнд байгаа хөдөлмөрийн зохих дадлыг харгалзан хариуцуулахад оршино;
- 84.2.4. чөлөөт цагийг нь хязгаарлах ба насанд хүрээгүй хүний зан үйлд онцгой шаардлага тогтоох. Энэ нь тухайн насанд хүрээгүй хүнийг тодорхой газарт очих, чөлөөт цагийн тодорхой хэлбэрийг ашиглах түүний дотор механик техник хэрэгсэл жолоодохтой холбогдсон үйл ажиллагааг хориглох, хоногт тодорхой хугацаанд гэрээсээ гадагш гарах, төрийн тусгай байгууллагын

зөвшөөрөлгүйгээр өөр газар явахыг хязгаарлах зэргээс бүрдэнэ. Эдгээрийг бүрэн төгс жагсаалт гэж үзэхгүй.

84.3. Насанд хүрээгүй хүнд нэгэн зэрэг хэд хэдэн хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ ногдуулж болно. Энэ зүйлийн хоёр дахь хэсгийн “2”, “4”-т заасан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх хугацааг хөнгөн гэмт хэрэгт нэг сараас хоёр жил хүртэл, хүндэвтэр гэмт хэрэгт зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар тогтооно.

86.4. Насанд хүрээгүй хүн хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг байнга эс биелүүлсэн тохиолдолд энэ арга хэмжээг төрийн тусгай байгууллагын саналаар цуцалж, насанд хүрээгүй хүнийг эрүүгийн хариуцлагад татуулахаар материалыг холбогдох байгууллагад шилжүүлнэ.

85 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүнийг ялаас чөлөөлөх

85.1. Хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн насанд хүрээгүй этгээдэд энэхүү Төрөлжсөн хуулийн 84 дүгээр зүйлийн хоёр дахь хэсэгт заасан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэн шүүх ялаас чөлөөлж болно.

85.2. Хүндэвтэр, түүнчлэн хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүнийг шүүх ялаас чөлөөлж, боловсролын сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад байлгаж болно. Насанд хүрээгүй хүнийг засан хүмүүжүүлэх зорилгоор сурган хүмүүжүүлэх зүйн тусгай арга барил ба хүмүүжил, сургалтын онцгой нөхцөл бүхий албадлагын арга хэмжээ болох боловсролын сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад байлгаж болно. Насанд хүрээгүй хүнийг дурдсан байгууллагад арван найман нас хүртэл нь тэгэхдээ гурван жил хүртэл хугацаагаар байлгана.

85.3. Насанд хүрээгүй хүнийг боловсролын сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад байлгах явдлыг шүүхээс тогтоосон хугацаа дуусахаас өмнө хэрэв шүүх насанд хүрээгүй хүнд энэ арга хэмжээг хэрэглэх шаардлагагүй гэж үзвэл зогсоож болно.

85.4. Боловсролын сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад байлгах хугацааг зөвхөн насанд хүрээгүй хүн ерөнхий боловсролын сургалт болон мэргэжлийн бэлтгэлээ дуусгах зайлшгүй шаардлагатай тохиолдолд түүний хүсэлтээр сунгана.

85.5. Энэхүү Төрөлжсөн хуулийн 100 дугаар зүйлийн нэг ба хоёр дахь хэсэг, 112 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг, 117 дугаар зүйлийн гурав дахь хэсэг, 136 дугаар зүйл, 137 дугаар зүйлийн гурав дахь хэсэг, 148 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг, 149 дүгээр зүйлийн хоёр дахь хэсэг, 153 дугаар зүйлийн дөрөв дэх хэсэг, 156 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг, 157 дугаар зүйлийн нэг ба хоёр дахь хэсэг, 192 дугаар зүйлийн нэг дэх хэсэг, 193 дугаар зүйлийн нэг хэсэг, 195 дугаар зүйлийн нэг дэх хэсэг, 197 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг, 198 дугаар зүйлийн нэг дэх хэсэг, 209 дүгээр зүйлийн хоёр ба гурав дахь хэсэг, 212 дугаар зүйлийн нэг ба хоёр дахь хэсэг, 214 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг, 216 дугаар зүйлийн нэг ба хоёр дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүнийг энэхүү зүйлийн хоёр дахь хэсэгт заасан журмаар ялаас чөлөөлөхгүй.

86 дугаар зүйл. Ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах

86.1. Ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах журмыг насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн этгээдэд дараахь хугацаагаар ялаа биечлэн эдэлсний дараа хэрэглэнэ:

- 86.1.1. хөнгөн буюу хүндэвтэр, эсхүл хүнд гэмт хэрэгт шүүхээс ногдуулсан ялын хугацааны гуравны нэгээс доошгүйг эдэлсэн;
- 86.1.2. онц хүнд гэмт хэрэгт шүүхээс ногдуулсан ялын гуравны хоёроос доошгүйг эдэлсэн.

87 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа

87.1. Энэхүү Төрөлжсөн хуулийн 71, 77 дугаар зүйлд заасан хөөн хэлэлцэх хугацааг насанд хүрээгүй хүний хувьд эрүүгийн хариуцлага ба ялаас чөлөөлөхдөө тал хувиар багасгана.

88 дугаар зүйл. Ялтай байдал арилах хугацаа

88.1. Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэхүү Төрөлжсөн хуулийн 80 дугаар зүйлд заасан ялтай байдлын хугацааг дараахь байдлаар багасгана:

- 88.1.1. хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэгт хорих ял эдэлсэнээс хойш нэг жилийн хугацаа өнгөрсөн;
- 88.1.2. хүнд буюу онц хүнд гэмт хэрэгт хорих ял эдэлсэнээс хойш гурван жил өнгөрсөн.

89 дүгээр зүйл. Арван наймаас хорин настай этгээдэд энэ бүлгийн заалтыг хэрэглэх

89.1. Үйлдсэн гэмт хэргийн шинж чанар ба хувийн байдлыг харгалзан шүүх онцгой тохиолдолд энэ бүлгийн заалтыг гэмт хэрэг үйлдсэн арван найман насанд хүрээгүй хүнд боловсролын сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага буюу хүмүүжүүлэх ангид байгаагаас бусад этгээдэд хорин нас хүртэл нь хэрэглэж болно.

VI ХЭСЭГ. ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЖТЭЙ БУСАД АРГА ХЭМЖЭЭ

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ. ЭМНЭЛГИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ

90 дүгээр зүйл. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх үндэслэл, зорилго

90.1. Шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг дараахь этгээдийн хувьд ногдуулж болно:

- 90.1.1. энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадваргүй этгээд;
- 90.1.2. гэмт хэрэг үйлдсэний дараа ял ногдуулах буюу гүйцэтгэх боломжгүй болохуйц байдалд сэтгэцийн зовиуртай болсон этгээд;
- 90.1.3. гэмт хэрэг үйлдэж, хэрэг хариуцах чадвартай боловч сэтгэцийн зовиураар шаналж байгаа этгээд.

90.2. Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зөвхөн сэтгэцийн зовиур нь энэ этгээдээс өөр ноцтой гэм хор учруулах боломжтой, эсхүл өөртөө буюу бусдад аюултай байгаа тохиолдолд ногдуулж болно.

90.3. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг гүйцэтгэх журмыг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай Монгол улсын хуулиар зохицуулна.

90.4. Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан ба сэтгэцийн байдал нь нийгэмд аюулгүй этгээдийн хувьд шүүх Монгол улсын эрүүл мэндийн хууль тогтоомжид заасан журмын дагуу тухайн этгээдийг эмчлүүлэх буюу нийгмийн халамжийн сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагад байлгах тухай шийдвэр гаргуулахаар эрүүл мэндийн холбогдох байгууллагад зайлшгүй шаардлагатай материалыг шилжүүлж болно.

90.5. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх зорилго нь энэхүү Төрөлжсөн хуулийн 90 дүгээр зүйлд заасан этгээдийг эмчлэх буюу түүний сэтгэцийн байдлыг илааршуулах, түүнчлэн энэхүү Төрөлжсөн хуулийн Тусгай ангийн холбогдох зүйлд заасан шинэ гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино.

91 дүгээр зүйл. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл

91.1. Шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний дараахь төрлийг ногдуулж болно:

- 91.1.1. амбулаторийн албадан хяналт ба сэтгэцийн эмгэг судлаачаар эмчлүүлэх;
- 91.1.2. сэтгэцийн эмгэг судлалын эмнэлгийн ердийн тасагт албадан эмчлэх;
- 91.1.3. сэтгэцийн эмгэг судлалын эмнэлгийн тусгай тасагт албадан эмчлэх;
- 91.1.4. сэтгэцийн эмгэг судлалын эмнэлгийн тусгай тасагт эрчимт хяналтын дор албадан эмчлэх.

91.2. Хэрэг хариуцах чадвартай байдалд үйлдсэн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдийн хэрэг хариуцах чадварыг үгүйсгээгүй сэтгэцийн зовиурыг эмчлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд шүүх амбулаторийн албадан хяналт ба сэтгэцийн эмгэг судлаачаар эмчлүүлэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

92 дугаар зүйл. Амбулаторийн албадан хяналт ба сэтгэцийн эмгэг судлаачаар эмчлүүлэх

92.1. Амбулаторийн албадан хяналт ба сэтгэцийн эмгэг судлаачаар эмчлүүлэхийг хэрэв тухайн этгээдийн сэтгэцийн байдал нь сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт хэвтүүлэх шаардлагагүй ба энэхүү Төрөлжсөн хуулийн 90 дүгээр зүйлд заасан үндэслэл байгаа тохиолдолд ногдуулж болно.

93 дугаар зүйл. Сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт албадан эмчлэх

93.1. Сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт энэхүү Төрөлжсөн хуулийн 90 дүгээр зүйлд заасан үндэслэл байгаа бөгөөд хэрэв тухайн этгээдийн сэтгэцийн зовиурын шинж чанар нь эмчлэх, асрах, тэжээн тэтгэх ба ажиглалтын нөхцөлийг зөвхөн сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт албадан эмчлүүлэхээр ногдуулж болно.

93.2. Сэтгэцийн байдал ба сэтгэцийн эмгэг судлалын эмнэлгийн эмчилгээ буюу ажиглалт нь эрчимт ажиглалт шаардахааргүй тохиолдолд сэтгэцийн эмгэг судлалын эмнэлгийн ердийн тасагт албадан эмчлүүлэхээр ногдуулж болно.

93.3. Сэтгэцийн байдал нь эмнэлгийн байнгын ажиглалт шаардахуйц байгаа этгээдийг сэтгэцийн эмгэг судлалын эмнэлгийн тусгай тасагт албадан эмчлүүлэхээр ногдуулж болно.

93.4. Сэтгэцийн байдал нь өөрт нь буюу бусад этгээдэд онцгой аюул учруулж байгаа ба байнгын, эрчимт ажиглалт шаардахаар байгаа тохиолдолд сэтгэцийн эмгэг судлалын эмнэлгийн эрчимт ажиглалт бүхий тусгай тасагт албадан эмчлүүлэхээр ногдуулж болно.

94 дүгээр зүйл. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхийг сунгах, өөрчлөх ба зогсоох

94.1. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг сунгах, өөрчлөх ба зогсоохыг сэтгэцийн эмгэг судлалын эмч нарын магадлан тогтоох комиссын дүгнэлтийг үндэслэн албадан эмчилгээ хийж байгаа байгууллагын захиргааны саналаар шүүх хэрэгжүүлнэ.

94.2. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зогсоох буюу өөрчлөх тухай шүүхэд санал оруулах үндэслэл байгаа эсэхийг шийдвэрлэхийн тулд зургаан сард нэгээс доошгүй удаа сэтгэцийн эмгэг судлалын эмч нарын магадлан тогтоох комиссын үзлэгт оруулна. Ийм үзлэгийг эмчлүүлэх явцад хэрэв эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх, эсхүл түүнийг зогсоох зайлшгүй шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн тохиолдолд эмчлэгч эмчийн санаачилгаар, түүнчлэн тухайн этгээд, түүний хууль ёсны төлөөлөгч ба (буюу) ойрын төрөл садны хүсэлтээр хийнэ. Хүсэлтийг албадан эмчилгээ хийж байгаа байгууллагын захиргаагаар дамжуулан сүүлчийн үзлэгийн цаг хугацаанаас хамаарахгүйгээр гаргана. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхийг зогсоох буюу өөрчлөх үндэслэл байхгүй бол албадан эмчилгээ хийж байгаа байгууллагын захиргаа шүүхэд албадан эмчилгээг сунгах тухай дүгнэлт гаргана. Албадан эмчилгээний анхны сунгалтыг эмчилгээ эхэлснээс хойш зургаан сарын дараа хийх бөгөөд албадан эмчилгээний дараагийн сунгалтыг жил бүр хийнэ.

94.3. Тухайн этгээдийн сэтгэцийн байдалд урьд ногдуулсан арга хэмжээг хэрэглэх зайлшгүй шаардлагагүй болох, эсхүл эмнэлгийн чанартай албадлагын өөр арга хэмжээг ногдуулах зайлшгүй шаардлага үүсэх тохиолдолд шүүхээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхийг зогсоох буюу өөрчилнө.

94.4. Сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт албадан эмчлэхийг зогсоох тохиолдолд шүүх албадан эмчилгээнд байгаа этгээдийн хувьд холбогдох зайлшгүй шаардлагатай материалыг эрүүл мэндийн тухай Монгол улсын хууль тогтоомжид заасан журмын дагуу нийгмийн халамжийн сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагад, түүнийг эмчлүүлэх буюу байлгах тухай асуудлыг шийдвэрлүүлэхээр эрүүл мэндийн байгууллагад шилжүүлж болно.

95 дугаар зүйл. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн хугацааг тооцох

95.1. Гэмт хэрэг үйлдсэний дараа тухайн этгээдийн сэтгэцийн зовиур эдгэрсэн тохиолдолд ял ногдуулах буюу түүний гүйцэтгэлийг сэргээх үед сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт эмчлэх албадлагын арга хэмжээ хэрэглэсэн хугацааг ялын хугацаанд оруулахдаа сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт байсан нэг өдрийг хорих ялын нэг өдөрт дүйцүүлэн тооцно.

96 дугаар зүйл. Ял эдлүүлэхтэй нэгтгэсэн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ

96.1. Энэхүү Төрөлжсөн хуулийн 91 дүгээр зүйлийн хоёр дахь хэсэгт заасан тохиолдолд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хорих ял эдлүүлэх газарт, харин өөр төрлийн ял эдэлж буй ялтанд амбулаториор сэтгэцийн эмгэг судлалын тусламж үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагад гүйцэтгэнэ.

96.2. Ялтны сэтгэцийн байдал нь сэтгэцийн эмгэг судлалын эмнэлгийн эмчилгээ, сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт ялтныг байлгах буюу эмнэлгийн өөр байгууллага шаардлагатай байдлаар өөрчлөгдөхөд эрүүл мэндийн тухай Монгол улсын хууль тогтоомжид заасан журам ба үндэслэлийг баримтална.

96.3. Өмнө дурдсан байгууллагад байсан хугацааг ял эдэлсэн хугацаанд оруулан тооцно. Өмнө дурдсан байгууллагад ялтныг цаашид эмчлэх шаардлагагүй болоход хасалтыг эрүүл мэндийн тухай Монгол улсын хууль тогтоомжид заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

96.4. Ял эдлүүлэхтэй нэгтгэсэн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхийг зогсоохыг сэтгэцийн эмгэг судлалын эмч нарын магадлан тогтоох комиссын дүгнэлтийг үндэслэн ял эдлүүлж байгаа байгууллагын саналаар шүүх гүйцэтгэнэ.

АРВАН ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ЭД ХӨРӨНГӨ ХУРААХ

97 дугаар зүйл. Эд хөрөнгө хураах

97.1. Эд хөрөнгө хураах гэж дараахь эд хөрөнгийг шүүхийн шийдвэрээр үнэ төлбөргүйгээр, төрийн өмчид албадан авахыг үзнэ:

- 97.1.1. Энэхүү Төрөлжсөн хуулийн 100 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг, 106 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг, 133, 134 дүгээр зүйл, 136 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг, 138, 139, 159, 178, 179, 180 дугаар зүйл, 191 дүгээр зүйлийн гурав ба дөрөв дэх хэсэг, 192, 193, 195, 196, 197, 199, 208, 214, 216, 218, 219, 221, 226, 227, 228, 229, 255, 257, 258, 259, 261, 264, 269, 328 дугаар зүйл, 332 дугаар зүйлийн гурав дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэний үр дүнд олж авсан хууль ёсны өмчлөгчид нь буцаан өгвөл зохих эд хөрөнгө ба орлогоос бусад мөнгө, үнэт зүйлс ба өөр эд хөрөнгө ба аливаа орлого;
- 97.1.2. гэмт хэрэг үйлдсэний үр дүнд олж авсан мөнгө, үнэт зүйлс ба бусад эд хөрөнгө ба энэ эд хөрөнгийн заримыг буюу бүгдийг хувиргасан буюу өөрчилснөөс олсон орлого;
- 97.1.3. терроризм, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл (гэмт байгууллага)-ийг санхүүжүүлэхэд ашигласан буюу зориулагдсан мөнгө, үнэт зүйлс ба бусад эд хөрөнгө;
- 97.1.4. яллагдагчид хамаарах гэмт хэрэг үйлдсэн зэвсэг, тоног төхөөрөмж буюу бусад хэрэгсэл.

97.2. Хэрэв гэмт хэрэг үйлдсэний үр дүнд олж авсан эд хөрөнгө ба (буюу) энэ эд хөрөнгийн орлого нь хууль ёсны замаар олж авсан эд хөрөнгөтэй нийлсэн, холилдсон

тохиолдолд гэмт хэрэг үйлдсэний үр дүнд олж авсан эд хөрөнгө ба түүний орлогын өртөгтэй тэнцэхүйц хэсгийг хураан авна.

97.3. Ялтнаас өөр этгээдэд (байгууллагад) шилжүүлсэн энэ зүйлийн нэг ба хоёр дахь хэсэгт заасан эд хөрөнгийг хэрэв тухайн эд хөрөнгийг хүлээн авсан этгээд гэмт үйлдлийн замаар олж авсан болохыг мэдсэн буюу мэдэх ёстой байсан бол хурааж авна.

98 дугаар зүйл. Эд хөрөнгийн оронд мөнгө хураан авах

98.1. Хэрэв энэхүү Төрөлжсөн хуулийн 97 дугаар зүйлд заасан эд хөрөнгөд хамаарах тодорхой зүйлийг хураан авах тухай шүүхийн шийдвэр гаргах үед түүнийг ашигласан, худалдсан буюу өөр шалтгааны улмаас хураан авах боломжгүй болгосон тохиолдолд шүүх тухайн зүйлийн өртөгт тохирсон хэмжээний мөнгийг хураан авах тухай шийдвэр гаргана.

99 дүгээр зүйл. Учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх

99.1. Энэхүү Төрөлжсөн хуулийн 97,98 дугаар зүйлд нийцүүлэн эд хөрөнгө хураах тухай асуудлыг шийдвэрлэхдээ шүүх тэргүүн ээлжинд хууль ёсны эзэмшигчид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай асуудлыг шийдвэрлэнэ.

99.2. Энэхүү Төрөлжсөн хуулийн 97 дугаар зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт зааснаас бусад гаргуулах өөр эд хөрөнгө гэм буруутай этгээдэд байхгүй тохиолдолд хууль ёсны эзэмшигчид учруулсан хохирлыг түүний өртгөөс нөхөн төлүүлж, харин үлдсэн хэсгийг улсын орлогод оруулна.

ТУСГАЙ АНГИ

VII ХЭСЭГ. ХҮНИЙ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

АРВАН ДОЛООДУГААР БҮЛЭГ. ХҮНИЙ АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

100 дугаар зүйл. Хүн санаатай алах

100.1. Бусдыг санаатай алсан бол долоогоос арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

100.2. Хүнийг:

- 100.2.1. хоёр буюу түүнээс дээш хүнийг;
- 100.2.2. албаны үйл ажиллагаа буюу олон нийтийн журамт үүргээ биелүүлсэнтэй нь холбогдуулан тухайн этгээд буюу түүний ойрын хүнийг;
- 100.2.3. гэм буруутай этгээд туслалцаагүй байдалд байгаа этгээдийг зориуд, түүнчлэн хүн хулгайлах, эсхүл хүн барьцаалахтай дагалдан;
- 100.2.4. гэм буруутай этгээд жирэмсэн байгааг нь мэдэж зориуд эмэгтэй хүнийг;
- 100.2.5. онц харгис хэрцгийгээр;
- 100.2.6. нийтэд аюултай аргаар;
- 100.2.7. өс хонзонгоор;
- 100.2.8. бүлэг этгээд, урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалтай бүлэг;

- 100.2.9. шунахай сэдэлт буюу хөлсөөр, түүнчлэн дээрэмдэх, далайлган сүрдүүлэх буюу зандачлахтай дагалдан;
- 100.2.10. танхайрах сэдэлтээр;
- 100.2.11. өөр гэмт хэргийг нуун дарагдуулах буюу түүнийг үйлдэхийг хөнгөвчлөх зорилгоор, түүнчлэн хүчиндэх буюу хүч хэрэглэсэн бэлгийн үйлдэл үйлдэхтэй дагалдан;
- 100.2.12. улс төр, үзэл суртал, арьсны өнгө, үндэстэн буюу шашны үзэн ядалт буюу дайсагналын сэдэлтээр;
- 100.2.13. хохирогчийн эд буюу эрхтнийг ашиглах зорилгоор алсан бол наймаас хорин жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл бүх насаар нь хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ.

101 дүгээр зүйл. Эх нь нярай хүүхдээ алах

101.1. Эх нь төрсөн хүүхдээ төрөх явцад буюу төрмөгц, түүнчлэн хэрэг хариуцах чадвар нь үгүйсгэгдээгүй сэтгэцийн гүнзгий хямралын нөхцөл буюу сэтгэцийн зовиурын байдалд нярай хүүхдээ алсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

102 дугаар зүйл. Санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчдаж бусдыг алах

102.1. Хохирогчийн зүгээс хүч хэрэглэсэн, тохуурхан даажигнасан буюу хүндээр доромжилсон, эсхүл хохирогчийн эрх зүйн бус буюу ёс суртахуунгүй бусад үйлдэл (эс үйлдэхүй), түүнчлэн хохирогчийн байнгын эрх зүйн бус буюу ёс суртахуунгүй зан үйлтэй холбогдон үүссэн удаан хугацааны туршид сэтгэцийн гүнзгий хямралын байдалд оруулсаны улмаас санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчидсан үедээ бусдыг алсан бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

102.2. Санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчидсан байдалд хоёр буюу түүнээс дээш хүнийг алсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

103 дугаар зүйл. Аргагүй хамгаалалтын хэр хэмжээг хэтрүүлж, эсхүл гэмт хэрэг үйлдсэн этгээдийг албадан саатуулахад зайлшгүй шаардлагатай арга хэмжээг хэтрүүлж бусдыг алах

103.1. Аргагүй хамгаалалтын хэр хэмжээг хэтрүүлж хүнийг алсан бол хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

103.2. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг албадан саатуулахад зайлшгүй шаардлагатай арга хэмжээг хэтрүүлж хүнийг алсан бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

104 дүгээр зүйл. Хүний амь насыг болгоомжгүй бусниулах

104.1. Хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

104.2. Мэргэжлийн үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүйн улмаас хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

104.3. Хоёр буюу түүнээс дээш хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол таван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

105 дугаар зүйл. Амиа хорлоход хүргэх

105.1. Хохирогчийг айлган сүрдүүлсэн, харгис хэрцгий харьцсан буюу хүн гэсэн нэр төрийг нь байнга гутаах замаар амиа хорлоход хүргэсэн буюу амиа хорлохоор завдсан бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах буюу таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

106 дугаар зүйл. Эрүүл мэндэд хүнд гэм хор санаатай учруулах

106.1. Хүний амь насанд аюултай буюу хараа, хэл, сонсгол, эсхүл ямар нэгэн эрхтнээс нь хагацуулсан буюу түүнийг ажиллагаагүй болгосон, жирэмслэлтийг тасалдуулсан, сэтгэцийн зовиур, мансууруулах, эсхүл дондуулах өвчтэй болгосон, нүүрийг засаршгүй эвдэж дүрсийг алдагдуулсан, хөдөлмөрийн ерөнхий чадварын гуравны нэгээс доошгүйг үлэмжхэн тогтонги алдагдуулсан буюу мэргэжлийн чадварыг нь зориуд бүрмөсөн алдагдуулж хүний эрүүл мэндэд хүнд гэм хорыг санаатай учруулсан бол гурваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

106.2. Энэ хэргийг:

- 106.2.1. албаны үйл ажиллагаа буюу олон нийтийн журамт үүргээ хэрэгжүүлсэнтэй нь холбогдуулан тухайн этгээд буюу түүний ойрын хүний хувьд;
- 106.2.2. хохирогчийг онц харгис хэрцгийгээр, тохуурхан даажигнаж буюу зовоон тарчлааж, түүнчлэн туслалцаагүй байдалд байгааг нь гэм буруутай этгээд зориуд ашиглаж;
- 106.2.3. нийтэд аюултай аргаар;
- 106.2.4. хөлсөөр;
- 106.2.5. танхайрах сэдэлтээр;
- 106.2.6. улс төр, үзэл суртал, арьсны өнгө, үндэстний буюу шашны үзэн ядалт буюу дайсагналын сэдэлтээр;
- 106.2.7. хохирогчийн эд буюу эрхтнийг ашиглах зорилгоор үйлдсэн бол дөрвөөс арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

106.3. Хэрэв энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг бүлэг этгээд, урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг, эсхүл хоёр буюу түүнээс дээш этгээдийн хувьд үйлдсэн бол таваас арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

106.4. Энэ зүйлийн нэг, хоёр буюу гурав дахь хэсэгт заасан хэргийн улмаас хохирогчийн амь насыг болгоомжгүй бусниулсан бол таваас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

107 дугаар зүйл. Эрүүл мэндэд хүндэвтэр гэм хор санаатай учруулах

107.1. Хүний амь насанд аюултай бус, эрүүл мэндэд хүндэвтэр гэм хорыг санаатай учруулсан ба энэхүү Төрөлжсөн хуулийн 106 дугаар зүйлд заасан хор уршгийг бий болгоогүй боловч хүний эрүүл мэндэд удаан хугацаатай зовиур буюу хөдөлмөрийн ерөнхий чадварын

гуравны нэгээс доошгүйг үлэмжхэн тогтонги алдагдуулсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

107.2. Энэ хэргийг:

- 107.2.1. хоёр буюу түүнээс дээш этгээдийн хувьд;
- 107.2.2. албаны үйл ажиллагаа буюу олон нийтийн журамт үүргээ хэрэгжүүлсэнтэй нь холбогдуулан тухайн этгээд буюу түүний ойрын хүний хувьд;
- 107.2.3. хохирогчийг онц харгис хэрцгийгээр, тохуурхан даажигнаж буюу зовоон тарчлааж, түүнчлэн туслалцаагүй байдалд байгааг нь гэм буруутай этгээд зориуд ашиглаж;
- 107.2.4. бүлэг этгээд, урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг;
- 107.2.5. танхайрах сэдэлтээр;
- 107.2.6. улс төр, үзэл суртал, арьсны өнгө, үндэстний буюу шашны үзэн ядалт буюу дайсагналын сэдэлтээр үйлдсэн бол тав жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

108 дугаар зүйл. Санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчдаж эрүүл мэндэд хүнд буюу хүндэвтэр гэм хор учруулах

108.1. Хохирогчийн зүгээс хүч хэрэглэсэн, тохуурхан даажигнасан буюу хүндээр доромжилсон, эсхүл хохирогчийн эрх зүйн бус буюу ёс суртахуунгүй бусад үйлдэл (эс үйлдэхүй), түүнчлэн хохирогчийн байнгын эрх зүйн бус буюу ёс суртахуунгүй зан үйлтэй холбогдон үүссэн удаан хугацааны туршид сэтгэцийн гүнзгий хямралын байдалд оруулсаны улмаас санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчдсан үедээ хүний эрүүл мэндэд хүнд буюу хүндэвтэр гэм хор санаатай учруулсан бол хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

109 дүгээр зүйл. Аргагүй хамгаалалтын хэр хэмжээг хэтрүүлж, эсхүл гэмт хэрэг үйлдсэн этгээдийг албадан саатуулахад зайлшгүй шаардлагатай арга хэмжээг хэтрүүлж эрүүл мэндэд хүнд буюу хүндэвтэр гэм хор учруулах

109.1. Аргагүй хамгаалалтын хэр хэмжээг хэтрүүлж хүний эрүүл мэндэд хүнд гэм хор санаатай учруулсан бол хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах буюу нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

109.2. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг албадан саатуулахад зайлшгүй шаардлагатай арга хэмжээг хэтрүүлж бусдын эрүүл мэндэд хүнд буюу хүндэвтэр гэм хор санаатай учруулсан бол хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

110 дугаар зүйл. Эрүүл мэндэд хөнгөн гэм хор санаатай учруулах

110.1. Хүний эрүүл мэндэд богино хугацаатай зовиур учруулсан буюу хөдөлмөрийн ерөнхий чадварыг үлэмж бага хэмжээгээр алдагдуулсан бол нэг сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наян цагаас хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

110.2. Энэ хэргийг танхайрах сэдэлтээр, эсхүл улс төр, үзэл суртал, арьсны өнгө, үндэстний буюу шашны үзэн ядалт буюу дайсагналын сэдэлтээр үйлдсэн бол нэг зуун хориос нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

111 дүгээр зүйл. Зодох

111.1. Энэхүү Төрөлжсөн хуулийн 110 дугаар зүйлд заасан хор уршиг учруулаагүй боловч зодсон буюу хүний бие махбодид өвдөлт үүсгэсэн хүч хэрэглэсэн бусад үйлдэл үйлдсэн бол нэг сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун хориос нэг зуун наян цаг хүртэл албадан ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

111.2. Эна хэргийг танхайрах сэдэлтээр, эсхүл улс төр, үзэл суртал, арьсны өнгө, үндэстний буюу шашны үзэн ядалт буюу дайсагналын сэдэлтээр үйлдсэн бол нэг зуун хориос нэг зуун наян цаг хүртэл албадан ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

112 дугаар зүйл. Тарчлаах

112.1. Байнга зодох замаар буюу хүч хэрэглэсэн бусад үйлдлээр бие махбодийн буюу сэтгэцийн шаналгаа зүдүүр учруулсан нь энэхүү Төрөлжсөн хуулийн 106, 107 дугаар зүйлд заасан хор уршигийг учруулаагүй бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

112.2. Энэ хэргийг:

- 112.2.1. хоёр буюу түүнээс дээш этгээдийн хувьд;
- 112.2.2. албаны үйл ажиллагаа буюу олон нийтийн журамт үүргээ хэрэгжүүлсэнтэй нь холбогдуулан тухайн этгээд буюу түүний ойрын хүний хувьд;
- 112.2.3. жирэмсэн эмэгтэйн хувьд гэм буруутай этгээд зориуд;
- 112.2.4. насанд хүрээгүй буюу гэм буруутай этгээд зориуд туслалцаагүй байлгасан, эсхүл гэм буруутай этгээдээс эд хөрөнгийн болон бусад байдлаар эрхшээлд нь байсан, түүнчлэн хулгайлсан эсхүл барьцаалагдсан этгээдийн хувьд;
- 112.2.5. эрүү шүүлт тулгасан;
- 112.2.6. бүлэг этгээд, урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг;
- 112.2.7. хөлсөөр;
- 112.2.8. улс төр, үзэл суртал, арьсны өнгө, үндэстний буюу шашны үзэн ядалт буюу дайсагналын сэдэлтээр үйлдсэн бол гурваас долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Энэхүү Төрөлжсөн хуулийн энэ зүйл болон бусад зүйлд заасан эрүү шүүлт гэж мэдүүлэг гаргуулахаар албадсан буюу хүний хүсэл зоригт харшилсан бусад үйлдэл, түүнчлэн ялын зорилгоор буюу бусад зорилгоор бие махбодийн буюу зан суртахууны шаналал зүдүүр учруулсныг үзнэ.

113 дугаар зүйл. Эрүүл мэндэд хүнд гэм хор болгоомжгүй учруулах

113.1. Хүний эрүүл мэндэд хүнд гэм хор болгоомжгүй учруулсан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наяд хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

113.2. Энэ хэргийг мэргэжлийнхээ үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас үйлдсэн бол дөрвөн жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

114 дүгээр зүйл. Алах буюу эрүүл мэндэд хүнд гэм хор учруулахаар айлган сүрдүүлэх

114.1. Алах буюу эрүүл мэндэд хүнд гэм хор учруулахаар айлган сүрдүүлсэн нь хэрэв энэхүү заналхийлэл хэрэгжих бодит үндэслэлтэй байсан бол хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

114.2. Энэ хэргийг улс төр, үзэл суртал, арьсны өнгө, үндэстний буюу шашны үзэн ядалт буюу дайсагналын сэдэлтээр үйлдсэн бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

115 дугаар зүйл. Хүний эд буюу эрхтнийг шилжүүлэн суулгахаар албадах

115.1. Хүч хэрэглэсэн буюу түүнийг хэрэглэхээр айлган сүрдүүлж хүний эд буюу эрхтнийг шилжүүлэн суулгахын тулд авахаар албадсан бол тодорхой гурван жил хүртэл хугацаагаар албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

115.2. Энэ хэргийг хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй, эсхүл гэм буруутай этгээдээс эд хөрөнгийн буюу бусад хараат байдалтай байгааг зориуд далимдуулан үйлдсэн бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

116 дугаар зүйл. Өнгөний өвчин халдах

116.1. Өөрийн биед өнгөний өвчин байгааг мэдсээр байж бусад этгээдэд халдаасан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

116.2. Энэ хэргийг хоёр буюу түүнээс дээш этгээдийн хувьд, эсхүл насанд хүрээгүй хүний хувьд зориуд үйлдсэн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

117 дугаар зүйл. Дархлалын олдмол хомсдолын өвчин халдах

117.1. Бусад этгээдийг дархлалын олдмол хомсдолын өвчин тусах аюулд зориуд хүргэсэн бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

117.2. Өөрийн биед дархлалын олдмол хомсдолын өвчин байгааг мэдсэн этгээд бусдад энэ өвчнийг халдаасан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

117.3. Энэ зүйлийн хоёр дахь хэсэгт заасан хэргийг хоёр буюу түүнээс дээш этгээд, эсхүл насанд хүрээгүй хүний хувьд зориуд үйлдсэн бол найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

117.4. Мэргэжлийнхээ үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас дархлалын олдмол хомсдолын өвчнийг бусад этгээдэд халдаасан бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг үйлдсэн этгээд хэрэв дархлалын олдмол хомсдолын өвчнийг бусад этгээдэд халдаах аюулыг буй болгосон, эсхүл халдаасан этгээдийг цаг тухайн үед нь сайн дураараа мэдэгдэж, урьдчилан сэрэмжлүүлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

118 дугаар зүйл. Хууль бусаар үр хөндөх

118.1. Эмнэлгийн холбогдох чиглэлийн дээд боловсролгүй этгээд үр хөндсөн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуугаас хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.

118.2. Хэрэв энэ хэргийн улмаас хохирогчийн амь насыг болгоомжгүй бусниулсан, эсхүл түүний эрүүл мэндэд хүнд гэм хор учруулсан бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

119 дүгээр зүйл. Өвчтөнд туслалцаа эс үзүүлэх

119.1. Хууль буюу тусгай журмын дагуу өвчтөнд туслалцаа үзүүлэх үүрэг бүхий этгээд хүндэтгэх шалтгаангүйгээр өвчтөнд туслалцаа үзүүлээгүйгээс хүний эрүүл мэндэд хүндэвтэр гэм хор учруулсан бол нэг сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

119.2. Хэрэв энэ хэргийн улмаас хохирогчийн амь насыг болгоомжгүй бусниулсан, эсхүл түүний эрүүл мэндэд хүнд гэм хор учруулсан бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

120 дугаар зүйл. Аюултай байдалд орхих

120.1. Бага буюу өндөр насны, өвчний ба бусад шалтгааны улмаас биеэ хамгаалж чадахгүй болсон хүний амь нас буюу эрүүл мэндийн байдал аюултай нөхцөлд байхад хэрэв

гэм буруутай этгээд туслалцаа үзүүлэх боломжтой байсан, эсхүл түүнийг халамжлах үүрэгтэй байсан, эсхүл түүний амь нас буюу эрүүл мэндийг аюултай байдалд оруулсан этгээд зориуд туслалцаа үзүүлээгүй орхисон бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун хориос нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ. ХҮНИЙ БА ИРГЭНИЙ ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ БА ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

121 дүгээр зүйл. Хүний ба иргэний тэгш эрх ба эрх чөлөөг зөрчих

121.1. Ялгаварлан гадуурхсан, өөрөөр хэлбэл хүний ба иргэний хүйс, арьсны өнгө, үндэс угсаа, хэл, гарал үүсэл, эд хөрөнгийн ба албан тушаалын байдал, оршин суугаа газар, шашин, итгэл үнэмшил буюу улс төрийн нам, төрийн бус байгууллагад эвлэлдэн нэгдсэн хамаарлаас шалтгаалан хүний ба иргэний эрх, эрх чөлөө ба хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наян цаг хүртэл албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

121.2. Энэ хэргийг албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл таван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу эсхүл нэг зуун хориос хоёр зуун дөчин цаг хүртэл албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

122 дугаар зүйл. Хувийн амьдралын халдашгүй байдлыг зөрчих

122.1. Хүний хувийн буюу гэр бүлийн нууцыг агуулсан хувийн амьдралын тухай мэдээ сэлтийг түүний зөвшөөрөлгүйгээр хууль бусаар цугларуулсан буюу тараасан, эсхүл ийм мэдээ сэлтийг нийтэд ярьсан, бүтээл буюу олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэд түгээсэн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун хориос нэг зуун наян цаг хүртэл албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

122.2. Энэ хэргийг албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

123 дугаар зүйл. Захидал харилцаа, телефон яриа, шуудан, цахилгаан буюу бусад мэдээллийн нууцыг зөрчих

123.1. Иргэдийн захидал харилцаа, телефон яриа, шуудан, цахилгаан буюу бусад мэдээллийн нууцыг зөрчсөн бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун хориос нэг зуун наян цаг хүртэл албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.

123.2. Энэ хэргийг албан тушаалынхаа байдлыг буюу мэдээллийг ил биш аргаар олж авах зориулалттай бүхий тусгай техник хэрэгсэл ашиглаж үйлдсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл нэг зуун наяс хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

123.3. Энэ хэргийг мэдээлэл ил биш аргаар олж авах зориулалт бүхий тусгай техник хэрэгсэл борлуулах зорилгоор хууль бусаар үйлдвэрлэсэн, борлуулсан буюу олж авсан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах ял шийтгэнэ.

124 дүгээр зүйл. Орон сууц, гэрийн халдашгүй байдлыг зөрчих

124.1. Орон сууц, гэрт амьдарч байгаа этгээдийн хүсэл зоригоос гадуур орон сууц, гэрт хууль бусаар нэвтрэн орсон бол нэг сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурав сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун хориос нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

124.2. Энэ хэргийг хүч хэрэглэж буюу түүнийг хэрэглэхээр айлган сүрдүүлж үйлдсэн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

124.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Энэ зүйл, түүнчлэн энэхүү Төрөлжсөн хуулийн бусад зүйлд заасан орон сууц, гэр гэж өмчийн хэлбэрээс үл шалтгаалах сууц ба сууц бус байр, орон сууц, гэр, хүн байнга буюу түр амьдарч болохуйц байр, түүнчлэн түр оршин амьдрах зориулалттай бусад байр буюу байгууламжийг үзнэ.

125 дугаар зүйл. Иргэдэд мэдээлэл өгөхөөс татгалзах

125.1. Албан тушаалтан тогтоосон журмын дагуу цугларуулсан баримт бичиг ба иргэдийн эрх ба эрх чөлөөг шууд хөндсөн материалыг өгөхөөс хууль бусаар татгалзсан, эсхүл бүрэн бус буюу зориуд худал мэдээлэл өгсөний улмаас иргэдийн эрх ба хууль ёсны ашиг сонирхолд гэм хор учруулсан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван

найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёроос таван жилийн хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах ял шийтгэнэ.

126 дугаар зүйл. Сонгуулийн эрхээ хэрэгжүүлэх буюу сонгуулийн хорооны ажилд саад хийх

126.1. Иргэнээс өөрийн сонгуулийн эрх буюу ард нийтийн санал асуулгад оролцох эрхээ чөлөөтэй хэрэгжүүлэхэд саад учруулсан, саналын нууцыг зөрчсөн, түүнчлэн сонгуулийн хорооны ажил, эсхүл өөрийн үүргээ гүйцэтгэсэнтэй нь холбогдуулан сонгуулийн хорооны гишүүний үйл ажиллагаанд саад хийсэн бол нэг сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун хориос нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.

126.2. Энэ хэргийг худалдан авч, хууран мэхлэж, хүч хэрэглэж буюу түүнийг хэрэглэхээр айлган сүрдүүлж, эсхүл албан тушаалынхаа байдлыг ашиглаж, эсхүл урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэгээс хоёр жилийн хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

126.3. Албан тушаалын буюу албан ажлын байдлаа ашиглан сонгуулийн хорооноос сонгуулийн ба ард нийтийн санал асуулгын тухай хууль тогтоомжид тогтоосон бүрэн эрхээ хэрэгжүүлэх, түүний шийдвэрт нөлөөлөх зорилгоор албан тушаалтан нэр дэвшигчдийн бүртгэл, нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт, сонгогчид ба ард нийтийн санал асуулгад оролцогчдын санал тоолох, сонгуулийн хорооны онцгой эрх хэмжээнд хамаарах бусад асуудлаар шаардлага буюу заалт чиглэл өгч хөндлөнгөөс оролцсон бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль эсхүл торгуульгүйгээр дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

127 дугаар зүйл. Сонгуульд нэр дэвшигчийг санхүүжүүлэх журам зөрчих

127.1. Сонгуулийн тодорхой үр дүнд хүрэх зорилгоор сонгуулийн зардлын дансанд оруулахгүйгээр их хэмжээтэй мөнгөн хөрөнгийг нэр дэвшигчид шилжүүлсэн, эсхүл сонгуулийн зардлын дансанд байгаагүй их хэмжээний мөнгөн хөрөнгийг зарцуулсан, эсхүл сонгуулийн тодорхой үр дүнд хүрэх зорилгоор нэр дэвшигч сонгуулийн зардлын данснаас гаргалгүйгээр их хэмжээтэй материаллаг үнэт зүйлсийг бусдад шилжүүлсэн буюу сонгуулийн тодорхой үр дүнд хүрэхэд чиглэгдсэн ба сонгуультай шууд буюу шууд бусаар холбогдуулан сонгуулийн зардлын данснаас гаргалгүйгээр их хэмжээгээр хэрэгжүүлсэн төлбөртэй ажил гүйцэтгэсэн, бараа борлуулсан, төлбөртэй үйлчилгээ үзүүлсэн, үндэслэлгүйгээр бууруулсан үнээр сонгуулийн зардлын данснаас төлбөр хийсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

127.2. Сонгуулийн зардлын данснаас гадуур сонгуульд нэр дэвшигч, тухайн нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, шадар туслагч сонгуульд нэр дэвшигчийг дэмжүүлэхийн тулд их хэмжээтэй хөрөнгө ашигласан, түүнчлэн сонгуулийн ба ард нийтийн санал асуулгын тухай хууль тогтоомжоор хориглосон ба сонгуулийн зардлын данс, ард

нийтийн санал асуулгын зардлын дансанд байгаагаас илүү их хэмжээний мөнгөн хөрөнгийг зарцуулсан бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл таван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл нэг зуун наяс хоёр зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс хоёр жилийн хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Энэ зүйлд заасан их хэмжээ гэж энэ зүйлд заасан хэрэг үйлдэх үед дөчин сая төгрөгөөс доошгүй байсныг үзнэ.

128 дугаар зүйл. Сонгуулийн буюу ард нийтийн санал асуулгын бичгийг хуурмаглах

128.1. Хэрэв сонгуулийн хорооны гишүүн, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, шадар туслагч сонгуулийн баримт бичиг, ард нийтийн санал асуулгын баримт бичгийг хуурамчаар үйлдсэн бол арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл дөрвөн жил хугацаагаар хорих ял шийтгэнэ.

128.2. Урьдчилсан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг, эсхүл худалдан авч, хууран мэхлэж, хүч хэрэглэж буюу түүнийг хэрэглэхээр айлган сүрдүүлж, түүнчлэн эд хөрөнгө устгаж буюу түүнийг устгахаар айлган сүрдүүлж, эсхүл иргэн буюу байгууллагын эрх ба хууль ёсны ашиг сонирхол буюу нийгэм, төрийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг ноцтой зөрчиж сонгогчдын тэмдэглэгээг хуурамчаар үйлдсэн бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёроос таван жилийн хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл гурван жил хугацаагаар хорих ял шийтгэнэ.

128.3. Сонгуулийн хуудас, ард нийтийн санал асуулгын хуудсыг хууль бусаар бэлтгэсэн, түүнчлэн түүнийг хадгалсан, тээвэрлэсэн бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

129 дүгээр зүйл. Сонгуулийн үр дүнг хуурмаглах

129.1. Санал авахад зарцуулсан саналын хуудсын тоонд зарцуулаагүй саналын хуудас оруулсан, эсхүл сонгогчид, ард нийтийн санал асуулгад оролцогчийн тухай буруу мэдээ сэлтийг зориуд өгсөн, эсхүл сонгох эрхгүй буюу ард нийтийн санал асуулгад оролцох эрхгүй этгээд буюу зохиомол нэр бүхий этгээдийг оруулан сонгогчид, ард нийтийн санал асуулгад оролцогчдын нэрсийн жагсаалтыг зориуд буруу бүрдүүлсэн, эсхүл сонгогчид, ард нийтийн санал асуулгад оролцогчдын тэмдэглэгээг хуурмагласан, эсхүл саналын хуудсыг сонгогчдын хүсэл зоригийг тодорхойлох боломжгүй болгосон, эсхүл саналын хуудсыг хууль бусаар устгасан, эсхүл сонгогчид, ард нийтийн санал асуулгад оролцогчдын саналыг зориуд буруу тоолсон, эсхүл сонгуулийн хорооны гишүүд санал тоолохоос өмнө санал хураалтын үр дүнгийн тухай буюу санал хураалтын үр дүнг тогтоох протоколд гарын үсэг зурсан, эсхүл санал хураалтын үр дүнгийн тухай буруу шийдвэр, тэмдэглэлийг зориуд үйлдсэн, эсхүл санал хураалтын үр дүнгийн тухай шийдвэрт түүнийг үйлдсэний дараа хууль бус өөрчлөлт оруулсан, эсхүл санал хураалтын үр дүн, сонгууль, ард нийтийн санал асуулгын үр дүнг зориуд буруу тодорхойлсон бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил

хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл дөрвөн жил хугацаагаар хорих ял шийтгэнэ.

130 дугаар зүйл. Хөдөлмөр хамгааллын журам зөрчих

130.1. Аюулгүйн техникийн журам буюу хөдөлмөр хамгааллын бусад журмыг сахин хангуулах үүрэг бүхий этгээд энэ журмыг зөрчсөнөөс хүний эрүүл мэндэд хүнд гэм хор болгоомжгүй учруулсан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

130.2. Энэ хэргийн улмаас хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр таван жил хугацаагаар хорих ял шийтгэнэ.

131 дүгээр зүйл. Сэтгүүлчийн мэргэжлийн хууль ёсны үйл ажиллагаанд саад учруулах

131.1. Сэтгүүлчийн мэргэжлийн хууль ёсны үйл ажиллагаанд мэдээлэл түгээх, эсхүл түүнээс татгалзуулахаар албадах замаар саад учруулсан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.

131.2. Энэ хэргийг албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр хоёр жил хугацаагаар хорих ял шийтгэнэ.

132 дугаар зүйл. Цалин, тэтгэвэр, тэтгэмж ба бусад төлбөрийг эс төлөх

132.1. Гурван сараас дээш хугацаагаар цалин, тэтгэвэр, тэтгэмж болон хуулиар тогтоосон бусад төлбөрийг байгууллагын удирдагч, ажил олгогч-хувь этгээд шунахай буюу хувийн бусад сонирхлоор төлөөгүй бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл таван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

132.2. Энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учруулсан бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр гурваас долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

133 дугаар зүйл. Зохиогчийн ба хамаарах эрх зөрчих

133.1. Зохиогч мөн болох эрхийг завшсан нь зохиогч буюу бусад эрх эзэмшигчид их хэмжээний хохирол учруулсан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван

найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наяс хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

133.2. Зохиогчийн эрх буюу хамаарах эрхийн объектыг хууль бусаар ашигласан, түүнчлэн борлуулах зорилгоор бусдын бүтээлийн буюу фонограммын хуурмаг хувийг их хэмжээтэйгээр үйлдсэн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наяс хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх эсхүл хоёр жил хугацаагаар хорих ял шийтгэнэ.

133.3. Энэ зүйлийн нэг ба хоёр дахь хэсэгт заасан хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг, эсхүл онц их хэмжээгээр, эсхүл албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн бол хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл торгуульгүйгээр зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Энэ зүйлд заасан их хэмжээ гэж хэрэв бүтээл буюу фонограммын хувийн өртөг, эсхүл зохиогчийн эрхийн ба хамаарах эрхийг ашигласан өртөг хоёр сая төгрөгөөс дээш байвал, онц их хэмжээ гэж арван саяас дээш төгрөг байсныг үзнэ.

134 дүгээр зүйл. Шинэ бүтээл ба патентийн эрх зөрчих

134.1. Шинэ бүтээл, ашигтай загвар буюу бүтээгдэхүүний загварыг хууль бусаар ашигласан, зохиогч буюу мэдүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр албан ёсоор нийтлэхээс өмнө шинэ бүтээл, ашигтай загвар буюу бүтээгдэхүүний загварын мөн чанарын тухай мэдээ сэлтийг задруулсан, зохиогч мөн болох эрхийг завшсан буюу хамтарсан зохиогч болохыг албадсанаас их хэмжээний хохирол учруулсан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наяс хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

134.2. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл таван жил хугацаагаар хорих ял шийтгэнэ.

135 дугаар зүйл. Шүтэж бишрэх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд саад учруулах

135.1. Шашны байгууллагын үйл ажиллагаа буюу шашны зан үйл үйлдэхэд хууль бусаар саад учруулсан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮНИЙ ЭРХ ЧӨЛӨӨ, НЭР ТӨР БА АЛДАР ХҮНДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

136 дугаар зүйл. Хүн хулгайлах

136.1. Хүн хулгайлсан бол гурваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

136.2. Энэ хэргийг:

136.2.1. урьдчилсан тохиролцсон бүлэг;

136.2.2. хүний амь нас буюу эрүүл мэндэд аюултай хүч хэрэглэсэн, эсхүл ийм хүч хэрэглэхээр айлган сүрдүүлж;

136.2.3. зэвсэг буюу зэсгийн чанартай ашиглаж болох зүйл хэрэглэж;

136.2.4. зориуд насанд хүрээгүй хүний хувьд;

136.2.5. зориуд жирэмсэн эмэгтэйн хувьд;

136.2.6. хоёр буюу түүнээс дээш этгээдийн хувьд;

136.2.7. шунахай сэдэлтээр үйлдсэн бол зургаас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

136.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг зохион байгуулалттай бүлэг, эсхүл хохирогчийн амь насыг болгоомжгүй бусниулсан буюу өөр хүнд хор уршиг учруулсан бол наймаас хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Хулгайлсан хүнийг сайн дураараа чөлөөлсөн этгээдийг хэрэв түүний үйлдэлд өөр гэмт хэргийн бүрэлдүүнгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

137 дугаар зүйл. Хууль бусаар хорих

137.1. Хүнийг хулгайлахтай холбоогүйгээр бусдыг хууль бусаар хорьсон бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

137.2. Энэ хэргийг:

137.2.1. урьдчилсан тохиролцсон бүлэг;

137.2.2. хүний амь нас буюу эрүүл мэндэд аюултай хүч хэрэглэж;

137.2.3. зэвсэг буюу зэсгийн чанартай ашиглаж болох зүйл хэрэглэж;

137.2.4. зориуд насанд хүрээгүй хүний хувьд;

137.2.5. зориуд жирэмсэн эмэгтэйн хувьд;

137.2.6. хоёр буюу түүнээс дээш этгээдийн хувьд үйлдсэн бол гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

137.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг зохион байгуулалттай бүлэг, эсхүл хохирогчийн амь насыг болгоомжгүй бусниулсан буюу өөр хүнд хор уршиг учруулсан бол дөрвөөс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

138 дугаар зүйл. Хүн худалдаалах

138.1. Хүн худалдаалсан, өөрөөр хэлбэл хүнийг худалдсан-худалдан авсан, эсхүл хүнийг мөлжих зорилгоор элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, нуун дарагдуулсан буюу хүлээн авсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

138.2. Энэ хэргийг:

138.2.1. хоёр буюу түүнээс дээш этгээдийн хувьд;

138.2.2. зориуд насанд хүрээгүй хүний хувьд;

138.2.3. албан тушаалынхаа байдлыг ашиглаж;

- 138.2.4. хохирогчийг Монгол улсын хилээр нэвтрүүлсэн буюу түүнийг хууль бусаар хил дээр тогтоон барьж;
- 138.2.5. хуурамч баримт бичиг ашиглаж, түүнчлэн хохирогчийн хувийн байдлыг гэрчлэх баримт бичгийг авч, нууж эсхүл устгаж;
- 138.2.6. хүч хэрэглэсэн буюу түүнийг хэрэглэхээр айлган сүрдүүлж;
- 138.2.7. хохирогчийн эд буюу эрхтнийг авах зорилгоор үйлдсэн бол гурваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

138.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг хохирогчийн амь насыг болгоомжгүй бусниулж, түүний эрүүл мэндэд хүнд гэм хор буюу өөр хүнд хор уршиг учруулж, эсхүл олон хүний амь нас ба эрүүл мэндэд аюултай аргаар, эсхүл зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол наймаас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. 1. Энэ зүйлийн нэг дэх хэсэг буюу хоёр дахь хэсгийн 1-д заасан хэргийг анх удаа үйлдсэн этгээд хохирогчийг сайн дураараа чөлөөлсөн ба үйлдсэн гэмт хэргийг илрүүлэхэд тус дөхөм үзүүлсэн бол хэрэв түүний үйлдэлд өөр гэмт хэргийн бүрэлдүүнгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

2. Энэ зүйлийн хүнийг мөлжих гэж бусад этгээдийг биеэ үнэлэх, бэлгийн мөлжлөгийн өөр хэлбэр, боолын хөдөлмөр (үйлчилгээ), өөрийн эрх мэдэлгүй байдалд ашигласныг үзнэ.

139 дүгээр зүйл. Боолын хөдөлмөр хийлгэх

139.1. Өмчийн эрхийн агуулгыг бүрдүүлсэн бүрэн эрхийг хэрэгжүүлэн хүний хөдөлмөрийг ашиглаж хохирогчоос үл хамаарах шалтгааны улмаас ажил (үйлчилгээ)-аас татгалзаж болохооргүй болгосон бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

139.2. Энэ хэргийг:

- 139.2.1. хоёр буюу түүнээс дээш этгээдийн хувьд;
- 139.2.2. зориуд насанд хүрээгүй хүний хувьд;
- 139.2.3. албан тушаалынхаа байдлыг ашиглаж;
- 139.2.4. дарамталж, хүч хэрэглэж буюу түүнийг хэрэглэхээр айлган сүрдүүлж;
- 139.2.5. хуурамч баримт бичиг ашиглаж, түүнчлэн хохирогчийн хувийн байдлыг гэрчлэх баримт бичгийг авч, нууж эсхүл устгаж үйлдсэн бол гурваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

139.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг хохирогчийн амь насыг болгоомжгүй бусниулсан, түүний эрүүл мэндэд хүнд гэм хор буюу өөр хүнд хор уршиг учруулсан, эсхүл зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол наймаас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

140 дүгээр зүйл. Гүтгэх

140.1. Бусад этгээдийн нэр төр ба алдар хүндийг гутаасан мэдээ сэлтийг зориуд тараасан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун хориос нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.

140.2. Гүтлэгийг нийтийн өмнө ярьсан, бүтээлээр нийтэд үзүүлсэн буюу олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тараасан бол таван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэг жил

хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наяс хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

140.3. Хүнд буюу онц хүнд гэмт хэрэгт үйлдсэнд холбогдуулан яллуулахаар гүтгэсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

141 дүгээр зүйл. Доромжлох

141.1. Зүй зохисгүй байдлаар бусдын нэр төр ба алдар хүндийг унагаасан бол нэг сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун хорин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.

141.2. Доромжлолыг нийтийн өмнө ярьсан, бүтээлээр нийтэд үзүүлсэн буюу олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тараасан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.

ХОРЬДУГААР БҮЛЭГ. ГЭР БҮЛ БА НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮНИЙ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

142 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах

142.1. Арван найман насанд хүрээгүй этгээд амлалт өгч, хууран мэхэлж, айлган сүрдүүлж буюу өөр аргаар гэмт хэрэг үйлдэхэд насанд хүрээгүй хүнийг татан оруулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

142.2. Энэ хэргийг эцэг эх, багш, эсхүл насанд хүрээгүй хүнийг хүмүүжүүлэх үүрэг хуулиар хүлээсэн бусад этгээд үйлдсэн бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

142.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг хүч хэрэглэж буюу түүнийг хэрэглэхээр айлган сүрдүүлж үйлдсэн бол хоёроос долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

142.4. Энэ зүйлийн нэг, хоёр буюу гурав дахь хэсэгт заасан хэргийг насанд хүрээгүй хүнийг гэмт бүлэгт татан оруулах буюу хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдэхээр үйлдсэн бол таваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

143 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүнийг нийгэмд харш үйлдэлд татан оруулах

143.1. Арван найман насанд хүрээгүй этгээдээс насанд хүрээгүй хүнийг согтууруулах ундааны зүйл, донтуулах бодисыг байнга хэрэглэх, тэнүүчлүүлэх буюу гуйланчлалд татан оруулсан бол нэг зуун наяс хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс хоёр жилийн хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

143.2. Энэ хэргийг эцэг эх, багш, эсхүл насанд хүрээгүй хүнийг хүмүүжүүлэх үүрэг хуулиар хүлээсэн бусад этгээд үйлдсэн бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

143.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг хүч хэрэглэж буюу түүнийг хэрэглэхээр айлган сүрдүүлж үйлдсэн бол зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Энэ зүйлийн үйлчлэл нь хэрэв амьдрах үндсэн хэрэгсэлгүй буюу оршин суугаа газаргүйн улмаас үүссэн амьдралын хүнд нөхцөл байдлаас эцэг эх нь насанд хүрээгүй хүнийг тэнүүчлэлд татан оруулсан тохиолдолд хамаарахгүй.

144 дүгээр зүйл. Хүүхэд солих

144.1. Шунахай буюу бусад жигшүүрт зорилгоор хүүхэд сольсон бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээтэй торгуулийн ял шийтгэнэ.

145 дугаар зүйл. Хууль бусаар үрчлэх

145.1. Хууль бусаар хүүхэд үрчилсэн буюу асран хамгаалалт (харгалзан дэмжилт)-д шилжүүлсэн үйлдлийг удаа дараа буюу шунахай сэдэлтээр үйлдсэн бол нэг сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурав сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

146 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүнийг хүмүүжүүлэх үүргээ эс биелүүлэх

146.1. Насанд хүрээгүй хүнийг хүмүүжүүлэх үүрэг бүхий эцэг эх буюу энэ үүргийг хүлээсэн бусад этгээд, түүнчлэн багш буюу боловсролын, хүмүүжлийн, эмчилгээний, эсхүл насанд хүрээгүй хүнд хяналт тавих үүрэг хүлээсэн бусад байгууллагын ажилтан насанд хүрээгүй хүнийг хүмүүжүүлэх үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй ба хэрэв энэ хэргийг насанд хүрээгүй хүнтэй харгис хэрцгий харьцах явдал дагалдсан бол нэг сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах ял шийтгэнэ.

147 дугаар зүйл. Хүүхдээ буюу хөдөлмөрийн чадваргүй эцэг эхээ тэжээн тэтгэхээс ноцтой зайлсхийх

147.1. Шүүхийн шийдвэрийн дагуу насанд хүрээгүй хүүхэд, түүнчлэн арван найман насанд хүрсэн хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэхээс ноцтой зайлсхийсэн бол нэг зуун хориос нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

147.2. Насанд хүрсэн хөдөлмөрийн чадвартай хүүхэд нь шүүхийн шийдвэрийн дагуу хөдөлмөрийн чадваргүй эцэг эхээ тэжээн тэтгэхээс ноцтой зайлсхийсэн бол нэг зуун хориос нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

ХОРИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮНИЙ БЭЛГИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДАЛ БА БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

148 дугаар зүйл. Хүчиндэх

148.1. Хохирогч буюу бусад этгээдэд хүч хэрэглэж буюу түүнийг хэрэглэхээр айлган сүрдүүлж, эсхүл хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хурьцал үйлдсэн бол зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

148.2. Энэ хэргийг:

- 148.2.1. бүлэг этгээд, урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг;
- 148.2.2. ална гэж буюу эрүүл мэндэд нь хүнд гэм хор учруулахаар айлган сүрдүүлж, түүнчлэн хохирогч буюу бусад этгээдийн хувьд онц харгис хэрцгийгээр харьцаж;
- 148.2.3. хохирогчид өнгөний өвчин халдааж;
- 148.2.4. зориуд насанд хүрээгүй хүнийг хүчиндэж үйлдсэн бол гурваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

148.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг хохирогчийн амь насыг болгоомжгүй бусниулж, эсхүл хохирогчийн эрүүл мэндэд хүнд гэм хор болгоомжгүй учруулж, дархлал олдмол хомсдолын өвчин халдааж буюу өөр хүнд хор уршиг учруулж, эсхүл зориуд арван дөрвөн насанд хүрээгүй хүнийг хүчиндэж үйлдсэн бол наймаас хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

149 дүгээр зүйл. Хүч хэрэглэсэн бэлгийн шинжтэй үйлдэл үйлдэх

149.1. Эрийг эмлэсэн, ижил хүйстэнтэй явалдсан буюу бэлгийн шинжтэй өөр үйлдлийг хохирогчид буюу бусад этгээдэд хүч хэрэглэж буюу түүнийг хэрэглэхээр айлган сүрдүүлж, эсхүл хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан үйлдсэн бол зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

149.2. Энэ хэргийг:

- 149.2.1. бүлэг этгээд, урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг;

- 149.2.2. ална гэж буюу эрүүл мэндэд нь хүнд гэм хор учруулахаар айлган сүрдүүлж, түүнчлэн хохирогч буюу бусад этгээдийн хувьд онц харгис хэрцгийгээр харьцаж;
- 149.2.3. хохирогчид өнгөний өвчин халдааж;
- 149.2.4. зориуд насанд хүрээгүй хүний хувьд үйлдсэн бол гурваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

149.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг хохирогчийн амь насыг болгоомжгүй бусниулж, эсхүл хохирогчийн эрүүл мэндэд болгоомжгүй хүнд гэм хор учруулж, эсхүл дархлал олдмол хомсдолын өвчин халдааж буюу өөр хүнд хор уршиг учруулж, эсхүл зориуд арван дөрвөн насанд хүрээгүй хохирогчийн хувьд үйлдсэн бол наймаас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

150 дугаар зүйл. Бэлгийн шинжтэй үйлдэлд албадах

150.1. Бэлгийн харьцаанд орох, эрийг эмлэх, ижил хүйстэнтэй явалдах буюу бэлгийн шинжтэй бусад үйлдэлд дарамтлах, эд хөрөнгийг нь устгах, гэмтээх буюу авах замаар, эсхүл хохирогчийн эд хөрөнгийн буюу бусад эрхшээлд байгаа байдлыг далимдуулан албадсан бол таван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэг жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

151 дүгээр зүйл. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох ба бэлгийн шинжтэй бусад үйлдэл хийх

151.1. Зориуд арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орсон, эрийг эмлэсэн, ижил хүйстэнтэй явалдсан бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах буюу дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

152 дугаар зүйл. Садар самуунд уруу татах

152.1. Арван найман насанд хүрсэн этгээдээс хүч хэрэглэхгүйгээр арван зургаан насанд хүрээгүй хүний хувьд садар самуун үйлдэл үйлдсэн бол арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

VIII ХЭСЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ГЭМТ ХЭРЭГ

ХОРИН ХОЁРДУГААР БҮЛЭГ. ӨМЧИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

153 дугаар зүйл. Хулгай

153.1. Бусдын эд хөрөнгийг бага бус хэмжээтэй сэм ашиглан шамшигдуулсан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

153.2. Урьдчилан тохиролцсон бүлэг, эсхүл орон байр, эсхүл агуулах саванд хууль бусаар нэвтэрч, эсхүл иргэнд үлэмжхэн хохирол учруулж, эсхүл хохирогчийн хувцас, цүнх буюу гар тээшээс хулгайлсан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наяс хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

153.3. Орон сууц, гэрт хууль бусаар нэвтэрч, эсхүл их хэмжээтэй хулгайлсан бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурав жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр хоёроос зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

153.4. Зохион байгуулалттай бүлэг, эсхүл онц их хэмжээтэй хулгайлсан бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. 1. Энэхүү Төрөлжсөн хуульд заасан ашиглан шамшигдуулах гэж бусдын эд хөрөнгийг шунахай зорилгоор, хууль бусаар, үнэ төлбөргүй авсан, эсхүл гэм буруутай этгээд буюу бусад этгээдэд ашигтайгаар бусдын эд хөрөнгийг хэрэглэж, тухайн эд хөрөнгийн өмчлөгч буюу бусад эзэмшигчид хохирол учруулсаныг үзнэ.

1. Энэ бүлэгт заасан иргэнд үлэмжхэн хохирол учруулсан гэж хохирогчийн эд хөрөнгийн байдлыг харгалзан тодорхойлох боловч нэг зуун мянган төгрөгөөс доош байж болохгүй.

2. Энэ бүлэгт заасан орон байр гэж хүмүүс түр оршин амьдрах буюу үйлдвэрлэл, үйлчилгээ буюу албаны бусад зорилгоор эд хөрөнгийн үнэт зүйлийг байрлуулах зориулалт бүхий өмчийн хэлбэрээс үл шалтгаалах барилга, байгууламжийг үзнэ.

Энэ бүлэгт заасан агуулах сав гэж эд хөрөнгийн үнэт зүйлийг байнга буюу түр хадгалах зориулалттай, байрласан нутаг дэвсгэр нь хамгаалалт буюу техник хэрэгслээр тоноглогдсон, эсхүл бусад хамгаалалт бүхий өмчийн хэлбэрээс үл шалтгаалах орон сууцны, гэрийн болон аж ахуйн байр сав, бусад байгууламжийг үзнэ.

3. Энэ бүлэгт заасан бага бус хэмжээ гэж нэг зуун мянган төгрөгөөс дээш, их хэмжээ гэж арван сая төгрөгөөс дээш, харин онц их хэмжээ гэж дөчин сая төгрөгөөс дээш буюу ийм өртөгтэй эд хөрөнгийг үзнэ.

154 дүгээр зүйл. Залилан мэхлэх

154.1. Хууран мэхлэх буюу итгэл хортой ашиглах замаар бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулсан буюу бусдын эд хөрөнгийн эрхийг олж авсан бол таван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэг жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

154.2. Урьдчилан тохиролцсон бүлэг, түүнчлэн иргэнд үлэмжхэн хохирол учруулж залилан мэхэлсэн бол арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наяс хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс хоёр жил хүртэл

хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

154.3. Албан тушаалынхаа байдлыг ашиглаж, түүнчлэн их хэмжээтэй залилан мэхэлсэн бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурав жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван зуун мянган төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэг сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр хоёроос найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

154.4. Зохион байгуулалттай бүлэг, эсхүл онц их хэмжээтэй залилан мэхэлсэн бол хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр таваас арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

155 дугаар зүйл. Завших буюу үрэгдүүлэх

155.1. Гэм буруутай этгээд өөрт хариуцуулсан бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулсан бол таван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэг жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун хорин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

155.2. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг, түүнчлэн иргэнд үлэмжхэн хохирол учруулж үйлдсэн бол арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

155.3. Энэ хэргийг албан тушаалынхаа байдлыг ашиглаж, түүнчлэн их хэмжээтэй үйлдсэн бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурав жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл таван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл гурван зуун мянган төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэг сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр хоёроос зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

155.4. Энэ зүйлийн нэг, хоёр буюу гурав дахь хэсэгт заасан хэргийг зохион байгуулалттай бүлэг, эсхүл онц их хэмжээтэй үйлдсэн бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

156 дугаар зүйл. Булаах

156.1. Бусдын эд хөрөнгийг илээр ашиглан шамшигдуулсан бол нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

156.2. Булаалтыг:

156.2.1. урьдчилан тохиролцсон бүлэг;

156.2.2. орон сууц, гэр, орон байр эсхүл өөр агуулах саванд хууль бусаар нэвтэрч;

- 156.2.3. хүний амь нас буюу эрүүл мэндэд аюулгүй хүч хэрэглэж, эсхүл ийм хүч хэрэглэхээр айлган сүрдүүлж;
- 156.2.4. их хэмжээтэй үйлдсэн бол гурван зуун мянган төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэг сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль эсхүл торгуульгүйгээр хоёроос арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

156.3. Зохион байгуулалттай бүлэг, эсхүл онц их хэмжээтэй үйлдсэн бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл торгуульгүйгээр зургаагаас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

157 дугаар зүйл. Дээрэмдэх

157.1. Бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах зорилгоор хүний амь нас буюу эрүүл мэндэд аюултай хүч хэрэглэж, эсхүл ийм хүч хэрэглэхээр айлган сүрдүүлж довтолсон бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл торгуульгүйгээр гурваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

157.2. Урьдчилан тохиролцсон бүлэг, түүнчлэн зэвсэг буюу зэвсгийн чанартай ашиглаж болох зүйлийг хэрэглэж дээрэмдсэн бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл торгуульгүйгээр таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

157.3. Орон сууц, гэр, орон байр, эсхүл агуулах саванд хууль бусаар нэвтэрч буюу их хэмжээтэй үйлдсэн бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл торгуульгүйгээр долоогоос арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

157.4. Зохион байгуулалттай бүлэг, эсхүл эд хөрөнгө онц их хэмжээтэй авах зорилгоор, эсхүл хохирогчийн эрүүл мэндэд хүнд гэм хор учруулж үйлдсэн бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл торгуульгүйгээр наймаас хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

158 дугаар зүйл. Далайлган сүрдүүлэх

158.1. Хүч хэрэглэх, эсхүл бусдын эд хөрөнгийг устгах буюу гэмтээх, түүнчлэн хохирогч буюу түүний ойрын хүнийг гутаасан мэдээ сэлт, эсхүл хохирогч буюу түүний ойрын хүний эрх буюу хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд ноцтой гэм хор учруулж болохуйц бусад мэдээ сэлтийг тараах айлган сүрдүүлэлтээр бусдын эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрхийг шилжүүлэх буюу эд хөрөнгийн шинжтэй бусад үйлдэл хийхийг шаардсан бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл торгуульгүйгээр дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

158.2. Урьдчилан тохиролцсон бүлэг, эсхүл хүч хэрэглэж, эсхүл их хэмжээтэй үйлдсэн бол хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль эсхүл торгуульгүйгээр гурваас долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

158.3. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, эсхүл онц их хэмжээтэй эд хөрөнгө олж авах зорилгоор, эсхүл хохирогчийн эрүүл мэндэд хүнд гэм хор учруулж үйлдсэн бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр долоогоос арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

159 дүгээр зүйл. Онцгой үнэт зүйлийг ашиглан шамшигдуулах

159.1. Ашиглан шамшигдуулсан аргаас үл хамааран түүхийн, шинжлэх ухааны, уран сайхны буюу соёлын онцгой үнэт зүйл бүхий зүйл буюу баримт бичгийг ашиглан шамшигдуулсан бол хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр зургаагаас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

159.2. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг, энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан зүйл буюу баримт бичгийг устгасан, сүйтгэсэн буюу эвдсэн бол хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр наймаас хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

160 дугаар зүйл. Хууран мэхлэх буюу итгэлийг хортой ашиглах замаар эд хөрөнгийн хохирол учруулах

160.1. Ашиглан шамшигдуулсан шинжгүйгээр хууран мэхлэх буюу итгэлийг хортой ашиглах замаар өмчлөгч буюу бусад эзэмшигчид эд хөрөнгийн хохирол учруулсан бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль дөрвөн нэг зуун хориос нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

160.2. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг, эсхүл их хэмжээтэй үйлдсэн бол таваас арван таван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл дөрвөн сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

160.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг зохион байгуулалттай бүлэг, онц их хэмжээтэй хохирол учруулж үйлдсэн бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

161 дүгээр зүйл Алдуул мал, гээгдэл буюу санамсаргүй олдсон эд хөрөнгө завших

161.1. Алдуул мал, гээгдэл буюу санамсаргүй олдсон эд хөрөнгө завшсан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу

бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наяс хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

162 дугаар зүйл. Ашиглан шамшигдуулах зорилгогүйгээр автомашин буюу бусад тээврийн хэрэгслийг хууль бусаар эзэмдэх

162.1. Автомашин буюу тээврийн бусад хэрэгслийг ашиглан шамшигдуулах зорилгогүйгээр хууль бусаар эзэмдсэн бол таван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэг жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

162.2. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг, эсхүл хүний амь нас буюу эрүүл мэндэд аюулгүй хүч хэрэглэж, эсхүл ийм хүч хэрэглэхээр айлган сүрдүүлж үйлдсэн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

162.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг зохион байгуулалттай бүлэг, эсхүл онц их хэмжээтэй хохирол учруулж үйлдсэн бол гурваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

162.4. Энэ зүйлийн нэг, хоёр буюу гурав дахь хэсэгт заасан хэргийг хүний амь нас буюу эрүүл мэндэд аюултай хүч хэрэглэж, эсхүл ийм хүч хэрэглэхээр айлган сүрдүүлж үйлдсэн бол дөрвөөс арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

163 дугаар зүйл. Эд хөрөнгө санаатай устгах буюу гэмтээх

163.1. Бусдын эд хөрөнгийг санаатай устгасан буюу гэмтээсэнээс үлэмжхэн хохирол учруулсан бол нэг сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуугаас нэг зуун наян цаг хүртэл албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

163.2. Энэ хэргийг танхайрах сэдэлт, галдан шатаах, дэлбэлэх буюу нийтэд аюултай бусад аргаар, эсхүл хүний амь насыг болгоомжгүй бусниулж буюу өөр хүнд хор уршиг учруулж үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

164 дүгээр зүйл. Эд хөрөнгө болгоомжгүй устгах буюу гэмтээх

164.1. Гал буюу орчин тойрондоо аюултай бусад эх үүсвэртэй болгоомжгүй харьцсны улмаас бусдын эд хөрөнгийг их хэмжээтэй устгасан буюу гэмтээсэн бол таван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэг жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

ХОРИН ГУРАВДУГААР БҮЛЭГ.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР ДАХЬ ГЭМТ ХЭРЭГ

165 дугаар зүйл. Хууль ёсны аж ахуйн буюу бусад үйл ажиллагаанд саад учруулах

165.1. Хувиараа аж ахуй эрхлэгч буюу хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхээс хууль бусаар татгалзсан, эсхүл түүнийг бүртгэхээс зайлсхийсэн, тодорхой үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгохоос хууль бусаар татгалзсан, зохион байгуулалт-эрх зүйн хэлбэрээс нь шалтгаалан хувиараа аж ахуй эрхлэгч буюу хуулийн этгээдийн эрх ба хууль ёсны ашиг сонирхлыг хязгаарласан, түүнчлэн бие даасан байдлыг нь хууль бусаар хязгаарласан, эсхүл хувиараа аж ахуй эрхлэгч буюу хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс хууль бусаар оролцсон хэргийг албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээгээр торгож, гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл нэг зуун хориос нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх ял шийтгэнэ.

165.2. Энэ хэргийг хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн актыг зөрчиж үйлдсэн, түүнчлэн их хэмжээтэй хохирол учруулсан бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасаж хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наяс хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

166 дугаар зүйл. Газрын хууль бус хэлцлийг бүртгэх

166.1. Илт хууль бус газрын хэлцлийг бүртгэсэн, улсын газрын кадастрын бүртгэлийн мэдээ сэлтийг гуйвуулсан, түүнчлэн газрын төлбөрийн хэмжээг санаатай багасгасан хэргийг албан тушаалтан албан тушаалынхаа байдлыг ашиглаж шунахай буюу хувийн бусад ашиг сонирхлын үүднээс үйлдсэн бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл нэг зуун хориос нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх ял шийтгэнэ.

167 дугаар зүйл. Аж ахуйн хууль бус үйл ажиллагаа

167.1. Хуулийн этгээд ба хувиараа аж ахуй эрхлэгч бүртгэлгүйгээр буюу бүртгэлийн журам зөрчиж аж ахуйн үйл ажиллагаа эрхэлсэн, түүнчлэн хуурамч мэдээ сэлт агуулсан баримт бичгийг улсын бүртгэл эрхэлсэн байгууллагад гаргасан, түүнчлэн аж ахуй эрхлэх тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай байхад ийм зөвшөөрөлгүйгээр аж ахуйн үйл ажиллагаа явуулсан буюу тусгай зөвшөөрлийн шаардлагыг зөрчсөнөөс иргэн, аж ахуйн нэгж, байгууллага буюу улсад их хэмжээтэй хохирол учруулсан, эсхүл их хэмжээний орлого олсон бол арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун хориос нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

167.2. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн, эсхүл онц их хэмжээний орлого олсон бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

168 дугаар зүйл. Тэмдэггүй бараа ба бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, олж авах, хадгалах, тээвэрлэх буюу борлуулах

168.1. Хуурамч үйлдэхээс хамгаалсан онцгой албан татварын тэмдэг, тусгай тэмдэг буюу тохирлын тэмдэгтэй заавал байх бараа ба бүтээгдэхүүнийг борлуулах зорилгоор их хэмжээгээр үйлдвэрлэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн буюу борлуулсан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээгээр торгож, гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

168.2. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, эсхүл онц их хэмжээтэй үйлдсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр хоёроос зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

169 дүгээр зүйл. Банкны хууль бус үйл ажиллагаа

169.1. Зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай тохиолдолд бүртгүүлэхгүйгээр буюу тусгай зөвшөөрөлгүйгээр банкны үйл ажиллагаа (банкны ажилбар) эрхэлсэн буюу зөвшөөрлийн шаардлага ба нөхцөлийг зөрчсөнөөс иргэн, аж ахуйн нэгж, байгууллага буюу улсад их хэмжээний хохирол учруулсан, эсхүл их хэмжээний орлого олсон бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээгээр торгож, дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

169.2. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн, эсхүл онц их хэмжээний орлого олсон бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр гурваас долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

170 дугаар зүйл. Хуурмаг аж ахуй эрхлэл

170.1. Зээл авах, татвараас чөлөөлөгдөх, эд хөрөнгийн бусад ашиг олох, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага буюу улсад их хэмжээтэй хохирол учруулсан хориглосон үйл ажиллагаагаа халхавчлах зорилгоор аж ахуйн буюу банкны үйл ажиллагаа эрхлэх санаагүйгээр ашгийн төлөө байгууллага байгуулсан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээгээр торгож, дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

171 дүгээр зүйл. Гэмт замаар бусад этгээдийн олж авсан мөнгөн хөрөнгө буюу өөр эд хөрөнгийг ил болгох (угаах)

171.1. Илт гэмт замаар олж авсан мөнгөн хөрөнгө буюу бусад эд хөрөнгийг (энэхүү Төрөлжсөн хуулийн 183, 186, 187 дугаар зүйлд заасан гэмт хэргээс бусад) хууль ёсоор эзэмших, ашиглах ба захиран зарцуулах зорилгоор санхүүгийн ажилбар ба мөнгөн хөрөнгийн бусад хэлцэл буюу гэмт замаар бусад этгээдийн олж авсан өөр эд хөрөнгөөр хэлцэл хийсэн бол таван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэг жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгуулийн ял шийтгэнэ.

171.2. Энэ хэргийг их хэмжээтэй үйлдсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл дөрвөн хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

171.3. Энэ зүйлийн хоёр дахь хэсэгт заасан хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг, эсхүл албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль эсхүл торгуульгүйгээр дөрвөөс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

171.4. Энэ зүйлийн хоёр буюу гурав дахь хэсэгт заасан хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль эсхүл торгуульгүйгээр долоогоос арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Энэ зүйл ба түүнчлэн энэхүү Төрөлжсөн хуулийн 171 дүгээр зүйлд заасан их хэмжээтэй үйлдсэн санхүүгийн ажилбар ба мөнгөн хөрөнгө буюу өөр эд хөрөнгийн бусад хэлцэл гэж дөчин сая төгрөгөөс дээш санхүүгийн ажилбар ба мөнгөн хөрөнгө буюу өөр эд хөрөнгийн бусад хэлцлийг үзнэ.

172 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдсэний үр дүнд тухайн этгээдийн олж авсан мөнгөн хөрөнгө буюу бусад эд хөрөнгийг ил болгох (угаах)

172.1. Гэмт хэрэг үйлдсэний үр дүнд мөнгөн хөрөнгө буюу бусад эд хөрөнгөөр (энэхүү Төрөлжсөн хуулийн 183, 186, 187 дугаар зүйлд заасан гэмт хэргээс бусад) санхүүгийн ажилбар ба бусад хэлцэл үйлдсэн, эсхүл дурдсан мөнгө буюу бусад эд хөрөнгийг аж ахуйн буюу эдийн засгийн өөр үйл ажиллагаа явуулахын тулд ашигласан бол таван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэг жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгуулийн ял шийтгэнэ.

172.2. Энэ хэргийг их хэмжээтэй үйлдсэн бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

172.3. Энэ зүйлийн хоёр дахь хэсэгт заасан хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг, эсхүл албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл торгуульгүйгээр дөрвөөс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

172.4. Энэ зүйлийн хоёр буюу гурав дахь хэсэгт заасан хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл торгуульгүйгээр арваас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

173 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдэх замаар олж авсан эд хөрөнгийг олж авах буюу борлуулах

173.1. Илт гэмт замаар олсон эд хөрөнгийг урьдчилан амлалгүйгээр олж авсан буюу борлуулсан бол нэг сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наyas хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

173.2. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг, эсхүл шатахуун ба хүнсний бүтээгдэхүүн, автомашин буюу өөр эд хөрөнгийн хувьд их хэмжээтэй үйлдсэн бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээгээр торгож таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

173.3. Энэ зүйлийн хоёр дахь хэсэгт заасан хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг, эсхүл албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээгээр торгож гурваас долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

174 дүгээр зүйл. Хууль бусаар зээл авах

174.1. Хувиараа аж ахуй эрхлэгч буюу аж ахуйн нэгж, байгууллагын удирдагчаас банк буюу бусад зээлдэгчид аж ахуйн байдал, эсхүл санхүүгийн байдлынхаа талаар зориуд худал мэдээ сэлт гаргах замаар зээл, эсхүл хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл авснаас их хэмжээний хохирол учруулсан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

174.2. Төрийн зээлийг хууль бусаар авсан, түүнчлэн түүнийг зориулалтын бусаар ашигласнаас иргэн, аж ахуйн нэгж буюу байгууллагад их хэмжээтэй хохирол учруулсан бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээтэй торгууль, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

175 дугаар зүйл. Өрсөлдөөнийг хориглох, хязгаарлах буюу үгүй болгох

175.1. Дангаараа ноёрхсон хэт өндөр, эсхүл дангаараа ноёрхсон хямд үнэ тогтоох, зах зээлийг хуваах, зах зээлд орохыг хязгаарлах, эдийн үйл ажиллагаанд бусад субъект оролцохыг шахан зайлуулах, нэгдсэн үнэ тогтоох замаар өрсөлдөөнийг хориглосон, хязгаарласан буюу үгүй болгосноос их хэмжээтэй хохирол учруулсан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

175.2. Энэ хэргийг албан тушаалынхаа байдлыг ашиглаж, эсхүл урьдчилан тохиролцсон бүлэг үйлдсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

175.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг хүч хэрэглэж буюу түүнийг хэрэглэхээр айлган сүрдүүлж, түүнчлэн далайлган сүрдүүлэх шинжгүйгээр бусдын эд хөрөнгийг устгаж буюу гэмтээж, эсхүл түүнийг устгах буюу гэмтээхээр айлган сүрдүүлж, эсхүл зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль эсхүл торгуульгүйгээр гурваас долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Энэ зүйлд заасан их хэмжээ гэж дөчин сая төгрөгөөс дээш хохирол байхыг үзнэ.

176 дугаар зүйл. Хэлцэл хийх буюу татгалзахыг албадах

176.1. Далайлган сүрдүүлэх шинжгүйгээр хүч хэрэглэх, бусдын эд хөрөнгийг устгах буюу гэмтээх, түүнчлэн хохирогч буюу түүний ойрын хүний эрх ба хууль ёсны ашиг сонирхолд ноцтой гэм хор учруулж болохуйц мэдээ сэлт тараахаар айлган сүрдүүлж хэлцэл хийх буюу хэлцэл хийхээс татгалзуулахыг албадсан бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээгээр торгож, хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

176.2. Энэ хэргийг хүч хэрэглэж, эсхүл зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

177 дугаар зүйл. Барааны тэмдгийг хууль бусаар ашиглах

177.1. Бусдын барааны тэмдэг, үйлчилгээний тэмдэг, барааны гарал үүслийн газрын нэр буюу эдгээртэй адилтгаж болох нэг төрлийн барааны тэмдгийг хууль бусаар ашигласан хэргийг удаа дараа үйлдсэн буюу их хэмжээтэй хохирол учруулсан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наyas хоёр зуун дөчин цаг хүртэл албадан ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.

177.2. Монгол улсад бүртгэгдээгүй барааны тэмдэг буюу барааны гарал үүслийн газрын нэрийн хувьд сэрэмжлүүлэх тэмдэглэгээг хууль бусаар ашигласан хэргийг удаа дараа үйлдсэн буюу их хэмжээтэй хохирол учруулсан бол таван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэг жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун хориос нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.

177.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

178 дугаар зүйл. Аж ахуйн, татварын буюу банкны нууцыг хууль бусаар олж авах ба задруулах

178.1. Баримт бичиг ашиглан шамшигдуулах, худалдаж авах буюу айлган сүрдүүлэх, түүнчлэн бусад хууль бус аргаар аж ахуйн, татварын буюу банкны нууцыг агуулсан мэдээ сэлтийг цугларуулсан бол гурван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

178.2. Эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хариуцуулсан буюу албан буюу ажлын хувьд мэдэж авсан аж ахуйн, татварын буюу банкны нууцыг бүрдүүлсэн мэдээ сэлтийг хууль бусаар задруулсан буюу ашигласан бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасаж, таван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэг жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

178.3. Их хэмжээтэй хохирол учруулсан буюу шунахай сонирхлоор үйлдсэн бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа гүйцэтгэх эрхийг хасаж, зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

178.4. Энэ зүйлийн хоёр буюу гурав дахь хэсэгт заасан хэргийн улмаас хүнд хор уршиг учруулсан бол арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

179 дүгээр зүйл. Хуурамч мөнгө буюу үнэт цаас бэлтгэх буюу борлуулах

179.1. Хуурамч үндэсний мөнгөн тэмдэгт, улсын үнэт цаас буюу Монгол улсын валютын бусад үнэт цаас, эсхүл гадаадын валют буюу гадаадын валютын үнэт цаасыг борлуулах зорилгоор бэлтгэсэн буюу борлуулсан бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр таваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

179.2. Энэ хэргийг их хэмжээтэй үйлдсэн бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр долоогоос арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

179.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр наймаас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

180 дугаар зүйл. Хуурамч цахим эсхүл төлбөрийн карт ба төлбөрийн бусад баримт бичгийг бэлтгэх буюу борлуулах

180.1. Үнэт цаас бус хуурамч цахим эсхүл төлбөрийн карт, түүнчлэн бусад төлбөрийн баримт бичгийг борлуулах зорилгоор үйлдсэн буюу борлуулсан бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр хоёроос зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

180.2. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр дөрвөөс долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

181 дүгээр зүйл. Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх

181.1. Энэ зүйлийн хоёр дахь хэсэгт зааснаас бусад бараа буюу өөр зүйлийг Монгол улсын гаалийн хилээс гадуур буюу гаалийн хяналт шалгалтаас нуун дарагдуулж, эсхүл баримт бичиг буюу гаалийн адитгалын хэрэгсэл ашиглан хууран мэхэлж, эсхүл мэдүүлээгүйгээр буюу зохиомлоор мэдүүлж, их хэмжээтэй нэвтрүүлсэн бол гурван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

181.2. Монгол улсын гаалийн хилээр мансууруулах хэрэгсэл, сэтгэцэд нөлөөлөх бодис, тэдгээрийн тусгай хяналтад байвал зохих мансууруулах хэрэгсэл ба сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх ба бэлтгэхэд ашиглах адитгал, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүчтэй үйлчлэх, хорт, хордуулах, тэсэрч дэлбэрэх, радиоидэвхт бодис, радиацийн эх үүсвэр, цөмийн материал, галт зэвсэг, дэлбэлэгч төхөөрөмж, байлдааны галт хэрэгсэл, стратегийн нэн чухал ач холбогдол бүхий түүхий эдийн бараа буюу түүх, соёлын үнэт зүйлийг Монгол улсын гаалийн хилээс гадуур буюу гаалийн хяналт шалгалтаас нуун дарагдуулж, эсхүл баримт бичиг буюу гаалийн адитгалын хэрэгсэл ашиглан хууран мэхэлж, эсхүл мэдүүлээгүйгээр буюу зохиомлоор мэдүүлж, Монгол улсын хилээр нэвтрүүлсэн бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр гурваас долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

181.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг албан тушаалтан албан тушаалынхаа байдлыг ашиглаж, гаалийн хяналт шалгалт явуулж буй этгээдэд хүч хэрэглэж үйлдсэн бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

181.4. Энэ зүйлийн нэг, хоёр буюу гурав дахь хэсэгт заасан хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр долоогоос арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

182 дугаар зүйл. Үнэт металл, байгалийн үнэт чулууны хууль бус эргэлт

182.1. Монгол улсын хууль тогтоомжоор тогтоосон журам зөрчиж, үнэт металл, байгалийн үнэт чулуутай холбогдсон хэлцэл үйлдсэн, түүнчлэн гоёл чимэглэлийн ба ахуйн эдлэхүүнээс бусад үнэт металл, байгалийн үнэт чулууг аливаа хэлбэр, байдлаар хууль бусаар хадгалсан, тээвэрлэсэн буюу илгээсэн бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

182.2. Энэ хэргийг их хэмжээтэй, эсхүл урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил

хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

183 дугаар зүйл. Үнэт металл ба үнэт чулууг улсад тушаах журам зөрчих

183.1. Цэвэршүүлсэн үнэт металл ба улсад заавал тушаах үнэт чулуу буюу газрын хэвлийгээс олборлосон буюу хоёрдогч түүхий эдээс гаргаж авсан, түүнчлэн олдмол үнэт металл ба үнэт чулууг улсад заавал худалдахаас их хэмжээтэй зайлсхийсэн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

184 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж буюу хувь хүн гаалийн татвар төлөхөөс зайлсхийх

184.1. Аж ахуйн нэгж буюу хувь хүн гаалийн татвар төлөхөөс их хэмжээтэй зайлсхийсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наyas хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

184.2. Энэ хэргийг онц их хэмжээтэй, эсхүл урьдчилан тохиролцсон бүлэг үйлдсэн бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Гаалийн татвар төлөхөөс их хэмжээтэй зайлсхийсэн гэж төлөөгүй гаалийн татварын хэмжээ хорин сая төгрөгөөс дээш, харин онц их хэмжээ гэж дөчин сая төгрөгөөс дээш байхыг үзнэ.

185 дугаар зүйл. Дампууруулах хууль бус үйлдэл

185.1. Эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх буюу эд хөрөнгийн үүрэг, эд хөрөнгийн мэдээ сэлт, түүний хэмжээ ба байрлаж байгаа газар, эсхүл эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх буюу эд хөрөнгийн үүргийн тухай бусад мэдээлэл, бусад этгээдэд эзэмшүүлэхээр эд хөрөнгө шилжүүлсэн, эд хөрөнгө өгсөн буюу устгасныг нуусан, түүнчлэн хуулийн этгээд буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчийн эдийн засгийн үйл ажиллагааг илэрхийлсэн нягтлан бодох бүртгэлийн ба бусад тооцооны баримт бичгийг нуусан, устгасан, хуурмагласан ба дампуурлын шинжтэй байхад эдгээр үйлдлийн улмаас их хэмжээтэй хохирол учруулсан бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

185.2. Бусад үүрэг гүйцэтгүүлэгчид зориуд хохирол учруулж хуулийн этгээдийн удирдлага буюу түүнийг үүсгэн байгуулагч (оролцогч), эсхүл хувиараа аж ахуй эрхлэгч тодорхой үүрэг гүйцэтгүүлэгчийн эд хөрөнгийн шаардлагыг хууль бусаар хангасан үйлдлийг дампуурлын шинж байхад их хэмжээтэй хохирол учруулж үйлдсэн бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

186 дугаар зүйл. Санаатай буюу хуурмаг дампуурал

186.1. Хуулийн этгээдийн удирдлага буюу үүсгэн байгуулагч (оролцогч), эсхүл хувиараа аж ахуй эрхлэгч үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагаар мөнгөн үүргийг бүрэн хэмжээгээр хангах буюу зайлшгүй төлбөр төлөх үүргээ зориуд гүйцэтгэх чадваргүй болсноос их хэмжээний хохирол учруулсан бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл найман сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

186.2. Хуулийн этгээдийн удирдлага буюу үүсгэн байгуулагч (оролцогч), тухайн хуулийн этгээд, түүнчлэн хувиараа аж ахуй эрхлэгч төлбөрийн чадваргүй болсон тухай нийтэд зориуд худал зарласан бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

187 дугаар зүйл. Хувь хүн албан татвар төлөхөөс зайлсхийх

187.1. Хувь хүн Монгол улсын татварын хууль тогтоомжийн дагуу хувь хүний орлогын албан татвар ногдох орлогыг зориуд худал тодорхойлж түүнийг төлөхөөс их хэмжээтэй зайлсхийсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

187.2. Энэ хэргийг онц их хэмжээтэй үйлдсэн бол зургаагаас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сараас гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Энэ зүйлд заасан их хэмжээ гэж санхүүгийн гурван жил дараалан таван сая төгрөгөөс дээш, төлөөгүй татварын хувь хэмжээ төлөх ёстой татварын 10 хувиас дээш, эсхүл арван таван сая төгрөгөөс дээш, харин онц их хэмжээ гэж санхүүгийн гурван жил дараалан хорин саяас дээш, төлөөгүй татварын хувь хэмжээ төлөх ёстой татварын 20 хувиас дээш, эсхүл жаран сая төгрөгөөс дээш байхыг үзнэ.

188 дугаар зүйл. Аж ахуйн нэгж албан татвар төлөхөөс зайлсхийх

188.1. Аж ахуйн нэгж Монгол улсын татварын хууль тогтоомжийн дагуу аж ахуйн нэгжийн албан татвар ногдох орлогыг зориуд худал тодорхойлж түүнийг төлөхөөс их хэмжээтэй зайлсхийсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

188.2. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг, эсхүл онц их хэмжээтэй үйлдсэн бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл

хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Энэ зүйлд заасан их хэмжээ гэж санхүүгийн гурван жил дараалан хорин сая төгрөгөөс дээш, төлөөгүй татварын хувь хэмжээ төлөх ёстой татварын 10 хувиас дээш, эсхүл жаран сая төгрөгөөс дээш, харин онц их хэмжээ гэж санхүүгийн гурван жил дараалан нэг зуун саяас дээш, төлөөгүй татварын хувь хэмжээ төлөх ёстой татварын 20 хувиас дээш, эсхүл гурван зуун сая төгрөгөөс дээш байхыг үзнэ.

189 дүгээр зүйл. Бүрэн эрхээ хортой ашиглах

189.1. Ашгийн буюу бусад аж ахуйн нэгжид удирдлагын чиг үүрэг гүйцэтгэж байгаа этгээд өөртөө буюу бусад этгээдэд ашиг ба давуу тал олгох, эсхүл бусдад гэм хор учруулах зорилгоор өөрийн бүрэн эрхийг тухайн аж ахуйн нэгжийн хууль ёсны ашиг сонирхолд харш байдлаар ашиглаж, иргэн буюу аж ахуйн нэгжийн эрх ба хууль ёсны ашиг сонирхолд, эсхүл нийгэм буюу төрийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд ноцтой гэм хор учруулсан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наyas хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

189.2. Энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учруулсан бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. 1. Энэ бүлгийн зүйл ба энэхүү Төрөлжсөн хуулийн 188 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт заасан ашгийн буюу өөр аж ахуйн нэгжид удирдах чиг үүрэг гүйцэтгэж байгаа этгээд гэж өмчийн хэлбэрээс үл хамааран ашгийн төлөө аж ахуйн нэгж, түүнчлэн төрийн буюу нутгийн өөрийн удирдлагын бус ашгийн байгууллагад захирамжлан зохион байгуулах буюу захиргаа-аж ахуйн үүрэг байнга, түр, эсхүл тусгайлан олгосон бүрэн эрхийн дагуу гүйцэтгэж байгаа этгээдийг үзнэ.

2. Энэ зүйл ба энэ бүлгийн өөр зүйлд заасан хэргийг үйлдэж, төрийн буюу нутгийн өөрийн удирдлагын бус ашгийн байгууллагын ашиг сонирхолд гэм хор учруулсан бол эрүүгийн мөрдөлтийг тухайн аж ахуйн нэгжийн өргөдлөөр буюу түүний зөвшөөрснөөр явуулна.

3. Энэ зүйл ба энэ бүлгийн өөр зүйлд заасан хэргийг үйлдэж, бусад аж ахуйн нэгжийн ашиг сонирхол, түүнчлэн иргэн, нийгэм буюу төрийн ашиг сонирхолд гэм хор учруулсан бол эрүүгийн мөрдөлтийг нийтлэг үндэслэлийн дагуу явуулна.

190 дүгээр зүйл. Нотариатчийн ба аудиторчийн бүрэн эрхийг хортой ашиглах

190.1. Нотариатч буюу аудиторч өөртөө буюу бусад этгээдэд ашиг ба давуу тал олгох, эсхүл бусдад гэм хор учруулах зорилгоор өөрийн үйл ажиллагааны зорилтод харш байдлаар бүрэн эрхээ хортой ашиглаж, иргэн буюу аж ахуйн нэгжийн эрх ба хууль ёсны ашиг сонирхол, эсхүл нийгэм буюу төрийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд ноцтой гэм хор учруулсан бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж, гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

190.2. Энэ хэргийг зориуд насанд хүрээгүй буюу эрх зүйн чадамжгүй хүний хувьд үйлдсэн бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурван жил хүртэл

хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах буюу хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

191 дүгээр зүйл. Хувийн хамгаалалтын албан хаагчийн бүрэн эрхийг хэтрүүлэх

191.1. Хувийн хамгаалалтын удирдлага буюу албан хаагч тусгай зөвшөөрлөөр олгосон бүрэн эрхээ энэ үйл ажиллагааны зорилтод харш байдлаар хэтрүүлэн ашиглаж, хүч хэрэглэж буюу түүнийг хэрэглэхээр айлган сүрдүүлж үйлдсэн бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

191.2. Энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учруулсан бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасаж, долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

192 дугаар зүйл. Ашгийн хууль бус_шан харамж

192.1. Ашгийн буюу бусад байгууллагад удирдах чиг үүргийг гүйцэтгэж байгаа этгээд мөнгө, үнэт цаас, бусад эд хөрөнгийг бусдад хууль бусаар шилжүүлсэн, түүнчлэн эрхэлж байгаа албаны байдалтайгаа холбогдуулан эд хөрөнгийн шинжтэй үйлчилгээг түүнд хууль бусаар үзүүлсэн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

192.2. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

192.3. Ашгийн буюу бусад байгууллагад удирдах чиг үүргийг гүйцэтгэж байгаа этгээд мөнгө, үнэт цаас, бусад эд хөрөнгийг хууль бусаар авсан, түүнчлэн эрхэлж байгаа албаны байдалтайгаа холбогдуулан эд хөрөнгийн шинжтэй үйлчилгээг хууль бусаар ашигласан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

192.4. Энэ зүйлийн гурав дахь хэсэгт заасан хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг, эсхүл далайлган сүрдүүлж үйлдсэн бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл таван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг үйлдсэн этгээд хэрэв түүний хувьд далайлган сүрдүүлэлтээр хууль бус шан харамж өгсөн тухайгаа хэрэв эрүүгийн хэрэг үүсгэх эрх бүхий байгууллагад сайн дураараа мэдээлсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

IX ХЭСЭГ. НИЙГМИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА НИЙГМИЙН ХЭВ ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙГМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

193 дугаар зүйл. Террорист явуулга

193.1. Засаг төрийн байгууллага буюу олон улсын байгууллагаас гаргасан шийдвэрт нөлөөлөх зорилгоор хүн амыг айлгах ба хүний амь нас бусниулах, эд хөрөнгийн үлэмж хохирол учруулах, эсхүл өөр хүнд хор уршиг буй болгосон дэлбэлэх, галдан шатаах буюу бусад үйлдэл үйлдсэн, түүнчлэн дурдсан үйлдлийг үйлдэх зорилгоор айлган сүрдүүлсэн бол наймаас арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

193.2. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг этгээд, эсхүл галт зэвсэг хэрэглэж үйлдсэн бол арваас хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

193.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг зохион байгуулалттай бүлэг, эсхүл хүний амь насыг болгоомжгүй бусниулсан буюу өөр хүнд хор уршиг учруулсан, түүнчлэн хорт, хордуулах, донтуулах, химийн ба биологийн аюултай бодис ашиглаж үйлдсэн бол арван таваас хорин жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Террорист явуулгыг бэлтгэхэд оролцсон этгээд хэрэв засаг төрийн байгууллагад цаг тухайн үед нь сэрэмжлүүлсэн буюу террорист явуулгыг хэрэгжүүлэх явдлыг болиулахад бусад аргаар тус дөхөм үзүүлсэн ба тухайн этгээдийн үйлдэлд өөр гэмт хэргийн бүрэлдүүнгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

194 дүгээр зүйл. Террорист үйл ажиллагаанд тус дөхөм үзүүлэх ба зориуд худал мэдээлэх

194.1. Энэхүү Төрөлжсөн хуулийн 192, 195, 198, 257, 258, 259, 334 дүгээр зүйлд заасан аль нэг гэмт хэрэг үйлдэхэд хатгасан, элсүүлсэн буюу өөр байдлаар бусдыг татан оролцуулсан, дурдсан гэмт хэргийн аль нэгийг үйлдэх зорилгоор зэвсэглэсэн буюу бэлтгэсэн, түүнчлэн терроризмыг санхүүжүүлсэн бол дөрвөөс наймаас арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

194.2. Албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр долоогоос арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

194.3. Дэлбэлэх, галдан шатаах буюу хүмүүсийг үхэлд хүргэх аюул буй болгох бусад үйлдэл, эд хөрөнгийн үлэмжхэн хохирол учруулах, эсхүл нийгэмд аюултай өөр хор уршиг учруулахад бэлтгэж байгаа талаар зориуд худал мэдээлсэн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгууль, эсхүл нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. 1. Энэ зүйлд заасан терроризмыг санхүүжүүлсэн гэж энэхүү Төрөлжсөн хуулийн 192 дүгээр зүйл, 193 дугаар зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэг, 194, 195, 198, 257, 258, 259, 334 дүгээр зүйлд заасан аль нэгэн гэмт хэргийг зохион байгуулах, бэлтгэх буюу үйлдэхийг санхүүжүүлэх зориулалттай болохыг ойлгон ухамсарлаж, хэрэгсэл олгосон буюу цугларуулсан, эсхүл санхүүгийн туслалцаа үзүүлсэн, эсхүл дурдсан гэмт хэргийн аль нэгийг үйлдэхээр байгуулсан буюу байгуулагдах зохион байгуулалттай бүлэг, хууль бус зэвсэглэсэн бие бүрэлдэхүүн, гэмт бүлэглэл (гэмт байгууллага)-д хангалт хийснийг үзнэ.

2. Энэ зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн этгээд хэрэв засаг төрийн байгууллагад цаг тухайн үед нь мэдэгдэж сэрэмжлүүлсэн буюу санхүүжүүлсэн буюу үйлдэхэд нь тус дөхөм үзүүлсэн гэмт хэргийг болиулах, эсхүл таслан зогсооход бусад аргаар тус дөхөм үзүүлсэн ба тухайн этгээдийн үйлдэлд өөр гэмт хэргийн бүрэлдүүнгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

195 дугаар зүйл. Террорист үйл ажиллагаанд уриалах буюу түүнийг нийтийн өмнө зөвтгөх

195.1. Террорист үйл ажиллагаа явуулахыг нийтэд уриалсан буюу терроризмыг нийтийн өмнө зөвтгөсөн бол хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээгээр торгож дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

195.2. Энэ хэргийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглаж үйлдсэн бол дөрвөөс хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны дөрвөн жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасаж, таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. 1. Энэ зүйлд заасан терроризмыг нийтийн өмнө зөвтгөх гэж нийтийн өмнө терроризм зөв зүйтэй хэмээсэн үзэл суртал ба практикийг хүлээн зөвшөөрч, дэмжих ба дагах хэрэгцээ шаардлага байгааг нийтийн өмнө мэдэгдснийг үзнэ.

196 дугаар зүйл. Хүн барьцаалах

196.1. Суллах нөхцөл болгон ямар нэгэн үйлдэл хийлгэх буюу ямар нэгэн үйлдэл хийхээс түдгэлзүүлэхээр төр, байгууллага буюу иргэнийг албадах зорилгоор хүнийг барьцаалсан буюу тогтоон барьсан бол таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

196.2. Энэ хэргийг:

- 196.2.1. урьдчилан тохиролцсон бүлэг;
- 196.2.2. хүний амь нас буюу эрүүл мэндэд аюултай хүч хэрэглэж;
- 196.2.3. галт зэвсэг буюу зэвсгийн чанартай ашиглагдах зүйл хэрэглэж;
- 196.2.4. зориуд насанд хүрээгүй хүний хувьд;
- 196.2.5. зориуд жирэмсэн эмэгтэйн хувьд;
- 196.2.6. хоёр буюу түүнээс дээш этгээдийн хувьд;

196.2.7. шунахай сэдэлтээр буюу хөлсөлж үйлдсэн бол зургаагаас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

196.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг зохион байгуулалттай бүлэг, эсхүл хүний амь насыг болгоомжгүй бусниулсан буюу өөр хүнд хор уршиг учруулсан бол наймаас хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Сайн дураараа буюу засаг төрийн шаардлагаар барьцаалагдсан хүний чөлөөлсөн этгээдийн үйлдэлд өөр гэмт хэргийн бүрэлдүүнгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

197 дугаар зүйл. Зандачлах

197.1. Иргэн буюу байгууллага руу довтлох зорилгоор зэвсэглэсэн тогтвортой бүлэг байгуулсан, түүнчлэн ийм бүлгийг удирдсан бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр арваас арван таван хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

197.2. Зэвсэглэсэн тогтвортой бүлэг буюу түүний үйлдсэн довтолгоонд оролцсон бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр наймаас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

197.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр арван хоёроос хорин жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ.

198 дугаар зүйл. Гэмт бүлэглэл (гэмт байгууллага) зохион байгуулах

198.1. Хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдэхийн тулд гэмт бүлэглэл (гэмт байгууллага) байгуулсан, түүнчлэн гэмт бүлэглэл (байгууллага) буюу түүний бүтцийн нэгжийг удирдсан, тэрчлэн хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдэх төлөвлөгөө ба нөхцөлийг боловсруулах зорилгоор зохион байгуулалттай бүлгийн зохион байгуулагч, удирдагч буюу бусад төлөөлөгчдийн нэгдэл байгуулсан бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр долоогоос арван таван хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

198.2. Гэмт бүлэглэл (гэмт байгууллага), эсхүл зохион байгуулагч, удирдагч буюу зохион байгуулалттай бүлгийн бусад төлөөлөгчийн нэгдэлд оролцсон бол хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр гурваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

198.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр арваас хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Гэмт бүлэглэл (гэмт байгууллага) буюу түүний бүтцэд орсон нэгж эсхүл зохион байгуулагч, удирдагч буюу зохион байгуулалттай бүлгийн бусад төлөөлөгчийн нэгдэлд оролцохоо сайн дураараа бүрмөсөн больсон ба тухайн гэмт хэргийг илрүүлэх буюу таслан зогсооход идэвхтэй тус дөхөм үзүүлсэн этгээдийг хэрэв түүний үйлдэлд өөр гэмт хэргийн бүрэлдүүнгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

199 дүгээр зүйл. Агаарын буюу бусад тээврийн хөлөг онгоц эсхүл төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг авч зугатаах

199.1. Агаарын буюу усан тээврийн хөлөг онгоц, эсхүл төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг авч зугатаасан, түүнчлэн ийм хөлөг онгоц буюу бүрэлдэхүүнийг авч зугатаах зорилгоор эзэмдэн авсан бол дөрвөөс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

199.2. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг, эсхүл хүний амь нас буюу эрүүл мэндэд аюултай хүч хэрэглэж, эсхүл ийм хүч хэрэглэхээр айлган сүрдүүлж, эсхүл зэвсэг буюу зэвсгийн чанартай ашиглах зүйл хэрэглэж үйлдсэн бол долоогоос арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

199.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг зохион байгуулалттай бүлэг, эсхүл хүний амь насыг болгоомжгүй бусниулсан буюу өөр хүнд хор уршиг учруулсан бол наймаас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

200 дугаар зүйл. Нийтийн эмх замбараагүй байдал буй болгох

200.1. Хүч хэрэглэж, түйвээж, галдан шатааж, эд хөрөнгө устгаж, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис буюу дэлбэлэгч төхөөрөмж хэрэглэж, түүнчлэн засаг төрийн төлөөлөгчийг зэвсэглэн эсэргүүцэж нийтийн эмх замбараагүй байдлыг зохион байгуулсан бол гурваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

200.2. Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан нийтийн эмх замбараагүй байдлыг буй болгоход идэвхтэй оролцсон бол гурваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

200.3. Засгийн төлөөлөгчийн хууль ёсны шаардлагад үл захирагдах ба нийтийн эмх замбараагүй байдалд уриалсан, түүнчлэн иргэдэд хүч хэрэглэхийг уриалсан бол хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

201 дүгээр зүйл. Танхайрах

201.1. Олон нийтийг илтэд үл хүндэтгэж нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчин зэвсэг буюу зэвсгийн чанартай ашиглах зүйл хэрэглэж үйлдсэн бол нэг зуун наяс хоёр зуун дөчин цаг хүртэл албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

201.2. Урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг, эсхүл засгийн төлөөлөгч, эсхүл нийгмийн хэв журам хамгаалах үүрэг гүйцэтгэж байгаа буюу нийгмийн хэв журмын зөрчлийг таслан зогсоох гэсэн бусад этгээдийг эсэргүүцсэн бол долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

202 дугаар. Эрээчих

202.1. Барилга буюу бусад байгууламжийг сараачсан, нийтийн тээврийн хэрэгсэл буюу олон нийтийн бусад газрын эд хөрөнгийг эвдсэн бол нэг сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр нэг зуун наяс хоёр зуун дөчин цаг хүртэл албадан ажил хийлгэх, эсхүл зургаагаас нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

202.2. Энэ хэргийг бүлэг этгээд буюу улс төр, үзэл суртал, арьсны өнгө, үндэстний буюу шашны үзэн ядалт буюу дайсагналын сэдэлтээр үйлдсэн бол гурван жил хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

203 дугаар зүйл. Амьдралын чухал объектыг хэрэгцээнээс гаргах

203.1. Цахилгаан, дулаан, холбоо, орон сууц ба нийтийн аж ахуйн буюу амьдралын чухал бусад объектыг сүйтгэсэн, гэмтээсэн буюу бусад аргаар хэрэгцээнээс гаргасан нь шунахай буюу танхайрах сэдэлтээр үйлдсэн бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

203.2. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг буюу албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, буюу торгуульгүйгээр гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

203.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийн улмаас хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

204 дүгээр зүйл. Уул, барилга буюу бусад ажил гүйцэтгэхэд аюулгүй байдлын журам зөрчих

204.1. Уулын, барилгын буюу бусад ажил гүйцэтгэх үед аюулгүй байдлын журам зөрчсөнөөс хүний эрүүл мэндэд хүнд гэм хор болгоомжгүй, эсхүл их хэмжээтэй хохирол учруулсан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

204.2. Энэ хэргийн улмаас хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол таван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

204.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийн улмаас хоёр буюу түүнээс дээш хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Энэ бүлгийн зүйлд заасан их хэмжээтэй хохирол гэж хорин сая төгрөгөөс дээш хохирлыг үзнэ.

205 дугаар зүйл. Тэсэрч дэлбэрэх объектод аюулгүй байдлын журам зөрчих

205.1. Тэсэрч дэлбэрэх аюул бүхий объектод аюулгүй ажиллагааны журам зөрчсөнөөс хүний эрүүл мэндэд хүнд гэм хор болгоомжгүй, эсхүл их хэмжээтэй хохирол учруулсан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах ял шийтгэнэ.

205.2. Энэ хэргийн улмаас хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол таван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

205.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийн улмаас хоёр буюу түүнээс дээш хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

206 дугаар зүйл. Тэсэрч дэлбэрэх, шатамхай бодис ба пиротехникийн эдлэхүүнийг бүртгэх, хадгалах, тээвэрлэх ба ашиглах журам зөрчих

206.1. Тэсэрч дэлбэрэх, шатамхай бодис буюу пиротехникийн эдлэхүүнийг бүртгэх, хадгалах, тээвэрлэх ба ашиглах журам зөрчсөн, түүнчлэн эдгээр бодисыг шуудан буюу тээшээр хууль бусаар илгээсэнээс хүний эрүүл мэндэд болгоомжгүй хүнд гэм хор учруулсан буюу хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол таван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

207 дугаар зүйл. Галын аюулгүй байдлын журам зөрчих

207.1. Галын аюулгүй байдлыг сахин хангуулах үүрэг бүхий этгээд галын аюулгүй байдлын журам зөрчсөнөөс хүний эрүүл мэндэд болгоомжгүй хүнд гэм хор учруулсан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

207.2. Энэ хэргийн улмаас хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

207.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийн улмаас хоёр буюу түүнээс дээш хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

208 дугаар зүйл. Цөмийн материал буюу радиоидэвхт бодистой хууль бусаар харьцах

208.1. Цөмийн материал буюу радиоидэвхт бодисыг хууль бусаар олж авсан, хадгалсан, ашигласан, шилжүүлсэн бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

208.2. Энэ хэргийн улмаас хүний амь насыг болгоомжгүй бусниулсан буюу бусад хүнд хор уршиг учруулсан бол таван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

208.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийн улмаас хоёр буюу түүнээс дээш хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

209 дүгээр зүйл. Зэвсэг, түүний бүрдэл хэсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис ба дэлбэлэгч төхөөрөмжийг хууль бусаар олж авах, шилжүүлэх, борлуулах, хадгалах, тээвэрлэх буюу авч явах

209.1. Галт зэвсэг, түүний бүрдэл хэсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис буюу дэлбэлэгч төхөөрөмжийг хууль бусаар олж авсан, шилжүүлсэн, борлуулсан, хадгалсан, тээвэрлэсэн буюу авч явсан бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл нэг сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

209.2. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг үйлдсэн бол хоёроос зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

209.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол таваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

209.4. Газын зэвсэг, хүйтэн зэвсэг, түүний дотор металл зэвсгийг хууль бусаар борлуулсан бол нэг зуун наyas хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Энэ зүйлд заасан зүйлийг сайн дураараа өгсөн этгээдийн үйлдэлд өөр гэмт хэргийн бүрэлдүүнгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө. Энэ зүйл, түүнчлэн энэхүү Төрөлжсөн хуулийн 209 дүгээр зүйлд заасан зүйлийг тухайн этгээдийг албадан саатуулах явцад гаргуулан авсан, түүнчлэн түүнийг мөрдөн байцаалтын ажиллагааны явцад илрүүлсэн ба гаргуулан авсаныг сайн дураараа өгсөн гэж үзэхгүй.

210 дугаар зүйл. Зэвсэг хууль бусаар бэлтгэх

210.1. Галт зэвсэг, түүний бүрдэл хэсгийг хууль бусаар бэлтгэсэн буюу засварласан, түүнчлэн байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис буюу дэлбэлэгч төхөөрөмжийг хууль бусаар бэлтгэсэн хоёроос дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

210.2. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг үйлдсэн бол хоёроос зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

210.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол таваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

210.4. Газын зэвсэг, хүйтэн зэвсэг, түүний дотор металл зэвсгийг хууль бусаар бэлтгэсэн бол нэг зуун наyas хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Энэ зүйлд заасан зүйлийг сайн дураараа өгсөн этгээдийн үйлдэлд өөр гэмт хэргийн бүрэлдүүнгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

211 Дүгээр зүйл. Галт зэвсгийг хайхрамжгүй хадгалах

211.1. Галт зэвсгийг бусад этгээд ашиглах нөхцөлийг бүрдүүлж, түүнийг хайхрамжгүй хадгалсаны улмаас хүнд хор уршиг учруулсан бол нэг сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наyan цаг хүртэл албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

212 дугаар зүйл. Зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис ба дэлбэлэгч төхөөрөмжийг хамгаалах үүрэгт назгай хандах

212.1. Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис буюу дэлбэлэгч төхөөрөмжийг хамгаалах үүрэг бүхий этгээд үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас түүнийг ашиглан шамшигдуулахад хүргэсэн буюу устгасан, эсхүл өөр хүнд гэм хор учруулсан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

213 дугаар зүйл. Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис ба дэлбэлэгч төхөөрөмжийг ашиглан шамшигдуулах эсхүл далайлган сүрдүүлэх

213.1. Галт зэвсэг түүний бүрдэл хэсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис буюу дэлбэлэгч төхөөрөмжийг ашиглан шамшигдуулсан, эсхүл далайлган сүрдүүлсэн бол гурваас долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

213.2. Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг, эсхүл албан тушаалынхаа байдлыг ашиглаж, эсхүл хүний амь нас буюу эрүүл мэндэд аюулгүй хүч хэрэглэж, эсхүл ийм хүч хэрэглэхээр айлган сүрдүүлж үйлдсэн бол хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

213.3. Энэ зүйлийн нэг ба хоёр дахь хэсэгт заасан хэргийг зохион байгуулалттай бүлэг, эсхүл хүний амь нас буюу эрүүл мэндэд аюултай хүч хэрэглэж, эсхүл ийм хүч хэрэглэхээр айлган сүрдүүлж үйлдсэн бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр долоогоос арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

ХОРИН ТАВДУГААР БҮЛЭГ. ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНД БА НИЙГМИЙН ЗАН СУРТАХУУНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

214 дүгээр зүйл. Мансууруулах хэрэгсэл, сэтгэцэд нөлөөт бодис буюу эдгээртэй адилтгах зүйлийг хууль бусаар олж авах, хадгалах, тээвэрлэх, бэлтгэх, дахин боловсруулах

214.1. Мансууруулах хэрэгсэл, сэтгэцэд нөлөөт бодис буюу эдгээртэй адилтгах зүйлийг борлуулах зорилгогүйгээр хууль бусаар их хэмжээтэй бус олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, бэлтгэсэн, дахин боловсруулсан бол нэг сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

214.2. Энэ хэргийг их хэмжээтэй үйлдсэн бол хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр гурваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. 1. Энэ зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж, мансууруулах хэрэгсэл, сэтгэцэд нөлөөт бодис буюу эдгээртэй адилтгах зүйлийг сайн дураараа шилжүүлэн өгсөн ба мансууруулах хэрэгсэл, сэтгэцэд нөлөөт бодис буюу эдгээртэй адилтгах зүйлийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг илрүүлэх буюу таслан зогсооход идэвхтэй тус дөхөм үзүүлсэн, түүнийг үйлдсэн этгээдийг илчилсэн, гэмт замаар олсон эд хөрөнгийг илрүүлсэн этгээдийг энэ гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө. Мансууруулах хэрэгсэл, сэтгэцэд нөлөөт бодис буюу эдгээртэй адилтгах зүйлийг тухайн этгээдийг албадан саатуулах явцад гаргуулан авсан, түүнчлэн түүнийг мөрдөн байцаалтын ажиллагааны явцад илрүүлсэн ба гаргуулан авсаныг сайн дураараа өгсөн гэж үзэхгүй.

2. Энэ зүйл, түүнчлэн энэхүү Төрөлжсөн хуулийн 214, 215 дугаар зүйлийн зорилгоор мансууруулах хэрэгсэл ба сэтгэцэд нөлөөт бодисын их хэмжээ ба онц их хэмжээг Монгол улсын засгийн газар батална.

3. Мансууруулах хэрэгсэл ба сэтгэцэд нөлөөт бодистой адилтгах зүйлийн их ба онц их хэмжээ нь мансууруулах хэрэгсэл ба сэтгэцэд нөлөөт бодисын их ба онц их хэмжээтэй дүйцсэн байна.

215 дугаар зүйл. Мансууруулах хэрэгсэл, сэтгэцэд нөлөөт бодис буюу тэдгээртэй адилтгах зүйлийг хууль бусаар үйлдвэрлэх, борлуулах буюу илгээх

215.1. Мансууруулах хэрэгсэл, сэтгэцэд нөлөөт бодис буюу эдгээртэй адилтгах зүйлийг хууль бусаар үйлдвэрлэсэн, борлуулсан буюу илгээсэн бол хоёроос найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

215.2. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг этгээд, эсхүл их хэмжээтэй, эсхүл арван найман насанд хүрсэн этгээдээс зориуд насанд хүрээгүй хүний хувьд үйлдсэн бол хорин сая

төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр гурваас арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

215.3. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, эсхүл албан тушаалынхаа байдлыг ашиглаж, эсхүл зориуд арван дөрвөн насанд хүрээгүй хүний хувьд, эсхүл онц их хэмжээтэй үйлдсэн бол дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр зургаагаас хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

216 дугаар зүйл. Мансууруулах хэрэгсэл буюу сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийн журам зөрчих

216.1. Мансууруулах хэрэгсэл, сэтгэцэд нөлөөт бодис, эсхүл тусгай хяналт бүхий мансууруулах хэрэгсэл буюу сэтгэцэд нөлөөт бодис бэлтгэхэд ашиглагдах багаж хэрэгсэл ба тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх, бэлтгэх, дахин боловсруулах, хадгалах, бүртгэх, борлуулах, худалдах, хуваарилах, тээвэрлэх, илгээх, олж авах, ашиглах, гаргах, оруулах, эсхүл устгах журам зөрчсөн, түүнчлэн мансууруулах хэрэгсэл буюу сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэхэд ашиглагдах ургамлыг тариалах журмыг хэрэв дурдсан журмыг сахин хангуулах үүрэг бүхий этгээд зөрчсөнөөс тэдгээр нь алдагдсан бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасаж, таван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэг жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгуулийн ял шийтгэнэ.

216.2. Энэ хэргийг шунахай сэдэлтээр үйлдсэн, эсхүл хүний эрүүл мэндэд гэм хор буюу өөр хүнд хор уршиг болгоомжгүй учруулсан бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасаж, гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

217 дугаар зүйл. Мансууруулах хэрэгсэл буюу сэтгэцэд нөлөөт бодисыг ашиглан шамшигдуулах эсхүл дайлган сүрдүүлэх

217.1. Мансууруулах хэрэгсэл буюу сэтгэцэд нөлөөт бодисыг ашиглан шамшигдуулсан, эсхүл далайлган сүрдүүлсэн бол гурваас долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

217.2. Энэ хэргийг албан тушаалынхаа байдлыг ашиглаж, эсхүл хүний амь нас буюу эрүүл мэндэд аюулгүй хүч хэрэглэж, эсхүл ийм хүч хэрэглэхээр айлган сүрдүүлж үйлдсэн бол хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр зургаагаас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

217.3. Энэ зүйлийн нэг, хоёр ба гурав дэхь хэсэгт заасан хэргийг зохион байгуулалттай бүлэг, эсхүл мансууруулах хэрэгсэл буюу сэтгэцэд нөлөөт бодисыг их хэмжээтэй, эсхүл хүний амь нас буюу эрүүл мэндэд аюултай хүч хэрэглэж, эсхүл ийм хүч хэрэглэхээр айлган сүрдүүлж үйлдсэн бол хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр наймаас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

218 дугаар зүйл. Мансууруулах хэрэгсэл буюу сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэхэд хатгах

218.1. Мансууруулах хэрэгсэл буюу сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэхэд бусдыг хатгасан бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

218.2. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг, эсхүл зориуд хоёр буюу түүнээс дээш насанд хүрээгүй хүний хувьд, эсхүл хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр айлган сүрдүүлж үйлдсэн бол гурваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

218.3. Энэ зүйлийн нэг, хоёр ба гурав дэхь хэсэгт заасан хэргийн улмаас хохирогчийн амь насыг болгоомжгүй бусниулсан буюу өөр хүнд хор уршиг учруулсан бол долоогоос арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Энэ зүйлд заасан үйлдэлд дархлалын олдмол хам өвчний халдвар ба бусад халдварт аюултай өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор мансууруулах хэрэгсэл ба сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэхэд ашиглагдах холбогдох багаж ба тоног төхөөрөмж хэрэглэхийг сурталчилсан тохиолдолд хэрэв энэ хэрэг нь эрүүл мэндийн салбар дахь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага ба мансууруулах бодис ба сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих байгууллагын зөвшөөрөлтэйгээр хэрэгжсэн бол хамаарагдахгүй.

219 дүгээр зүйл. Мансууруулах бодис агуулсан хориглосон ургамлыг хууль бусаар тариалах

219.1. Тариалахыг хориглосон ургамлыг тарих буюу ургуулах, түүнчлэн олс, намуу цэцэг буюу мансууруулах бодис агуулсан бусад ургамлыг тариалсан бол арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээгээр торгож хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

219.2. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг, эсхүл их хэмжээтэй үйлдсэн бол гурваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Энэ зүйлийн зорилгоор мансууруулах бодис агуулсан тариалахыг хориглосон ургамлын хэмжээг Монгол улсын засгийн газар батална.

220 дугаар зүйл. Мансууруулах хэрэгсэл буюу сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх байр байгуулах, эсхүл тэтгэх

220.1. Мансууруулах хэрэгсэл буюу сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэх байр байгуулсан, эсхүл тэтгэсэн бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

220.2. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол гурваас долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

221 дүгээр зүйл. Мансууруулах хэрэгсэл буюу сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар, эсхүл олж авах эрх олгосон хуурамч жор олгох

221.1. Мансууруулах хэрэгсэл буюу сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар олгосон, эсхүл жор буюу олж авах эрх олгосон бусад баримт бичгийг хуурамчаар үйлдсэн бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс

буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

222 дугаар зүйл. Хүчтэй үйлчлэх буюу хорт бодисыг борлуулах зорилго бүхий хууль бус эргэлт

222.1. Мансууруулах хэрэгсэл, сэтгэцэд нөлөөт бодист хамаарагдахгүй хүчтэй үйлчлэх буюу хорт бодис, эсхүл тэдгээрийг бэлтгэх буюу дахин боловсруулах тоног төхөөрөмжийг борлуулах зорилгоор хууль бусаар бэлтгэсэн, дахин боловсруулсан, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн буюу илгээсэн, түүнчлэн хууль бусаар борлуулсан бол нэг сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван сар жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

222.2. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг үйлдсэн бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун хориос хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

222.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг зохион байгуулалттай бүлэг, эсхүл хүчтэй үйлчлэх бодисыг их хэмжээтэй үйлдсэн бол таван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэг жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл дөрвөөс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

222.4. Хүчтэй үйлчлэх буюу хорт бодисыг үйлдэрлэх, олж авах, хадгалах, бүртгэх, тээвэрлэх буюу илгээх журмыг зөрчсөн нь тэдгээрийг ашиглан шамшигдуулахад болгоомжгүй хүргэсэн, эсхүл өөр ноцтой гэм хор учруулсан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Хүчтэй үйлчлэх ба хорт бодисын жагсаалт, түүнчлэн их хэмжээг энэ зүйл ба энэхүү Төрөлжсөн хуулийн зорилгоор Монгол улсын Засгийн газар батална.

223 дугаар зүйл. Хууль бусаар хувийн эмнэлэг буюу хувийн эмийн үйл ажиллагаа эрхлэх

223.1. Тусгай зөвшөөрөлгүй этгээд хувийн эмнэлгийн үйлчилгээ буюу хувийн эмийн үйл ажиллагаа эрхэлснээс хүний эрүүл мэндэд болгоомжгүй гэм хор учруулсан бол бол таван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэг жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль эсхүл гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

223.2. Энэ хэргийн улмаас хүний амь нас болгоомжгүй бусниулсан бол таван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

224 дүгээр зүйл. Ариун цэвэр-эрүүл ахуйн журам зөрчих

224.1. Ариун цэвэр-эрүүл ахуйн журам зөрчсөнөөс хүмүүсийг олноор нь болгоомжгүй өвчлүүлсэн буюу хордуулсан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах ял шийтгэнэ.

224.2. Энэ хэргийн улмаас хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол нэг зуун наяс хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл таван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

225 дугаар зүйл. Хүмүүсийн амь нас буюу эрүүл мэндэд аюул учруулахуйц нөхцөл байдлын тухай зарлан мэдээллийг нуун дарагдуулах

225.1. Хүмүүсийн амь нас буюу эрүүл мэнд, эсхүл хүрээлэн буй орчинд аюул учруулахуйц үйл явдал, үйл баримт буюу үзэгдлийн тухай мэдээллээр хүн амыг хангах ба түүнийг арилгах арга хэмжээ авах бүрэн эрх бүхий байгууллагын үүрэг хүлээсэн этгээд тийм мэдээллийг нуун дарагдуулсан буюу гуйвуулсан бол арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах ял шийтгэнэ.

225.2. Энэ хэргийг Монгол улсын төрийн албан тушаалтан үйлдсэн, эсхүл тийм хэргийн улмаас хүний эрүүл мэндэд гэм хор буюу бусад хүнд хор уршиг учруулсан бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

226 дугаар зүйл. Аюулгүй байдлын шаардлагад нийцээгүй бараа ба бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх эсхүл борлуулах, ажил үйлчилгээ гүйцэтгэх

226.1. Хэрэглэгчийн амь нас буюу эрүүл мэндийн аюулгүй байдлын шаардлагад нийцээгүй бараа ба бүтээгдэхүүн, ажил буюу үйлчилгээг борлуулах зорилгоор үйлдвэрлэсэн, хадгалсан буюу тээвэрлэсэн, эсхүл борлуулсан, түүнчлэн дурдсан бараа, ажил буюу үйлчилгээ аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгааг гэрчилсэн албан ёсны баримт бичгийг хууль бусаар олгосон буюу ашигласан бол арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

226.2. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг, эсхүл зургаа хүртэл настай хүүхдэд зориулсан бараа, ажил буюу үйлчилгээний хувьд, эсхүл хүний эрүүл мэндэд хүнд гэм хор болгоомжгүй учруулсан, эсхүл хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

226.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийн улмаас хоёр буюу түүнээс дээш хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол дөрвөөс арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

227 дугаар зүйл. Биеэ үнэлэхэд татан оролцуулах

227.1. Биеэ үнэлэхэд бусдыг татан оруулсан буюу биеэ үнэлэхийг үргэлжлүүлэхийг албадсан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

227.2. Энэ хэргийг хүч хэрэглэж буюу түүнийг хэрэглэхээр айлган сүрдүүлж, эсхүл хохирогчийг Монгол улсын хилээр нэвтрүүлсэн буюу түүнийг хилийн чанадад хууль бусаар тогтоон барьсан, эсхүл урьдчилан тохиролцсон бүлэг үйлдсэн бол зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

227.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг зохион байгуулалттай бүлэг, эсхүл зориуд насанд хүрээгүй хүний хувьд үйлдсэн бол гурваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

228 дугаар зүйл. Биеэ үнэлэхийг зохион байгуулах

228.1. Бусад этгээдээс биеэ үнэлэхийг зохион байгуулсан, түүнчлэн биеэ үнэлэх байр байгуулсан буюу биеэ үнэлэх байраар байнга хангасан бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

228.2. Энэ үйлийг албан тушаалынхаа байдлыг ашиглаж, эсхүл хүч хэрэглэж буюу түүнийг хэрэглэхээр айлган сүрдүүлж, эсхүл зориуд насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлэхээр ашиглаж үйлдсэн бол зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

228.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг зориуд арван дөрвөн насанд хүрээгүй хүний хувьд үйлдсэн бол гурваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

229 дүгээр зүйл. Садар самуунд холбогдох материал буюу зүйлийг хууль бусаар тараах

229.1. Садар самууны материал буюу зүйлийг тараах буюу зар сурталчилгаа хийх зорилгоор хууль бусаар бэлтгэсэн, түүнчлэн садар самууны холбогдолтой хэвлэл, кино буюу видеоматериал, дүрслэл буюу бусад зүйлийг хууль бусаар худалдсан бол таваас арван сая

төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

230 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүнийг дүрсэлсэн садар самуунд холбогдох материал буюу зүйлийн бэлтгэлт ба эргэлт

230.1. Насанд хүрээгүй хүнийг зориуд дүрсэлсэн садар самууны холбогдолтой материал буюу зүйлийг бэлтгэсэн, хадгалсан, улсын хилээр нэвтрүүлсэн, тараасан, нийтэд үзүүлсэн буюу ийм зүйлийн зар сурталчилгаа хийсэн, түүнчлэн арван найман насанд хүрсэн этгээдээс садар самууны холбогдолтой үзүүлбэр арга хэмжээнд зориуд насанд хүрээгүй хүнийг тоглогчоор татан оруулсан бол зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

230.2. Энэ хэргийг эцэг эх буюу насанд хүрээгүй хүнийг хүмүүжүүлэх үүрэг хуулиар хүлээсэн бусад этгээд, түүнчлэн насанд хүрээгүй хүнд хяналт тавих үүрэг хүлээсэн боловсролын, хүмүүжлийн, эмчилгээний буюу бусад байгууллагын ажилтан, эсхү багш, эсхүл урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг, эсхүл зориуд арван дөрвөн насанд хүрээгүй хүний хувьд үйлдсэн бол гурваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

231 дүгээр зүйл. Түүх ба соёлын дурсгалт зүйлийг устгах буюу гэмтээх

231.1. Төрийн хамгаалалтад авсан түүх, соёл, байгалийн цогцолбор буюу объект, түүнчлэн түүхийн буюу соёлын үнэ цэнэ бүхий зүйл буюу баримт бичгийг устгасан буюу гэмтээсэн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

231.2. Энэ хэргийг Монгол улсын хэмжээний ач холбогдол бүхий онцгой үнэ цэнэ бүхий объект буюу дурсгалт зүйлийн хувьд үйлдсэн бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

232 дугаар зүйл. Өөд бологсдын бие ба тэдгээрийг оршуулсан газрыг гутаах

232.1. Өөд бологсдын биеийг гутаасан, эсхүл өөд бологсдыг чандарлах буюу буяны ёслол үйлдэхэд зориулсан оршуулгын газар, булшны байгууламж буюу оршуулгын газрын барилгыг устгасан, гэмтээсэн, эрээчсэн бол нэг сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун хориос хоёр зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

232.2. Энэ хэргийг бүлэг этгээд, урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг, эсхүл хүч хэрэглэж буюу түүнийг хэрэглэхээр айлган сүрдүүлж үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

233 дугаар зүйл. Мал, амьтантай харгис хэрцгий харьцах

233.1. Танхайрах буюу шунахай сэдэлтээр, эсхүл бага насны хүүхдийн дэргэд мал, амьтан, эсхүл хээлтэй буюу нялх төлтэй мал, амьтантай харгис хэрцгий харьцаж үхүүлсэн буюу бэртээсэн бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүлнэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

233.2. Энэ хэргийг бүлэг этгээд, урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

ХОРИНЗУРГААДУГААР БҮЛЭГ. ЭКОЛОГИЙН ГЭМТ ХЭРЭГ

234 дугаар зүйл. Ажил, үйлдвэрлэлийн үед хүрээлэн буй орчиныг хамгаалах журам зөрчих

234.1. Үйлдвэр, хөдөө аж ахуй, эрдэм шинжилгээний болон бусад объектыг төлөвлөх, байршуулах, барих, ашиглалтад оруулах ба ашиглах үед хүрээлэн буй орчиныг хамгаалах журмыг тухайн журмыг сахин хангуулах үүрэг хүлээсэн этгээд зөрчсөний улмаас радиоидэвхт орчиныг ноцтой өөрчилсөн, хүний эрүүл мэндэд гэм хор учруулсан, амьтныг олноор нь үхүүлсэн, эсхүл өөр хүнд хор уршиг учруулсан бол таван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэг жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун хориос хоёр зуун дөчин цаг хүртэл хэмжээгээр албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

235 дугаар зүйл. Экологид аюултай бодис ба хог хаягдалтай харьцах журам зөрчих

235.1. Аюултай хог хаягдлын хориглосон төрлийн үйлдвэрлэл, радиоидэвхт, бактериологи, химийн бодис ба хаягдлыг тээвэрлэх, хадгалах, булах, ашиглах буюу бусад байдлаар харьцах талаар тогтоосон журам зөрчсөний улмаас хүний эрүүл мэнд буюу хүрээлэн буй орчинд ноцтой гэм хор учруулах аюулыг буй болгосон бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

235.2. Энэ хэргийн улмаас хүрээлэн буй орчиныг бохирдуулсан, хордуулсан буюу халдваржуулсан, хүний эрүүл мэндэд гэм хор учруулсан, эсхүл амьтныг олноор нь үхүүлсэн, түүнчлэн экологийн гамшигийн голомтод үйлдсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

235.3. Энэ зүйлийн нэг ба хоёр дахь хэсэгт заасан хэргийн улмаас хүний амь насыг болгоомжгүй бусниулсан, эсхүл хүмүүсийг олноор нь өвчлүүлсэн бол гурваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

236 дугаар зүйл. Микробиологийн, эсхүл биологийн үүсгэгч буюу хорт бодистой харьцах аюулгүй байдлын журам зөрчих

236.1. Микробиологийн, эсхүл биологийн бусад үүсгэгч буюу хорт бодистой харьцах аюулгүй байдлын журам зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд гэм хор учруулсан, тахал буюу юүтгэл тараасан, эсхүл бусад хүнд хор уршиг учруулсан бол нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

236.2. Энэ хэргийн улмаас хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол нэг зуун наяс хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасаж таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

237 дугаар зүйл. Мал эмнэлгийн ба ургамлын өвчин ба хортонтой тэмцэх талаар тогтоосон журам зөрчих

237.1. Мал эмнэлгийн журам зөрчсөний улмаас юүтгэл болгоомжгүй тараасан буюу бусад хүнд хор уршиг учруулсан бол таван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэг жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

237.2. Ургамлын өвчин ба хортонтой тэмцэх талаар тогтоосон журам зөрчсөний улмаас хүнд хор уршиг болгоомжгүй учруулсан бол таван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэг жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах ял шийтгэнэ.

238 дугаар зүйл. Ус бохирдуулах

238.1. Гадаргууны буюу газрын доорхи ус, ундны усан хангамжийн эх үүсвэрийг бохирдуулсан, тагласан, ширгээсэн, эсхүл байгалийн унаган төрхийг бусад байдлаар өөрчилж амьтны буюу ургамлын аймаг, загасны нөөц, ойн буюу хөдөө аж ахуйд ноцтой гэм хор учруулсан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл таван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

238.2. Энэ хэргийн улмаас хүний эрүүл мэндэд гэм хор учруулсан, эсхүл амьтныг олноор нь үхүүлсэн, эсхүл дархан цаазат газар нутагт, эсхүл экологийн гамшигийн голомтод үйлдсэн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

238.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийн улмаас хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

239 дүгээр зүйл. Агаар бохирдуулах

239.1. Агаарыг бохирдуулагч бодисыг гадагшуулах журам зөрчсөн буюу тоног төхөөрөмж, байгууламж ба бусад объектын ашиглалтын журам зөрчсөний улмаас агаарын байгалийн унаган төрхийг бохирдуулсан буюу бусад байдлаар өөрчилсөн бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл таван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

239.2. Энэ хэргийн улмаас хүний эрүүл мэндэд гэм хор болгоомжгүй учруулсан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

239.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийн улмаас хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

240 дүгээр зүйл. Газар эвдэх

240.1. Хөдөө аж ахуйн хортой бүтээгдэхүүн буюу бордоо, ургамлын идэвхжүүлэгч, химийн хорт бодис ба бусад химийн буюу биологийн хорт бодисыг хадгалах, ашиглах ба тээвэрлэх үед тэдгээртэй харьцах журам зөрчсөний улмаас газрыг хордуулсан, бохирдуулсан буюу бусад байдлаар эвдсэн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

240.2. Энэ хэргийг экологийн гамшигийн голомтод үйлдсэн бол хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

240.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийн улмаас хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

241 дүгээр зүйл. Газрын хэвлий хамгаалах ба ашиглах журам зөрчих

241.1. Ашигт малтмалын хайгуултай холбоогүйгээр зураг төсөл зохиох, байршуулах, барилга барих, уулын боловсруулах үйлдвэр буюу газрын доорхи байгууламжийг ашиглалтад оруулах ба ашиглах үед газрын хэвлийг хамгаалах ба ашиглах журам зөрчсөн, түүнчлэн ашигт малтмалын байршлын талбайд дур зоргоороо барилга барьсаны улмаас үлэмжхэн хохирол учруулсан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ял шийтгэнэ.

242 дугаар зүйл. Хууль бусаар ан агнах

242.1. Их хэмжээний хохирол учруулж, эсхүл тээврийн механик хэрэгсэл буюу агаарын хөлөг, тэсэрч дэлбэлэх бодис, газ буюу шувуу ба ан амьтныг олноор нь устгах өөр арга

хэрэглэж, эсхүл бүрмөсөн хориглосон шувуу ба ан амьтныг агнаж, эсхүл дархан цаазтай, эсхүл экологийн гамшигийн голомтод хууль бусаар ан агнасан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

242.2. Энэ хэргийг албан тушаалынхаа байдлыг ашиглаж, эсхүл урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

243 дугаар зүйл. Ойг хууль бусаар огтлох

243.1. Ой буюу ойд хамааралгүй мод, бут сөөг, ороонгыг хууль бусаар огтолсон, түүнчлэн тэдгээрийн өсөлтийг зогсоох хүртэл гэмтээсэн нь үлэмж хэмжээтэй бол нэг сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл зургаагаас нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

243.2. Ой буюу ойд хамааралгүй мод, бут сөөг, ороонгыг хууль бусаар огтолсон, түүнчлэн тэдгээрийн өсөлтийг зогсоох хүртэл гэмтээсэн хэргийг бүлэг этгээд, эсхүл албан тушаалынхаа байдлыг ашиглаж, эсхүл их хэмжээтэй үйлдсэн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, нэг зуун наyas хоёр зуун дөчин цаг хүртэл албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс хоёр жилийн хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

243.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг онц их хэмжээтэй, урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

244 дүгээр зүйл. Ойг устгах буюу гэмтээх

244.1. Гал ба бусад орчин тойрондоо аюултай зүйлтэй болгоомжгүй харьцсаны үр дүнд ойг устгасан буюу гэмтээсэн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

244.2. Галдан шатаах, нийтэд аюултай бусад арга, эсхүл бохирдуулах буюу бусад сөрөг нөлөөллийн үр дүнд ойг устгасан буюу гэмтээсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван зуун мянгаас таван сая төгрөг хүртэл хэмжээтэй

буюу ялтны нэг сараас нэг жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

245 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай нутаг дэвсгэр ба байгалийн объектын дэглэм зөрчих

245.1. Дархан цаазтай газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газрын ба төрөөс тусгайлан хамгаалсан байгалийн бусад газар нутгийн дэглэм зөрчсөний улмаас үлэмж хохирол учруулсан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.

ХОРИН ДОЛООДУГААР БҮЛЭГ. ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БА ТЭЭВЭР АШИГЛАЛТЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

246 дугаар зүйл. Хөдөлгөөний аюулгүй байдал ба төмөр зам, агаарын буюу усан замын тээврийн ашиглалтын журам зөрчих

246.1. Төмөр зам, агаарын буюу усан замын тээврийн хөдөлгөөний ба ашиглалтын аюулгүй байдлын журмыг тухайн журмыг сахин хангуулах үүрэг бүхий ажил буюу албан тушаал эрхэлж буй этгээд зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүнд гэм хор болгоомжгүй учруулсан бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

246.2. Энэ хэргийн улмаас хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

246.3. Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан хэргийн улмаас хоёр буюу түүнээс хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

247 дугаар зүйл. Замын хөдөлгөөний ба тээврийн хэрэгсэл ашиглалтын журам зөрчих

247.1. Автомашин, эсхүл тээврийн бусад механик хэрэгсэл жолоодож яваа этгээд замын хөдөлгөөний буюу тээврийн хэрэгсэл ашиглалтын журам зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүнд гэм хор болгоомжгүй учруулсан бол таван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах буюу хасахгүйгээр хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

247.2. Энэ хэргийн улмаас хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол гурван жил хүртэл хугацаагаар тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

247.3. Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан хэргийн улмаас хоёр буюу түүнээс хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол гурван жил хүртэл хугацаагаар тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Энэ зүйлд заасан тээврийн бусад механик хэрэгсэл гэж троллейбус, түүнчлэн трактор ба өөрөө явагч бусад машин, мотоцикл ба бусад тээврийн механик хэрэгслийг үзнэ.

248 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийг чанар муутай засварлах ба техникийн гэмтэлтэй тээврийн хэрэгслийг ашиглалтад гаргах

248.1. Тээврийн хэрэгсэл, зам, дохиоллын буюу холбооны хэрэгсэл, эсхүл тээврийн бусад тоног төхөөрөмжийг чанар муутай засварласан, түүнчлэн тээврийн хэрэгслийн техникийн байдлын төлөө хариуцлага хүлээсэн этгээд техникийн хувьд бүрэн бус тээврийн хэрэгслийг ашиглалтад гаргасны улмаас хүний эрүүл мэндэд хүнд гэм хор болгоомжгүй учруулсан бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

248.2. Энэ хэргийн улмаас хүний амь нас болгоомжгүй бусниулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

248.3. Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан хэргийн улмаас хоёр буюу түүнээс хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

249 дүгээр зүйл. Тээврийн хэрэгсэл, зам харилцааны төхөөрөмжийг хэрэгцээнээс гаргах

249.1. Тээврийн хэрэгсэл, зам, дохиоллын буюу холбооны хэрэгсэл, эсхүл тээврийн бусад тоног төхөөрөмжийг эвдсэн, гэмтээсэн буюу өөр байдлаар ашиглах боломжгүй болгосон, түүнчлэн тээврийн зам харилцааг хааснаас хүний эрүүл мэндэд хүнд гэм хор болгоомжгүй, эсхүл их хэмжээтэй хохирол учруулсан бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

249.2. Энэ хэргийн улмаас хүний амь нас болгоомжгүй бусниулсан бол гурваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

249.3. Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан хэргийн улмаас хоёр буюу түүнээс хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол зургаагаас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

250 дугаар зүйл. Тээврийн ажлын аюулгүй байдлыг хангах журам зөрчих

250.1. Зорчигч, явган зорчигч буюу хөдөлгөөний бусад оролцогч хөдөлгөөний аюулгүй байдлын буюу тээврийн хэрэгсэл ашиглалтын журам зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүнд гэм хор болгоомжгүй учруулсан бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

250.2. Энэ хэргийн улмаас хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол таван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

250.3. Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан хэргийн улмаас хоёр буюу түүнээс хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

251 дүгээр зүйл. Замын барилга, ашиглалт буюу засварын аюулгүй байдлын журам зөрчих

251.1. Замын барилга, ашиглалт буюу засварын аюулгүй байдлыг зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүнд гэм хор болгоомжгүй учруулсан бол дөрвөн жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

251.2. Энэ хэргийн улмаас хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол таван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл таван жил мөн хугацаагаар хорих ял шийтгэнэ.

251.3. Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан хэргийн улмаас хоёр буюу түүнээс хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

252 дугаар зүйл. Олон улсын нислэгийн журам зөрчих

252.1. Заасан маршрутын зөвшөөрөл, нисэх газар, агаарын хаалга, нислэгийн өндөр буюу олон улсын нислэгийн журмыг өөр байдлаар зөрчсөн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

ХОРИН НАЙМДУГААР БҮЛЭГ. КОМПЬЮТЕРИЙН МЭДЭЭЛЛИЙН ГЭМТ ХЭРЭГ

253 дугаар зүйл. Компьютерийн мэдээлэлд хууль бусаар нэвтрэн орох

253.1. Компьютер буюу компьютерийн систем, түүний сүлжээнд байгаа хуулиар хамгаалагдсан компьютерийн мэдээлэлд хууль бусаар нэвтрэн орж мэдээллийг устгаж, хааж, өөрчилж, эсхүл хувилаж компьютерийн ажиллагаа, түүний систем буюу сүлжээг зөрчсөн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

253.2. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг, эсхүл албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын

хэмжээний торгууль, эсхүл нэгээс хоёр жил хүртэл хугацааны засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

254 дүгээр зүйл. Компьютерийн хөнөөлт программ бүтээх, ашиглах ба тараах

254.1. Компьютерийн мэдээллийг зөвшөөрөлгүйгээр устгах, хаах, өөрчлөх буюу хувилах зорилгоор компьютерийн программ зохион бүтээсэн, программд өөрчлөлт оруулсан, нянтай программыг тусгайлан зохион бүтээсэн, түүнчлэн ийм программ буюу ийм программ бүхий агуулагчийг ашигласан, эсхүл тараасан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээгээр торгож гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

254.2. Энэ хэргийн улмаас хүнд хор уршиг болгоомжгүй учруулсан бол гурваас долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

255 дугаар зүйл. Компьютер буюу компьютерийн систем, түүний сүлжээний ашиглалтын журам зөрчих

255.1. Компьютер, түүний систем буюу сүлжээнд нэвтрэн орох эрх бүхий этгээд компьютерийн хуулиар хамгаалагдсан мэдээллийг устгах, хаах буюу хувилахад хүргэхээр компьютерийн ашиглалт, компьютерийн систем буюу түүний сүлжээний журам зөрчсөний улмаас ноцтой гэм хор учруулсан бол таван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл нэг зуун наyas хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах ял шийтгэнэ.

255.2. Энэ хэргийн улмаас хүнд хор уршиг болгоомжгүй учруулсан бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Х ХЭСЭГ. ТӨРИЙН ЭРХ МЭДЛИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

ХОРИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ.

ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛЛЫН ҮНДЭС БА ТӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

256 дугаар зүйл. Төрд тэрслэх

256.1. Монгол улсын иргэн тагнуул хийсэн, төрийн нууцыг шилжүүлэн өгсөн, эсхүл өөр байдлаар гадаад улс буюу түүний төлөөлөгчөөс Монгол улсын гадаад аюулгүй байдалд хохирол учруулсан дайсагнасан үйл ажиллагаа явуулахад туслалцаа үзүүлсэн бол хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээгээр торгож, арван хоёроос хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Энэ зүйл ба энэхүү Төрөлжсөн хуулийн 256, 258 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн этгээд хэрэв засаг төрийн байгууллагад сайн дураараа ба цаг тухайн үед нь мэдээлсэн буюу Монгол улсын ашиг сонирхолд цаашид учрах хохирлыг зайлуулахад бусад

байдлаар тус дөхөм үзүүлсэн ба хэрэв түүний үйлдэлд өөр гэмт хэргийн бүрэлдүүнгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

257 дугаар зүйл. Тагнуул хийх

257.1. Гадаад улс, гадаадын байгууллага буюу тэдгээрийн төлөөлөгчид дамжуулах зорилгоор улсын нууц бүхий мэдээ сэлтийг дамжуулсан, түүнчлэн цугларуулсан, ашиглан шамшигдуулсан буюу хадгалсан, түүнчлэн Монгол улсын гадаад аюулгүй байдалд хохирол учруулахад ашиглах бусад мэдээ сэлтийг гадаадын тагнуулын даалгавраар дамжуулсан буюу цугларуулсан бол арваас хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

258 дугаар зүйл. Төрийн буюу нийгмийн зүтгэлтний амь насанд халдах

258.1. Төрийн буюу нийгмийн зүтгэлтний төрийн буюу улс төрийн үйл ажиллагааг зогсоох, эсхүл ийм үйл ажиллагаанаас өс авах зорилгоор түүний амь насанд халдсан бол арван хоёроос хорин жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл бүх насаар нь хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ.

259 дүгээр зүйл. Төрийн эрх мэдлийг хүчээр эзлэн авах

259.1. Төрийн эрх мэдлийг хүчээр эзлэн авах буюу Монгол улсын Үндсэн хуулийг зөрчиж төрийн эрх мэдлийг хүчээр тогтоон барих, түүнчлэн Монгол улсын үндсэн хуулийн байгууллыг хүч хэрэглэж зөрчихөд чиглэгдсэн үйлдэл үйлдсэн бол арван хоёроос хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

260 дугаар зүйл. Зэвсэгт үймээн

260.1. Монгол улсын үндсэн хуулийн байгууллыг унагаах буюу хүч хэрэглэн өөрчлөх, эсхүл Монгол улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг зөрчих зорилгоор зэвсэгт үймээн зохион байгуулсан, эсхүл түүнд идэвхтэй оролцсон бол арван хоёроос хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

261 дүгээр зүйл. Хэт даварсан үйл ажиллагаа явуулахыг нийтэд уриалах

261.1. Хэт даварсан үйл ажиллагаа явуулахад нийтийг уриалсан бол арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

261.2. Энэ хэргийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглаж үйлдсэн бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасаж таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

262 дугаар зүйл. Хорлон сүйтгэх

262.1. Монгол улсын эдийн засгийн ба батлан хамгаалах хүчин чадлыг сулруулах зорилгоор үйлдвэр, байгууламж, зам ба мэдээллийн хэрэгсэл, холбооны хэрэгсэл, хүн амын амьдралыг хангах объектыг сүйтгэх буюу гэмтээхэд чиглэгдсэн дэлбэлсэн, галдан шатаасан буюу бусад үйлдэл үйлдсэн бол арваас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

262.2. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол арван хоёроос хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

263 дугаар зүйл. Төрийн нууцыг задруулах

263.1. Албаны буюу ажлын хувьд итгэмжлэгдэн хариуцсан буюу мэдэж авсан этгээд төрийн нууцыг агуулсан мэдээ сэлтийг задруулсан нь бусдад мэдээж болсон ба төрд тэрслэх гэмт хэргийн шинжгүй бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

263.2. Энэ хэргийн улмаас хүнд хор уршиг болгоомжгүй учруулсан бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасаж гурваас долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

264 дугаар зүйл. Төрийн нууц баримт бичгийг үгүй болгох

264.1. Төрийн нууцыг мэдэх болсон этгээд төрийн нууцыг агуулсан баримт бичигтэй харьцах талаар тогтоосон журмыг зөрчсөний улмаас төрийн нууц бүхий баримт бичиг, түүнчлэн төрийн нууцын мэдээ сэлтийг агуулсан зүйлийг болгоомжгүй үгүй болгосон буюу хүнд хор уршиг учруулсан бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

ГУЧИДУГААР БҮЛЭГ. ТӨРИЙН ЭРХ МЭДЭЛ, ТӨРИЙН АЛБАНЫ АШИГ СОНИРХОЛ БА НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ БАЙГУУЛЛАГЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

265 дугаар зүйл. Албан тушаалтан бүрэн эрхээ хортой ашиглах

265.1. Албан тушаалтан албаныхаа бүрэн эрхийг албан ажлын ашиг сонирхолд харш ашигласан нь шунахай буюу хувийн бусад ашиг сонирхлын үүднээс үйлдэгдсэн ба иргэн буюу байгууллагын эрх ба хууль ёсны ашиг сонирхол, эсхүл нийгэм буюу төрийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг ноцтой зөрчсөн бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл таван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

265.2. Энэ хэргийг Монгол улсын төрийн албан тушаал эрхэлж байгаа этгээд үйлдсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

265.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийн улмаас хүнд хор уршиг учруулсан бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасаж арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. 1. Энэ бүлгийн зүйлд заасан албан тушаалтан гэж засгийн төлөөлөгчийн чиг үүрэг, эсхүл захирамжлан-зохион байгуулах, захиргаа-аж ахуйн чиг үүргийг төрийн байгууллага, нутгийн өөрийн удирдлагын байгууллага, түүнчлэн Монгол улсын зэвсэгт хүчин, бусад цэргийн бүрэлдэхүүнд байнга, түр буюу тусгайлан олгосон бүрэн эрхийн дагуу гүйцэтгэж байгаа этгээдийг үзнэ.

2. Энэхүү Төрөлжсөн хуулийн энэ бүлгийн зүйл ба бусад зүйлд заасан Монгол улсын төрийн албан тушаал эрхэлж байгаа этгээд гэж Монгол улсын үндсэн хууль болон бусад хуулиар тогтоосон төрийн байгууллагын бүрэн эрхийг шууд гүйцэтгэх албан тушаал эрхэлж байгааг ойлгоно.

3. Албан тушаалтанд хамаарагдахгүй төрийн албан хаагч ба нутгийн өөрийн удирдлагын байгууллагын албан хаагчид холбогдох зүйлд тусгайлан заасан тохиолдолд энэ бүлгийн зүйлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

266 дугаар зүйл. Албан тушаалтан бүрэн эрхээ хэтрүүлэх

266.1. Албан тушаалтан бүрэн эрхээсээ илтэд хэтэрсэн үйлдэл үйлдэж иргэн буюу байгууллагын эрх ба хууль ёсны ашиг сонирхол, эсхүл нийгэм буюу төрийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг ноцтой зөрчсөн бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл таван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

266.2. Энэ хэргийг Монгол улсын төрийн албан тушаал эрхэлж байгаа этгээд үйлдсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

266.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг хүч хэрэглэж буюу түүнийг хэрэглэхээр айлган сүрдүүлж, эсхүл зэвсэг буюу тусгай хэрэгсэл хэрэглэж, эсхүл хүнд хор уршиг учруулж үйлдсэн бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасаж гурваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

267 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах

267.1. Төсөв захирагч албан тушаалтан төсвийн хөрөнгийг төсөвт заагаагүй зориулалтаар их хэмжээтэй захиран зарцуулсан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл таван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

267.2. Энэ хэргийг Монгол улсын төрийн албан тушаал эрхэлж байгаа этгээд үйлдсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

268 дугаар зүйл. Албан тушаалтны бүрэн эрхийг завших

268.1. Албан тушаалтан бус төрийн албан хаагч буюу нутгийн өөрийн удирдлагын байгууллагын албан хаагч албан тушаалтны бүрэн эрхийг завшсан ба энэ үйлдэлтэй холбогдуулан иргэн буюу байгууллагын эрх ба хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг ноцтой зөрчсөн бол нэг сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун хориос нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

269 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагаанд хууль бусаар оролцох

269.1. Албан тушаалтан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх байгууллага үүсгэн байгуулах, эсхүл хуулиар хориглосон журамд харш байдлаар ийм байгууллагыг удирдахад биечлэн буюу итгэмжлэгдсэн этгээдээрээ дамжуулан оролцсон нь тухайн байгууллагаас хөнгөлөлт ба давуу байдал буюу бусад хэлбэрийн ивээл авахтай холбоотой байсан бол таван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасаж гурван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун хориос нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

270 дүгээр зүйл. Хахууль авах

270.1. Албан тушаалтан албаны бүрэн эрхэд хамаарах, эсхүл ийм үйлдэл (эс үйлдэхүй)-ээр албан тушаалынхаа байдлаараа тус үзүүлж чадахуйц, түүнчлэн албаны талаар ерөнхий ивээлд авч буюу зөнд нь орхих үйлдлээр хахууль өгөгч буюу түүнийг төлөөлсөн этгээдэд ашигтай үйлдэл (эс үйлдэхүй) хийж, биечлэн буюу зуучлагчаар дамжуулан мөнгө, үнэт цаас, бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн шинжтэй ашиг авсан бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасаж таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

270.2. Албан тушаалтан хууль бус үйлдэл (эс үйлдэхүй)-ээр хахууль авсан бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасаж гурваас долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

270.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан үйлийг Монгол улсын төрийн албан тушаал эрхэлж байгаа этгээд үйлдсэн бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасаж таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

270.4. Энэ зүйлийн нэг, хоёр буюу гурав дахь хэсэгт заасан хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг, эсхүл хахууль авахаар далайлган сүрдүүлж, эсхүл их хэмжээтэй үйлдсэн бол дөрвөөс дөчин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны таван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль буюу торгуульгүйгээр долоогоос арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Хахуулийн их хэмжээ гэж таван сая төгрөгөөс дээш хэмжээний мөнгө, үнэт цаас, бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн шинжтэй ашгийг үзнэ.

271 дүгээр зүйл. Хахууль өгөх

271.1. Албан тушаалтанд биечлэн буюу зуучлагчаар дамжуулан хахууль өгсөн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

271.2. Албан тушаалтнаар зориуд хууль бус үйлдэл (эс үйлдэхүй) үйлдүүлэхээр хахууль өгсөн бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Хахууль өгсөн этгээд хэрэв түүнийг албан тушаалтны зүгээс далайлган сүрдүүлж хахууль авсан буюу хахууль өгсөн талаар эрүүгийн хэрэг үүсгэх эрх бүхий байгууллагад сайн дураараа мэдээлсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

272 дугаар зүйл. Албан тушаалын хуурамч баримт бичиг үйлдэх

272.1. Албан тушаалтан, түүнчлэн албан тушаалтан бус төрийн албан хаагч буюу нутгийн өөрийн удирдлагын байгууллагын албан хаагч албан ёсны баримт бичигт зориуд худал мэдээ сэлт оруулсан, түүнчлэн дурдсан баримт бичигт бодит байдлыг гуйвуулсан засварыг шунахай буюу хувийн бусад сонирхлын үүднээс үйлдсэн бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наяс хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс хоёр жилийн хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

273 дугаар зүйл. Албан тушаалдаа цалгар назгай хандах

273.1. Албан тушаалтан албан ажилдаа цалгар назгай хандасны улмаас үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас их хэмжээний хохирол учруулсан бол таван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэг жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун хориос нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл зургаагаас нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

273.2. Энэ хэргийн улмаас бусдын эрүүл мэндэд болгоомжгүй хүнд гэм хор учруулсан буюу хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

273.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийн улмаас хоёр буюу түүнээс дээш хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Энэ зүйлд заасан их хэмжээ гэж таван сая төгрөгөөс дээш хэмжээтэй хохирлыг үзнэ.

ГУЧИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

274 дүгээр зүйл. Шүүн таслах ба урьдчилсан мөрдөн байцаах ажиллагаа явуулахад саад учруулах

274.1. Шүүн таслах ажиллагаа явуулахад саад учруулах зорилгоор шүүхийн үйл ажиллагаанд ямар нэгэн хэлбэрээр хөндлөнгөөс оролцсон бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

274.2. Хэргийг бүх талаас нь бүрэн ба бодитой мөрдөн байцаахад саад учруулах зорилгоор прокурор, мөрдөн байцаагч буюу хэрэг бүртгэгчийн үйл ажиллагаанд ямар нэгэн хэлбэрээр хөндлөнгөөс оролцсон бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль эсхүл нэг зуун наyas хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

274.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

275 дугаар зүйл. Шүүн таслах ба урьдчилсан мөрдөн байцаах ажиллагаа явуулахтай нь холбогдуулан айлгаж сүрдүүлэх буюу хүч хэрэглэх

275.1. Хэрэг буюу материалыг шүүхэд хянан хэлэлцэхтэй холбогдуулан шүүгч, иргэдийн төлөөлөгч буюу шүүн таслах ажиллагаа явуулахад оролцогч бусад этгээд, түүнчлэн тэдний ойрын хүнийг алах, эрүүл мэндэд нь хүнд гэм хор учруулах, эд хөрөнгийг нь устгах буюу гэмтээхээр айлган сүрдүүлсэн бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

275.2. Энэ хэргийг прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч, өмгөөлөгч, шинжээч, мэргэжилтэн, шүүхийн хуяг, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, түүнчлэн тэдний ойрын хүний хувьд урьдчилсан мөрдөн байцаах ажиллагаа, хэрэг буюу материалыг шүүхэд хянан хэлэлцэх, эсхүл шүүхийн шийтгэх тогтоол, шийдвэр буюу шүүхийн бусад актыг биелүүлэхтэй нь холбогдуулан үйлдсэн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

275.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг хүний амь нас буюу эрүүл мэндэд аюулгүй хүч хэрэглэж үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

275.4. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг хүний амь нас буюу эрүүл мэндэд аюултай хүч хэрэглэж үйлдсэн бол таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

276 дугаар зүйл. Шүүхийг эс хүндэтгэх

276.1. Шүүх хуралдаанд оролцогчдыг доромжилж шүүхийг үл хүндэтгэсэн бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

276.2. Энэ хэргийг шүүгч, иргэдийн төлөөлөгч буюу шүүн таслах ажиллагаа явуулахад оролцогч бусад этгээдийг доромжилж үйлдсэн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэгээс хоёр жил хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

277 дугаар зүйл. Шүүгч, иргэдийн төлөөлөгч, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч, шүүхийн хуяг, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийг гүтгэх

277.1. Хэрэг буюу материал шүүхэд хянан хэлэлцэхтэй нь холбогдуулан шүүгч, иргэдийн төлөөлөгч буюу шүүн таслах ажиллагаа явуулахад оролцож байгаа бусад этгээдийг гүтгэсэн бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

277.2. Энэ хэргийг прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч, шүүхийн хуяг, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн хувьд урьдчилсан мөрдөн байцаалт, эсхүл шүүхийн шийтгэх тогтоол, шийдвэр буюу шүүхийн өөр актын биелүүлэхтэй нь холбогдуулж үйлдсэн бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

278 дугаар зүйл. Гэм буруугүй хүнийг зориуд эрүүгийн хариуцлагад татах

278.1. Гэм буруугүй этгээдийг зориуд эрүүгийн хариуцлагад татсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

278.2. Энэ хэргийг үйлдэхдээ бусдыг хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдсэнд ялласан бол гурваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

279 дүгээр зүйл. Эрүүгийн хариуцлагаас хууль бусаар чөлөөлөх

279.1. Прокурор, мөрдөн байцаагч буюу хэрэг бүртгэгч гэмт хэрэг үйлдсэнд сэжиглэгдэж буюу яллагдаж байгаа этгээдийг эрүүгийн хариуцлагаас хууль бусаар чөлөөлсөн бол хоёроос долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

280 дугаар зүйл. Хууль бусаар албадан саатуулах, цагдан хорих

280.1. Хүнийг хууль бусаар зориуд албадан саатуулсан бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

280.2. Хүнийг хууль бусаар зориуд цагдан хорьсон бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

280.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийн улмаас хүнд хор уршиг учруулсан бол гурваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

281 дүгээр зүйл. Мэдүүлэг гаргуулахаар албадах

281.1. Мөрдөн байцаагч буюу хэрэг бүртгэгчийн зүгээс айлган сүрдүүлэх, дарамтлах буюу хууль бус бусад үйлдлийн замаар сэжигтэн, яллагдагч, хохирогч, гэрчээс мэдүүлэг гаргуулах, эсхүл шинжээч, мэргэжилтнээс дүгнэлт буюу мэдүүлэг гаргуулахаар албадсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

281.2. Энэ хэргийг хүч хэрэглэж, тохуурхан даажигнаж буюу эрүү шүүлт тулгаж үйлдсэн бол хоёроос найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

282 дугаар зүйл. Нотлох баримт хуурмаглах

282.1. Хэрэгт оролцогч этгээд буюу түүний төлөөлөгч иргэний хэргийн нотлох баримтыг хуурмагласан бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

282.2. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор буюу өмгөөлөгч эрүүгийн хэргийн нотлох баримтыг хуурмагласан бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасаж, гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

282.3. Хүнд буюу онц хүнд гэмт хэрэгт эрүүгийн хэргийн нотлох баримтыг хуурмагласан, түүнчлэн нотлох баримт хуурмагласны улмаас хүнд хор уршиг учруулсан бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасаж, гурваас долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

283 дугаар зүйл. Хууль бус шийтгэх тогтоол, шийдвэр буюу шүүхийн бусад актыг зориуд гаргах

283.1. Шүүх (шүүгч) хууль бус шүүхийн шийтгэх тогтоол, шийдвэр буюу шүүхийн бусад актыг зориуд гаргасан бол арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны хоёр жил сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

283.2. Энэ хэргийн улмаас шүүхээс хорих ял ногдуулсан шийтгэх тогтоол гаргасан буюу өөр хүнд хор уршиг учруулсан бол гурваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

284 дүгээр зүйл. Зориуд худал мэдээлэх

284.1. Гэмт хэрэг үйлдсэн талаар зориуд худал мэдээлсэн бол таван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэг жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наyas хоёр зуун дөчин цаг хүртээл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

284.2. Энэ хэргийг үйлдэхдээ хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдсэнд ялласан бол таваас арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

284.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг яллах нотлох баримт зохиомлоор буй болгож үйлдсэн бол зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

285 дугаар зүйл. Зориуд худал мэдүүлэг өгөх, шинжээч, мэргэжилтний дүгнэлт гаргах буюу буруу орчуулах

285.1. Гэрч, хохирогч зориуд худал мэдүүлэг, эсхүл шинжээч зориуд худал дүгнэлт буюу мэдүүлэг, мэргэжилтэн зориуд худал мэдүүлэг өгсөн, түүнчлэн шүүхэд буюу урьдчилсан мөрдөн байцаалтад зориуд буруу орчуулсан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наяс хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

285.2. 385.2. Энэ хэргийг үйлдэхдээ хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдсэнд ялласан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Гэрч, хохирогч, шинжээч, мэргэжилтэн буюу орчуулагч нь хэрэв хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад буюу шүүхийн шийтгэх тогтоол буюу шүүхийн шийдвэр гарахаас өмнө сайн дураараа худал мэдүүлэг, дүгнэлт гаргасан буюу зориуд худал орчуулснаа мэдэгдсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

286 дугаар зүйл. Гэрч буюу хохирогч мэдүүлэг өгөхөөс татгалзах

286.1. Гэрч, хохирогч мэдүүлэг өгөхөөс татгалзсан бол нэг сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу гурав сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун хориос нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

287 дугаар зүйл. Мэдүүлэг гаргуулах буюу мэдүүлэг өгөхөөс татгалзуулах, эсхүл буруу орчуулга хийлгэхээр худалдаж авах буюу албадах

287.1. Худал мэдүүлэг гаргуулах зорилгоор гэрч, хохирогчийг, эсхүл худал дүгнэлт буюу худал мэдүүлэг гаргуулах зорилгоор шинжээч, мэргэжилтнийг, түүнчлэн буруу орчуулуулах зорилгоор орчуулагчийг худалдан авсан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наяс хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

287.2. Гэрч, хохирогчоор худал мэдүүлэг гаргуулах, эсхүл шинжээч, мэргэжилтнээр худал дүгнэлт буюу худал мэдүүлэг гаргуулах, түүнчлэн орчуулагчаар буруу орчуулуулахаар албадсан, түүнчлэн дурдсан этгээдийг мэдүүлэг өгөхөөс татгалзуулах явдлыг эдгээр этгээд буюу түүний ойрын хүнийг дарамтлах, алах, эрүүл мэндэд нь гэм хор учруулах, эд хөрөнгийг нь устгах буюу гэмтээхээр айлган сүрдүүлсэн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу

ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

287.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг дурдсан этгээдийн амь нас буюу эрүүл мэндэд аюулгүй хүч хэрэглэж үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

287.4. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг зохион байгуулалттай бүлэг, эсхүл дурдсан этгээдийн амь нас буюу эрүүл мэндэд аюултай хүч хэрэглэж үйлдсэн бол гурваас долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

288 дугаар зүйл. Урьдчилсан мөрдөн байцаалтын нууцыг задруулах

288.1. Хуулиар тогтоосон журмын дагуу урьдчилсан мөрдөн байцаалтын мэдээ сэлтийг задруулахгүй байх талаар сануулга авсан этгээд мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгчийн зөвшөөрөлгүйгээр түүнийг задруулсан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

289 дүгээр зүйл. Битүүмжилсэн буюу хураавал зохих эд хөрөнгийн талаархи хууль бус үйлдэл

289.1. Итгэмжлэгдэн хариуцсан этгээд битүүмжилсэн эд хөрөнгийг үрэгдүүлсэн буюу хууль бусаар шилжүүлсэн, түүнчлэн банк, зээлийн байгууллагын албан хаагч битүүмжилсэн мөнгөн хөрөнгийн хадгаламжийг банкны гүйлгээнд оруулсан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наyas хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

289.2. Шүүхийн шийтгэх тогтоолоор хураавал зохих эд хөрөнгийг нуусан буюу завшсан, түүнчлэн өөр байдлаар эд хөрөнгө хураах тухай шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон шийтгэх тогтоолыг биелүүлэхээс зайлсхийсэн бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл гурван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээгээр торгож гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

290 дүгээр зүйл. Хорих газар, баривчлах байр буюу цагдан хорихоос оргох

290.1. Ял эдэлж байгаа буюу урьдчилан хоригдож байгаа этгээд хорих газар, баривчлах буюу урьдчилан хорих байрнаас оргосон бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

290.2. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

290.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийг хүний амь нас буюу эрүүл мэндэд аюултай хүч хэрэглэж, эсхүл ийм хүч хэрэглэхээр айлган сүрдүүлж, түүнчлэн зэвсэг буюу зэвсгийн чанартай ашиглаж болох зүйлийг хэрэглэж үйлдсэн бол найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

291 дүгээр зүйл. Хорих ял эдлэхээс зайлсхийх

291.1. Хорих газраас гадагш гарах зөвшөөрөл авсан хоригдол эргэж ирээгүй бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

292 дугаар зүйл. Шүүхийн шийтгэх тогтоол, шүүхийн шийдвэр буюу шүүхийн бусад актыг эс биелүүлэх

292.1. Засгийн төлөөлөгч, төрийн албан хаагч, нутгийн өөрийн удирдлагын албан хаагч, түүнчлэн төрийн, ашгийн буюу бусад байгууллагын албан хаагч хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийтгэх тогтоол, шүүхийн шийдвэр буюу шүүхийн бусад актыг ноцтой эс биелүүлсэн, түүнчлэн түүнийг биелүүлэхэд саад учруулсан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл таван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл нэг зуун наyas хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

293 дугаар зүйл. Гэмт хэргийг нуун далдлах

293.1. Онц хүнд гэмт хэргийг урьдчилан амлалгүйгээр нуун далдалсан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Нөхөр эхнэр буюу ойрын төрөл төрөгсөд бие биенийхээ үйлдсэн гэмт хэргийг урьдчилан амлалгүйгээр нуун дарагдуулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

ГУЧИН ХОЁРДУГААР БҮЛЭГ. УДИРДЛАГЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

294 дүгээр зүйл. Засгийн төлөөлөгчид хүч хэрэглэх

294.1. Засгийн төлөөлөгч буюу түүний ойрын хүнд албан тушаалын үүргээ биелүүлсэнтэй нь холбогдуулан амь нас буюу эрүүл мэндэд аюулгүй хүч хэрэглэсэн, эсхүл ийм хүч хэрэглэхээр айлгаж сүрдүүлсэн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

294.2. Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан этгээдийн амь нас буюу эрүүл мэндэд аюултай хүч хэрэглэсэн таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Энэ зүйл ба энэхүү Төрөлжсөн хуулийн бусад зүйлд заасан засгийн төлөөлөгч гэж хууль сахиулах буюу хяналт шалгалтын байгууллагын албан тушаалтан, түүнчлэн албан тушаалын байдлаас шалтгаалахгүй этгээдийг хуулиар тогтоосон журмын дагуу захирамжлах бүрэн эрх бүхий бусад албан тушаалтныг үзнэ.

295 дугаар зүйл. Засгийн төлөөлөгчийг доромжлох

295.1. Засгийн төлөөлөгчийг албан тушаалын үүргээ гүйцэтгэх үед нь буюу биелүүлэхтэй нь холбогдуулан нийтийн өмнө доромжилсон бол нэг сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун хориос нэг зуун наян цаг хүртэл албадан ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.

296 дугаар зүйл. Нийгмээс тусгаарлалтыг хангах байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалтыг алдагдуулах

296.1. Ялтныг засан хүмүүжүүлэхэд саад учруулах, ял биелүүлэх байгууллагын захиргаанд үзүүлсэн туслалцаа дэмжлэгээс өс авах зорилгоор ялтны амь нас буюу эрүүл мэндэд аюулгүй хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр айлган сүрдүүлсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

296.2. Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан хэргийг албаны үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан хорих газар буюу цагдан хорих газрын ажилтан, эсхүл түүний ойрын хүний хувьд үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

296.3. Энэ зүйлийн нэг ба хоёр дахь хэсэгт заасан хэргийг зохион байгуулалттай бүлэг, эсхүл хүний амь нас буюу эрүүл мэндэд аюултай хүч хэрэглэж үйлдсэн бол таваас арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

297 дугаар зүйл. Монгол улсын хилийг хууль бусаар нэвтрэх

297.1. Монгол улсад орох буюу Монгол улсаас гарах эрх бүхий хүчин төгөлдөр баримт бичиггүйгээр, эсхүл Монгол улсын хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу олж авсан зохих зөвшөөрөлгүйгээр Монгол улсын хилийг хууль бусаар нэвтэрсэн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

297.2. Урьдчилан тохиролцсон бүлэг, эсхүл зохион байгуулалттай бүлэг, эсхүл хүч хэрэглэж буюу түүнийг хэрэглэхээр айлган сүрдүүлж Монгол улсын хилийг хууль бусаар нэвтэрсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Энэ зүйл нь Монгол улсын Үндсэн хуульд нийцүүлэн улс төрийн орогнох эрхийг ашигласан гадаадын иргэн ба аль ч улсын харъяалалгүй этгээд Монгол улсын хилийг нэвтрэх журмыг зөрчиж, Монгол улсад ирсэн тохиолдолд үйлчлэхгүй.

298 дугаар зүйл. Хууль бус цагаачлалыг зохион байгуулах

298.1. Гадаадын иргэн буюу аль ч улсын харъяалалгүй этгээдийг Монгол улсад хууль бусаар оруулсан, түүнийг Монгол улсад хууль бусаар байлгасан буюу Монгол улсын нутаг дэвсгэрээр хууль бусаар дамжин өнгөрүүлсэн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наян цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

298.2. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, эсхүл Монгол улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдэх зорилгоор үйлдсэн бол хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван

жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

299 дүгээр зүйл. Монгол улсын хилийг хууль бусаар өөрчлөх

299.1. Монгол улсын хилийг хууль бусаар өөрчлөх зорилгоор хилийн тэмдгийг авсан, шилжүүлсэн буюу устгасан бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

299.2. Энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учруулсан бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

300 дугаар зүйл. Албан ёсны баримт бичиг ба төрийн шагналыг олж авах буюу борлуулах

300.1. Эрх олгосон буюу үүргээс чөлөөлсөн албан ёсны баримт бичиг, түүнчлэн Монгол улсын төрийн шагналыг хууль бусаар олж авсан буюу борлуулсан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

301 дүгээр зүйл. Баримт бичиг, тамга, тэмдгийг ашиглан шамшигдуулах буюу гэмтээх

301.1. Албан ёсны баримт бичиг, тамга буюу тэмдгийг шунахай буюу хувийн бусад сонирхлын үүднээс ашиглан шамшигдуулсан, устгасан, гэмтээсэн буюу нуусан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

301.2. Иргэний үнэмлэх буюу хувийн бусад чухал баримт бичгийг ашиглан шамшигдуулсан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

301.3. Онцгой албан татварын тэмдэг, хуурамч үйлдэхээс хамгаалагдсан тусгай тэмдгийг ашиглан шамшигдуулсан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

302 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийн таних дугаарыг хуурамчаар үйлдэх буюу устгах

302.1. Тээврийн хэрэгслийг ашиглах буюу борлуулах зорилгоор таних дугаар, чиргүүл, арал анги, хөдөлгүүрийн дугаарыг хуурамчаар үйлдсэн буюу устгасан, түүнчлэн тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн тэмдгийг хураамчаар үйлдсэн, тэрчлэн илт хуурамч таних дугаар, чиргүүл, арал анги, хөдөлгүүр буюу илт хуурамч улсын бүртгэлийн тэмдэг бүхий тээврийн хэрэгслийг борлуулсан, эсхүл илт хуурамч дугаар бүхий чиргүүл, арал анги, хөдөлгүүрийг борлуулсан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил

хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

302.2. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

303 дугаар зүйл. Баримт бичиг, төрийн шагнал, тамга, тэмдэг, албан хуудсыг хуурамчаар үйлдэх, бэлтгэх буюу борлуулах

303.1. Үнэмлэх буюу эрх олгосон буюу үүргээс чөлөөлсөн албан ёсны бусад баримт бичгийг ашиглах, эсхүл борлуулах зорилгоор хуурамчаар үйлдсэн, түүнчлэн хуурамч Монгол улсын төрийн шагнал, тамга, тэмдэг, албан хуудсыг энэ зорилгоор бэлтгэсэн буюу борлуулсан бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

303.2. Энэ хэргийг өөр гэмт хэргийг нуух буюу түүнийг үйлдэхийг хөнгөвчлөх зорилгоор үйлдсэн бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

303.3. Илт хуурамч баримт бичиг ашигласан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наyas хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

304 дүгээр зүйл. Цэргийн алба хаахаас зайлсхийх

304.1. Цэргийн алба хаахаас чөлөөлөгдөх хууль ёсны үндэслэл байхгүй байхад цэргийн албаны татлагаас зайлсхийсэн бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

305 дугаар зүйл. Монгол улсын төрийн сүлд буюу далбааг гутаах

305.1. Монгол улсын төрийн сүлд буюу Монгол улсын төрийн далбааг гутаасан бол хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

306 дугаар зүйл. Дураараа аашлах

306.1. Хууль ёсны эсэх талаар иргэн буюу байгууллагатай маргаж байгаа ямар нэгэн үйлдлийг хууль буюу хэм хэмжээ тогтоосон бусад актад тогтоосон журамд харш байдлаар дураараа хэрэгжүүлсэний улмаас ноцтой гэм хор учруулсан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэг зуун наyas хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

306.2. Энэ хэргийг хүч хэрэглэж буюу түүнийг хэрэглэхээр айлган сүрдүүлж үйлдсэн бол гурван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

XI ХЭСЭГ. ЦЭРГИЙН АЛБАНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

ГУЧИН ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЦЭРГИЙН АЛБАНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

307 дугаар зүйл. Цэргийн албаны эсрэг гэмт хэргийн ухагдахуун

307.1. Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг гэж Монгол улсын иргэн зэвсэгт хүчин, бусад цэрэгт, цэргийн үүрэгтэн дайчилгаа, сургууль, цугларалтын үед цэргийн алба хаах талаар хуулиар тогтоосон журмыг зөрчиж энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдсэнийг үзнэ.

307.2. Дайны үед эсхүл дайн бүхий байдалд цэргийн алба хаах журмын эсрэг гэмт хэрэг үйлдсэнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг дайны үеийн Монгол улсын хууль тогтоомжоор тодорхойлно.

308 дугаар зүйл. Тушаал эс биелүүлэх

308.1. Тогтоосон журмын дагуу өгсөн захирагчийн тушаалыг захирагдагч эс биелүүлсэний улмаас ноцтой гэм хор учруулсан бол хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн алба хаах хугацааг хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн сахилгажуулах ангид явуулах ял шийтгэнэ.

308.2. Энэ хэргийг бүлэг этгээд, урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг үйлдсэн, түүнчлэн хүнд хор уршиг учруулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

308.3. Тушаалыг хайхрамжгүйгээр эс биелүүлсэн, эсхүл албандаа цалгар назгай хандсаны улмаас хүнд хор уршиг учруулсан бол нэг жил хүртэл хугацаагаар цэргийн алба хаах хугацааг хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн сахилгажуулах ангид явуулах ял шийтгэнэ.

309 дүгээр зүйл. Захирагчаа эсэргүүцэх буюу албадах

309.1. Захирагч, түүнчлэн өөрт нь хүлээлгэсэн цэргийн алба хаах үүрэг гүйцэтгэж буй бусад этгээдийг эсэргүүцсэн, эсхүл энэ үүргийг нь зөрчүүлэхээр хүч хэрэглэж буюу түүнийг хэрэглэхээр айлган сүрдүүлж албадсан бол хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн алба хаах хугацааг хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн сахилгажуулах ангид явуулах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

309.2. Энэ хэргийг бүлэг этгээд, урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг, эсхүл зэвсэг хэрэглэж, эсхүл хүний эрүүл мэндэд хүнд буюу хүндэвтэр гэм хор, эсхүл бусад хүнд хор уршиг учруулж үйлдсэн бол гурваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

310 дугаар зүйл. Захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх

310.1. Цэргийн алба хаах үүрэг гүйцэтгэх үед нь буюу энэ үүргийг гүйцэтгэхтэй нь холбогдуулан захирагч нь зодсон буюу өөр хүч хэрэглэсэн бол хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн алба хаах хугацааг хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн сахилгажуулах ангид явуулах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

310.2. Энэ хэргийг бүлэг этгээд, урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг, эсхүл зэвсэг хэрэглэж, эсхүл хүний эрүүл мэндэд хүнд буюу хүндэвтэр гэм хор, эсхүл бусад хүнд хор уршиг учруулж үйлдсэн бол гурваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

311 дүгээр зүйл. Захирах захирагдах харилцаагүй цэргийн албан хаагч харилцахдаа дүрмийн заалт зөрчих

311.1. Бие биедээ захирах захирагдахгүй цэргийн албан хаагч хоорондын харилцаанд дүрмийн заалт зөрчиж, хохирогчийн нэр төр ба алдар хүндийг гутаасан буюу тохуурхан даажигнасан, эсхүл хүч хэрэглэсэн бол хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн сахилгажуулах ангид явуулах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

311.2. Энэ хэргийг хоёр буюу түүнээс дээш хүний хувьд, эсхүл бүлэг этгээд, урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг, эсхүл зэвсэг хэрэглэж, эсхүл хүний эрүүл мэндэд хүндэвтэр гэм хор учруулж үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

311.3. Энэ зүйлийн нэг буюу хоёр дахь хэсэгт заасан хэргийн улмаас хүнд хор уршиг учруулсан бол арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

312 дугаар зүйл. Албаны анги буюу газраа дур мэдэн орхих

312.1. Цэргийн албан хаагч цэргийн анги буюу алба хаах газраа дур мэдэн орхисон, хүндэтгэх шалтгаангүйгээр томилогдсон, шилжүүлсэн газар, томилолтын, амралтын хугацаа өнгөрснөөс хойш буюу эмчилгээний байгууллагаас хоёр хоногоос дээш арваас илүүгүй хоногоор хугацаандаа ирээгүй бол нэг жил хүртэл хугацаагаар цэргийн сахилгажуулах ангид явуулах ял шийтгэнэ.

312.2. Энэ хэргийг цэргийн сахилгажуулах ангид ял эдэлж байгаа цэргийн албан хаагч үйлдсэн бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

312.3. Дайчилгааны буюу гэрээт цэргийн алба хаагч арав хүртэл хоног тэгэхдээ нэг сараас хэтрэхгүйгээр цэргийн анги буюу алба хаах газраа дур мэдэн орхисон, хүндэтгэх шалтгаангүйгээр хугацаандаа албандаа ирээгүй бол хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн алба хаах хугацааг хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн сахилгажуулах ангид явуулах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

312.4. Энэ зүйлийн гурав дахь хэсэгт заасан хэргийг нэг сараас дээш хугацаатай үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Энэ зүйлд заасан хэргийг анх удаа үйлдсэн цэргийн албан хаагч хүнд нөхцөл байдал тохиолдсоны улмаас ангиа дураараа орхисон бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

313 дугаар зүйл. Цэргийн албанаас оргох

313.1. Цэргийн алба хаахаас зайлсхийсэн, түүнчлэн энэ зорилгоор алба хаах анги буюу газрыг дур мэдэн орхисон бол долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

313.2. Албаны зэвсэгтэй оргосон, түүнчлэн урьдчилан тохиролцсон бүлэг буюу зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол гурваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан цэргийн албанаас оргох хэргийг анх удаа үйлдсэн цэргийн албан хаагч хүнд нөхцөл байдал тохиолдсоны улмаас үйлдсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

314 дүгээр зүйл. Худал өвчлөх буюу бусад аргаар цэргийн албаны үүргээ гүйцэтгэхээс зайлсхийх

314.1. Цэргийн албан хаагч худал өвчлөх буюу биедээ ямар нэгэн гэмтэл учруулах буюу хуурамч баримт бичиг үйлдэх буюу бусад байдлаар хууран мэхлэх замаар цэргийн алба хаах үүрэг гүйцэтгэхээс зайлсхийсэн бол нэг жил хүртэл хугацаагаар цэргийн албан хаах хугацааг хязгаарлах, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар цэргийн сахилгажуулах ангид явуулах ял шийтгэнэ.

314.2. Энэ хэргийг цэргийн алба хаах үүрэг гүйцэтгэхээс бүрэн чөлөөлөгдөх зорилгоор үйлдсэн бол долоон хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

315 дугаар зүйл. Байлдааны жижүүрийн алба хаах журам зөрчих

315.1. Монгол улсад гэнэт халдсан довтолгоог цаг тухайд нь илрүүлэх ба цохилт өгөх, эсхүл түүний аюулгүй байдлыг хангах байлдааны жижүүрийн журам зөрчсөний улмаас улсын аюулгүй байдлын ашиг сонирхолд гэм хор учруулсан буюу учруулж болох байсан бол хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн албан хаах хугацааг хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн сахилгажуулах ангид явуулах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

315.2. Энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учруулсан бол арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

315.3. Хайхрамжгүй буюу цалгар назгай хандаж, байлдааны жижүүрийн алба хаах журам зөрчсөний улмаас хүнд хор уршиг учруулсан бол хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн албан хаах хугацааг хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн сахилгажуулах ангид явуулах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

316 дугаар зүйл. Хилийн алба хаах журам зөрчих

316.1. Хилийн жижүүрийн бүрэлдэхүүнд орсон буюу хилийн албаны үүрэг гүйцэтгэж байгаа бусад этгээд хилийн алба хаах журам зөрчсөний улмаас улсын аюулгүй байдлын ашиг сонирхолд гэм хор учруулсан буюу учруулж болох байсан бол хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн албан хаах хугацааг хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн сахилгажуулах ангид явуулах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

316.2. Энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учруулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

316.3. Хайхрамжгүй буюу налгар назгай хандаж, хилийн алба хаах журам зөрчсөний улмаас хүнд хор уршиг учруулсан бол хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн албан хаах хугацааг хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн сахилгажуулах ангид явуулах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

317 дугаар зүйл. Харуулын албаны дүрмийн журам зөрчих

317.1. Харуулын албаны бүрэлдэхүүнд орсон этгээд харуулын алба хаах журам зөрчсөний улмаас хамгаалах объектод гэм хор учруулсан бол хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн албан хаах хугацааг хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн сахилгажуулах ангид явуулах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

317.2. Энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учруулсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

317.3. Хайхрамжгүй буюу цалгар назгай хандаж, харуулын алба хаах журам зөрчсөний улмаас хүнд хор уршиг учруулсан бол нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

318 дугаар зүйл. Нийгмийн хэв журам хамгаалах ба нийгмийн аюулгүй байдлыг хангах алба хаах журам зөрчих

318.1. Нийгмийн хэв журам хамгаалах ба нийгмийн аюулгүй байдлыг хангах цэргийн жижүүрийн бүрэлдэхүүнд орсон этгээд алба хаах журам зөрчсөний улмаас иргэдийн эрх ба хууль ёсны ашиг сонирхолд гэм хор учруулсан бол хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн албан хаах хугацааг хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн сахилгажуулах ангид явуулах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

318.2. Энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учруулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

319 дүгээр зүйл. Дотоодын алба хаах дүрмийн журам зөрчих

319.1. Ангийн хоногийн жижүүр (харуулаас бусад) дотоод албаны дүрмийн журам зөрчсөн, түүнчлэн харуулын жижүүрийн бүрэлдэхүүнд багтсан этгээд гарнизоны харуулын дүрмийн журам зөрчсөний улмаас хүнд хор уршиг учруулсан бол хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн албан хаах хугацааг хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн сахилгажуулах ангид явуулах ял шийтгэнэ.

320 дүгээр зүйл. Цэргийн эд хөрөнгийг санаатай устгах буюу гэмтээх

320.1. Зэвсэг, байлдааны галт хэрэгсэл буюу цэргийн техникийн зүйлийг санаатай устгасан буюу гэмтээсэн бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн албан хаах хугацааг хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн сахилгажуулах ангид явуулах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

320.2. Энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учруулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

321 дүгээр зүйл. Цэргийн эд хөрөнгийг болгоомжгүй устгах буюу гэмтээх

321.1. Зэвсэг, байлдааны галт хэрэгсэл буюу цэргийн техникийн зүйлийг болгоомжгүй устгасан буюу гэмтээсний улмаас хүнд хор уршиг учруулсан бол зургаан сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны арван найман сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн албан хаах хугацааг хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн сахилгажуулах ангид явуулах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

322 дугаар зүйл. Цэргийн эд хөрөнгийг үгүй болгох

322.1. Албан ажлын журмаар ашиглуулахаар өөрт нь хариуцуулсан зэвсэг, байлдааны галт хэрэгсэл буюу цэргийн техникийн зүйлийг байлгах журам зөрчсөний улмаас хүнд хор уршиг учруулсан бол хоёр сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны зургаан сар хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн албан хаах хугацааг хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн сахилгажуулах ангид явуулах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

323 дугаар зүйл. Хүрээлэн буй орчинд нэн аюултай зэвсэг ба зүйлтэй харьцах журам зөрчих

323.1. Орчин тойрондоо нэн аюултай зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, радиоидэвхт материал, тэсэрч дэлбэрэх буюу бусад бодис ба зүйлтэй харьцах журам зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүнд гэм хор болгоомжгүй учруулсан, цэргийн техник устгасан, эсхүл өөр хүнд хор уршиг учруулсан бол хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн албан хаах хугацааг хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар цэргийн сахилгажуулах ангид явуулах ял шийтгэнэ.

323.2. Энэ хэргийн улмаас хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

323.3. Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан хэргийн улмаас хоёр буюу түүнээс дээш хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

324 дүгээр зүйл. Машин жолоодох буюу ашиглах журам зөрчих

324.1. Байлдааны, тусгай зориулалтын буюу тээврийн машин жолоодох буюу ашиглах журам зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүнд гэм хор болгоомжгүй учруулсан бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах буюу хасахгүйгээр хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

324.2. Энэ хэргийн улмаас хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах буюу хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

324.3. Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан хэргийн улмаас хоёр буюу түүнээс дээш хүний амь насыг болгоомжгүй бусниулсан бол долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

325 дугаар зүйл. Нислэгийн буюу түүнд бэлтгэх журам зөрчих

325.1. Нислэг буюу түүнд бэлтгэх журам, эсхүл цэргийн нисэх аппаратыг ашиглах бусад журам зөрчсөний улмаас хүний амь нас болгоомжгүй бусниулсан, эсхүл өөр хүнд хор уршиг учруулсан бол долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

XII ХЭСЭГ. ЭНХ ТАЙВАН БА ХҮН ТӨРӨЛХТНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

ГУЧИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЭНХ ТАЙВАН БА ХҮН ТӨРӨЛХТНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

326 дугаар зүйл. Түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх буюу дэгдээх

326.1. Түрэмгий дайныг төвлөсөн, бэлтгэсэн буюу өдөөсөн бол долоогоос арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

326.2. Түрэмгий дайн дэгдээсэн бол арваас хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

327 дугаар зүйл. Түрэмгий дайн өдөөхийг нийтэд уриалах

327.1. Түрэмгий дайн өдөөхийг нийтэд уриалсан бол арван сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны хоёр жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл нэгээс гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

327.2. Энэ хэргийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглаж, эсхүл Монгол улсын төрийн албан тушаалтан үйлдсэн бол таваас хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасаж таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

328 дугаар зүйл. Үй олноор хөнөөх зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, хуримтлуулах, олж авах буюу борлуулах

328.1. Монгол улсын олон улсын гэрээгээр хориглосон химийн, биологийн, түүнчлэн үй олноор устгах бусад төрлийн зэвсгийг боловсруулсан, үйлдвэрлэсэн, хуримтлуулсан, олж авсан буюу борлуулсан бол таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

329 дүгээр зүйл. Дайны хориглосон хэрэгсэл ба арга хэрэглэх

329.1. Дайны олзлогдогч буюу энгийн хүн амтай харгис хэрцгий харьцсан буюу энгийн хүн амыг албадан гаргасан, эзлэгдсэн нутаг дэвсгэр дэх үндэсний эд хөрөнгийг тоносон, Монгол улсын олон улсын гэрээгээр хориглосон дайны хэрэгсэл ба арга хэрэглэсэн бол хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

329.2. Монгол улсын олон улсын гэрээгээр хориглосон үй олноор устгах зэвсэг хэрэглэсэн бол арваас хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

330 дугаар зүйл. Төрлөөр устгах

330.1. Үндэстэн, угсаатан, арьсны өнгө буюу шашны бүлгийн гишүүдийг алсан, тэдгээрийн эрүүл мэндэд хүнд гэм хор учруулсан, хүүхэд төрүүлэхэд хүч хэрэглэн саад учруулсан, хүч хэрэглэн нүүлгэн шилжүүлсэн, эсхүл энэ бүлгийн гишүүдийг бие махбодийн хувьд устгахаар тооцоолсон амьдралын бусад нөхцлийг буй болгосон нь энэ бүлгийн гишүүдийг бүрэн буюу хэсэгчлэн устгахад чиглэгдсэн үйлдэл бол арван хоёроос хорин жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ.

331 дүгээр зүйл. Байгалийн тэнцэл алдагдуулах

331.1. Ургамлын төрөл зүйл буюу амьтны аймгийг үй олноор нь устгасан, агаарын буюу усны нөөцийг хордуулсан, түүнчлэн экологийн сүйрэлд хүргэж болохуйц бусад үйлдэл үйлдсэн бол арван хоёроос хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

332 дугаар зүйл. Цэрэг хөлслөлт

332.1. Хөлсний цэрэг элсүүлсэн, сургаж бэлтгэсэн, санхүүжүүлсэн буюу материалын бусад хангалт хийсэн, түүнчлэн зэвсэгт мөргөлдөөн буюу байлдааны ажиллагаанд ашигласан бол дөрвөөс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

332.2. Энэ хэргийг албан тушаалынхаа байдлыг ашиглаж, эсхүл зориуд насанд хүрээгүй хүний хувьд үйлдсэн этгээдийг хорин сая төгрөг хүртэл хэмжээтэй буюу ялтны гурван жил хүртэл хугацааны үеийн цалин хөлс буюу бусад орлогын хэмжээний торгууль, эсхүл торгуульгүйгээр долоогоос арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

332.3. Зэвсэгт мөргөлдөөн буюу дайны ажиллагаанд хөлсний цэргээр оролцсон бол гурваас долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар. Хөлсний цэрэг гэж мөнгө, эд хөрөнгийн шан харамж авах зорилгоор ажиллаж байгаа ба зэвсэгт мөргөлдөөн буюу байлдааны ажиллагаанд оролцож буй улсын иргэн бус, тухайн улсын нутаг дэвсгэрт байнга оршин амьдардаггүй этгээд, түүнчлэн албан ёсны үүрэг гүйцэтгээгүй этгээдийг үзнэ.

333 дүгээр зүйл. Олон улсын хамгаалалт бүхий этгээд буюу байгууллага руу довтлох

333.1. Олон улсын хамгаалалт бүхий гадаад улсын төлөөлөгч буюу олон улсын байгууллагын ажилтан, түүнчлэн олон улсын хамгаалалт бүхий албаны буюу орон сууцны байр, эсхүл тээврийн хэрэгсэл рүү довтолсон бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

333.2. Энэ хэргийг дайн өдөөх буюу олон улсын харилцааг хүндрүүлэх зорилгоор үйлдсэн бол гурваас долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ

ХУРЛЫН ДАРГА